



Save the Children

**“ОХИДЫГ ХҮЧИРХИЙЛЭЛ, МӨЛЖЛӨГӨӨС  
ХАМГААЛАХ НЬ” ТӨСЛИЙН СУУРЬ  
СУДАЛГААНЫ ТАЙЛАН**



**“ОХИДЫГ ХҮЧИРХИЙЛЭЛ, МӨЛЖЛӨГӨӨС  
ХАМГААЛАХ НЬ” ТӨСЛИЙН СУУРЬ  
СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

Хүүхдийг Ивээх Сан нь дэлхийн 120 улсад хүүхдийн эрхийн чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллага юм. Монгол Улсад 1994 онд салбараа нээсэн ба Хүүхэд хамгаалал, Хүүхдийн эрхийн засаглал, Боловсрол, Хүүхдийн ядуурлыг бууруулах, Хүмүүнлэг, Эрүүл мэндийн хөтөлбөрүүдийн хүрээнд хүүхдийн амьдралд эрчимтэй, тогтвортой өөрчлөлт хийхийн төлөө ажиллаж байна.

Боловсруулсан: IRIM Хараат бус судалгааны хүрээлэн

Хянан тохиолдуулсан: Энхбатын Цолмон  
Энхболдын Жаргал  
Баяндалайн Баярмаа  
Нямсүрэнгийн Онон

Хэвлэлийн эхийг бэлтгэсэн: Хорлоогийн Балдандорж

НҮБ-ын “Итгэлцлийн сан”-гийн санхүүжилттэй “Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төслийн хүрээнд боловсруулав.

Хүүхдийг Ивээх Сангийн Монгол Улс дахь хөтөлбөрийн газар | Төв шуудангийн хайрцаг 1023, Улаанбаатар-13, Монгол улс | Утас: +976-11-329371, 329365 | Факс: +976-11-329361 | Цахим шуудан: [Mongolia.secretary@savethechildren.org](mailto:Mongolia.secretary@savethechildren.org) | Судалгааны тайланг цахим хэлбэрээр [www.savethechildren.mn](http://www.savethechildren.mn) вэб хуудаснаас авах боломжтой.

Улаанбаатар хот, Монгол Улс, 2022 он

## АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар . . . . .	4
Хүснэгт, дүрсийн жагсаалт . . . . .	5
Өмнөх үг . . . . .	8
Нэр томьёо, ойлголтын хүрээ. . . . .	10
Хураангуй. . . . .	11
1. Суурь судалгааны арга зүй . . . . .	15
1.1. Судалгааны зорилго ба хамрах хүрээ . . . . .	15
1.2. Судалгааны арга зүй. . . . .	15
1.2.1. Арга зүй . . . . .	15
1.2.2. Судалгааны түүвэр . . . . .	16
1.2.3. Мэдээлэл цуглуулалт. . . . .	18
1.2.4. Мэдээллийн чанарын хяналт . . . . .	18
1.3. Судалгааны хязгаарлагдмал тал . . . . .	19
1.4. Судалгаанд оролцогчдын ерөнхий шинж . . . . .	19
2. Судалгааны үр дүн. . . . .	21
2.1. Хүүхэд хамгааллын үйлчилгээний эрх зүйн орчин, тулгамдаж буй асуудал . . . . .	21
2.2. Хүүхэд хамгаалал, бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн талаарх сурагчдын ойлголт, мэдлэг . . . . .	31
2.2.1. Хүүхэд хамгааллын талаарх ойлголт, мэдлэг. . . . .	31
2.2.2. Охидын бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн талаарх ойлголт мэдлэг, тусламж эрэлхийлэх зан үйл . . . . .	37
2.3. Хүүхэд хамгааллын үйлчилгээ, чанар хүртээмж . . . . .	46
2.3.1. Хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны өнөөгийн нөхцөл байдал, чанар, хүртээмж . . . . .	46
2.3.2. Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдал, чанар, хүртээмж . . . . .	59
2.4. Сурагчдын аюулгүй байдалд үзүүлэх КОВИД-19 цар тахлын нөлөө. . . . .	78
Нэгдсэн дүгнэлт. . . . .	85
Санал зөвлөмж . . . . .	90
Хавсралт 1. Хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэх хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх журмын харьцуулалт . . . . .	92
Хавсралт 2. Хууль тогтоомжийг даган гарсан журмуудыг жагсаалт. . . . .	94
Хавсралт 3. Тоон судалгаанд хамрагдсан сургууль тус бүрээр гарсан үр дүн . . . . .	95

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

---

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
ББШ	Баримт бичгийн шинжилгээ
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ГБХТtХ	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
ГМЯ	Голлох мэргэжилтний ярилцлага
ГССҮТ	Гэмтэл согог судлалын үндэсний төв
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЖСХ	Жендэрт суурилсан хүчирхийлэл
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
КС	Кейс судалгаа
НА	Нийгмийн ажилтан
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НҮБИС	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Итгэлцлийн Сан
НЦҮТ	Нэг цэгийн үйлчилгээний төв
ОУБ	Олон улсын байгууллага
ТБ	Төрийн байгууллага
ТББ	Төрийн бус байгууллага
ТХБ	Түр хамгаалах байр
ФБЯ	Фокус бүлгийн ярилцлага
ХБЯ	Хагас бүтэцлэгдсэн ярилцлага
ХЭҮТ	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв
ЭХЭМТ	Эх хүүхдийн эрүүл мэндийн төв
ШУТИС	Шинжлэх ухаан технологийн их сургууль
ХИС	Японы Хүүхдийг Ивээх Сан
IRIM	Хараат бус судалгааны хүрээлэн

## ХҮСНЭГТ, ДҮРСИЙН ЖАГСААЛТ

### Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1.	Төслийн суурь үзүүлэлтүүд. . . . .	11
Хүснэгт 2.	Түүврийн хэмжээ. . . . .	16
Хүснэгт 3.	Зорилтот 15 сургууль ба сургууль тус бүрийн түүврийн хэмжээ . . . . .	17
Хүснэгт 4.	Чанарын судалгааны оролцогчид. . . . .	17
Хүснэгт 5.	Тоон мэдээлэл цуглуулалтын арга болон чанарын хяналтын төрөл . . . . .	19
Хүснэгт 6.	Хүүхэд хамгааллын үйлчилгээний эрх зүйн орчин. . . . .	25
Хүснэгт 7.	Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний тухай зүйл заалт. . . . .	27
Хүснэгт 8.	Үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн тоо, 2020 оны 10 сарын байдлаар. . . . .	29
Хүснэгт 9.	Хүүхэд хамгаалах ёстой хүн мөн гэж үзсэн охидын хариулт, n=620 . . . . .	33
Хүснэгт 10.	Аюултай, эрсдэлтэй байдалд орвол өөрийгөө хэрхэн хамгаалах талаар хаанаас мэдээлэл, заавар, зөвлөгөө авдаг мэдээллийн эх сурвалж. . . . .	34
Хүснэгт 11.	Аюултай нөхцөл байдлаас өөрийгөө хэрхэн хамгаалах талаар мэдлэгээ үнэлсэн охидын өөрийн үнэлгээ, n=664 . . . . .	34
Хүснэгт 12.	Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн талаар мэдээлэл авдаг эх сурвалж, n=480 . . . . .	38
Хүснэгт 13.	Гэр бүлийн орчинд бэлгийн хүчирхийлэл, мөлжлөг, дарамт шахалт тохиолдох эрсдэлээ үнэлсэн охидын тоо, насны ангиллаар, n=664 . . . . .	40
Хүснэгт 14.	Асран хамгаалагчтай хамт амьдардаг эсэх байдлаас хамаарч гэр бүлийн орчинд бэлгийн хүчирхийлэл, мөлжлөг, дарамт шахалт тохиолдох эрсдэлээ үнэлсэн охидын тоо, n=664 . . . . .	40
Хүснэгт 15.	Найз охин, хамаатан садны хэн нэгэн бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн тохиолдолд охидын хандах хүн, байгууллага, n=664 . . . . .	41
Хүснэгт 16.	Охид бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртөх магадлал үүсгэдэг шалтгааныг үнэлсэн охидын тоо, n=664 . . . . .	43
Хүснэгт 17.	Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чанарыг сайн гэж үзсэн дундаж хувь, оролцогч талуудаар. . . . .	47
Хүснэгт 18.	Хамтарсан багийн урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах ур чадварын үнэлгээ, хувиар . . . . .	51
Хүснэгт 19.	Сургуулийн удирдлага, нийгмийн ажилтнуудын урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах ур чадварын үнэлгээ, хувиар . . . . .	52
Хүснэгт 20.	Хамтарсан багийн кейс бүртгэл. . . . .	62
Хүснэгт 21.	Хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын хүний нөөц, чадавх . . . . .	71
Хүснэгт 22.	Хохирогч/даван туулагчдад нэн шаардлагатай үйлчилгээ . . . . .	75
Хүснэгт 23.	Чанарын судалгаанд хамрагдсан үйлчилгээ үзүүлэгч төрийн болон төрийн бус байгууллагын мэргэжилтнүүдээс гарсан санал . . . . .	76
Хүснэгт 24.	2016 болон 2021 оны Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх магадлан итгэмжлэх журмын харьцуулалт . . . . .	92
Хүснэгт 25.	Хүүхэд бусдаар хамгаалуулах шаардлагатай эсэх талаар охидын ойлголт . . . . .	95

## Дүрсийн жагсаалт

Дүрс 1.	Суурь судалгааны үйл явц . . . . .	16
Дүрс 2.	Суурь судалгааны бүрэлдэхүүн хэсгүүд . . . . .	18
Дүрс 3.	Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл . . . . .	20
Дүрс 4.	Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо . . . . .	23
Дүрс 5.	Хүүхэд бусдаар хамгаалуулах шаардлагатай эсэх талаарх охидын үзэл бодлын ялгаа, (n=664) . . . . .	32
Дүрс 6.	Хүүхдийн эрх зөрчигдөх, аюулгүй байдалд нөлөөлөх эрсдэлтэй зүйл тохиолдоход хамгийн түрүүнд хандаж, тусламж хүсэх субъект, n=664 . . . . .	36
Дүрс 7.	Хүүхэд хэн нэгнээр хамгаалуулахдаа чухалчлах зарчим, n=664 . . . . .	37
Дүрс 8.	Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн талаар мэддэг охидын эзлэх хувь, n=664 . . . . .	38
Дүрс 9.	Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн талаар мэдээлэл авдаг эх сурвалжийн тоо, n=480 . . . . .	39
Дүрс 10.	Ойр дотнын найз, эгч, ах, дүү, хамаатан садан, танилууд дунд бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртөж байсан/өртөх дөхөж байсан гэж хариулсан охидын тоо, n=664 . . . . .	40
Дүрс 11.	Охидын эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөг үйлдэгдэх магадлал өндөр орчин гэж үнэлсэн охидын тоо, дүүргээр, n=664 . . . . .	42
Дүрс 12.	Охид бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн үедээ хэн нэгнээс тусламж авч, хамгаалуулж чаддаггүй байх магадлалтай гэж үзсэн охидын эзлэх хувь. . . . .	44
Дүрс 13.	Охид бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн үедээ тусламж авч чаддаггүй шалтгааны талаар охидын үнэлгээ . . . . .	44
Дүрс 14.	Сэтгэцийн гэмтэлд суурилсан, хохирогч төвтэй арга зүйн талаарх мэдлэг . . . . .	53
Дүрс 15.	Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэргийн хохирогч/даван туулагчдад үзүүлж буй хариу үйлчилгээ . . . . .	61
Дүрс 16.	Хохирогч/даван туулагчдыг дэмжиж тусламж үзүүлдэг хүн/байгууллага . . . . .	61
Дүрс 17.	Холбон зуучлах үйлчилгээний төрөл . . . . .	66
Дүрс 18.	Хариу үйлчилгээний оролцогчид . . . . .	69
Дүрс 19.	Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэрэгт өртсөн хохирогч/даван туулагчдад үзүүлж буй хариу үйлчилгээний зураглал . . . . .	70
Дүрс 20.	КОВИД-19 цар тахлын дараах гэр бүлийн уур амьсгал . . . . .	78
Дүрс 21.	КОВИД-19 цар тахлын өмнө болон үед гэр бүлд тулгарсан бэрхшээлүүдийн төрөл, хувиар . . . . .	79
Дүрс 22.	КОВИД-19 цар тахлын үед үүдэж, гэр бүлийн орчин дох эрсдэлүүдэд гарсан өөрчлөлтүүд, хувиар . . . . .	79
Дүрс 23.	Сургууль, амьдарч буй орчин болон цахим орчинд аюул, эрсдэл үүссэн эсэх, хувиар . . . . .	81
Дүрс 24.	КОВИД-19 цар тахлын улмаас хамгийн ихээр эрсдэл нэмэгдсэн орчин, хувиар . . . . .	83
Дүрс 25.	КОВИД-19 цар тахлын улмаас аюулгүй байдалд эрсдэл үүссэн охидын хандаж тусламж, үйлчилгээ хүссэн хүн эсвэл байгууллага, хувиар . . . . .	84
Дүрс 26.	Үйлчилгээ авсан байгууллагат үзүүлэх сэтгэл ханамжийн үнэлгээ, хувиар. . . . .	84
Дүрс 27.	Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт ямар үйлдлийг оруулдгийг зөв мэддэг охидын эзлэх хувь . . . . .	96
Дүрс 28.	Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртөж байсан гэх хариултыг өгсөн оролцогчид, сургуулиар. . . . .	96

## Матрицын жагсаалт

Матриц 1.	Хамтарсан багийн охидын эсрэг бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгт өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд (n=10). . . . .	48
Матриц 2.	Ерөнхий боловсролын сургуулиудад охидыг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд (n=18). . . . .	50
Матриц 3.	Мэргэжил арга зүйн зөвлөгөөг авч буй байгууллага. . . . .	53
Матриц 4.	Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулахад тулгарч буй бэрхшээл . . . . .	54
Матриц 5.	Хувь хүний түвшинд нөлөөлж буй хүчин зүйлүүд . . . . .	56
Матриц 6.	Гэр бүлийн түвшинд нөлөөлж буй хүчин зүйлүүд . . . . .	56
Матриц 7.	Олон нийтийн түвшинд нөлөөлж буй хүчин зүйлүүд . . . . .	58
Матриц 8.	Үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын үйлчилгээний төрлийн харьцуулалт. . . .	60
Матриц 9.	Төрийн болон төрийн бус байгууллагын харьцуулалт. . . . .	74



## ӨМНӨХ ҮГ

---

Хүүхдийг Ивээх Сан (ХИС) нь хүүхдийн эрхийг хүндэтгэн хангах, хэрэгжүүлэх замыг боловсронгуй болгох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, ашгийн бус, шашны бус, олон улсын, бие даасан, хараат бус иргэний нийгмийн байгууллага юм. ХИС-гийн Хүүхэд хамгааллын хөтөлбөр нь 2021 оноос “Охидыг хүчирхийлэл мөлжлөгөөс хамгаалах нь” төслийг НҮБ-ын Итгэлцлийн сангийн санхүүжилтээр нийслэлийн Баянгол, Чингэлтэй, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүрэгт 3 жилийн хугацаатай хэрэгжүүлж байна.

Охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, ялгаварлан гадуурхлын бүх хэлбэрийг устгахад чиглэсэн цогц, олон талын оролцоог хангасан, уялдаа холбоо бүхий үндэсний төлөвлөгөө, хөтөлбөр, стратеги боловсруулах эсвэл байгаагаа хянан үзэж сайжруулах, тэдгээр төлөвлөгөө, хөтөлбөр, стратегийг хэрэгжүүлэх хангалттай нөөцийг бүрдүүлэх, түүнийг оновчтой хуваарилах, зорилтот бүлгийг тодорхойлох, хэрэгжүүлэх цаг хугацааны төлөвлөгөө гаргах, түүнчлэн холбогдох бүхий л талыг оролцуулсан хяналт, үнэлгээний механизмыг бүрдүүлэх замаар тэдгээрийн үр дүнтэй хэрэгжилтийг хангах, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, түүний учир шалтгаан, үр дагавар, хүн худалдаалах явдал, нэн ялангуяа охид, хүүхдүүдийг худалдаалахтай холбоотой Хүний эрхийн хорооны тусгай элч, хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх Ерөнхий нарийн бичгийн даргын тусгай төлөөлөгчийн охин хүүхэдтэй хамааруулан гаргасан санал зөвлөмжийг анхааралдаа авахыг НҮБ-ын бүх гишүүн орнуудад сануулан 2015 онд Охин хүүхдийн асуудлаар А/70/485 тоот шийдвэрийг гаргасан байдаг.

Монгол Улсын нэгдэн орсон олон улсын хүний эрхийн гэрээ, НҮБ-ын хороодын дүгнэлт зөвлөмжүүдэд охин хүүхдийг бэлгийн болон бусад төрлийн мөлжлөгөөс хамгаалж, хүчирхийллийн аливаа хэлбэрээс охидыг хамгаалах, нэр төрийг нь хүндэтгэхийг эрхэмлэх ёстойг онцлон тэмдэглэдэг.

Монгол Улсад хүчирхийлэлтэй тэмцэхэд тодорхой ахиц, өөрчлөлт гарч байгаа хэдий ч жендэрт суурилсан хүчирхийлэл, охидын эсрэг хүчирхийллийн тоо буурахгүй хэвээр байгаад зовниж, Хүүхдийг Ивээх Сан охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс эрүүл мэнд, хүүхэд хамгаалал, боловсролын үйлчилгээгээр дамжуулан хамгаалах зорилго тавин ажиллаж байна. Мөн жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр салбар, байгууллага хоорондын уялдаа холбоог бэхжүүлэх, үүнд боловсролын байгууллагуудыг татан оролцуулах, хүүхдийн оролцоог дэмжих, жендэрт суурилсан хүчирхийллийн мэдээлэл цуглуулах ажлыг сайжруулахад дэмжлэг үзүүлэхээр ажиллаж байна.

Олны хүч оломгүй далай гэдэг ээ. Энэ чиглэлээр бидний нэгэн адил Монгол Улсын Засгийн газартай хамтран ажиллаж байгаа зорилго нэгт хөгжлийн болон хүмүүнлэгийн бүх түншүүддээ талархал илэрхийлье.

“Охидыг хүчирхийлэл мөлжлөгөөс хамгаалах нь” төслийн энэхүү суурь судалгаагаар зорилтот дүүрэг тус бүрийн холбогдох тоон болон чанарын судалгааны мэдээллээр төслийн зорилгын шалгуур үзүүлэлтүүдийг хэмжиж, зорилтот 5 дүүргийн төр, ИНБ-ын ажилтнууд хохирогч төвтэй, гэмтлийн дараах сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх аргачлалыг ашиглан гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод тусламж,

үйлчилгээ үзүүлэх чадварыг тодруулан ба сургуулийн удирдлага, багш, сурагчид жендэрээс үүдэлтэй хүчирхийллийн тухай, энэ төрлийн хүчирхийллийн бууруулахад сургуулийн үүрэг, оролцоо, сургууль дээрх жендэрийн эрүүл, зөв орчныг төлөвшүүлэх арга замууд, үе тэнгийнхэн бие биенээ хамгаалах, урьдчилан сэргийлэх аргын тухай, хохирогч-төвтэй арга зүйн талаар, үйлчилгээ үзүүлэгчдээс цаг тухайд нь тусламж, үйлчилгээ авах, сургуулийн орчинд хүүхдийн эрхийн зөрчлийн гомдол гаргах зэрэг ойлголттой эсэхийг үнэлэн, 12-18 насны охидын жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, дараах үйлчилгээг цахимаар болон бусад хэлбэрээр авах боломж бүрдсэн эсэх, хаанаас тусламж авахаа мэддэг эсэх талаарх чанарын болон тоон судалгааг хийлээ.

Тус судалгааг гэрээлэн гүйцэтгэж бидэнтэй хамтран ажилласан IRIM хараат бус судалгааны хүрээлэнгийн хамт олон болон судалгаанд мэдээлэл өгч оролцсон бүх талуудад гүн талархал илэрхийлж байна.

Энхбатын Цолмон  
ХИС-гийн Хүүхэд хамгаалал, Хүүхдийн эрхийн засаглалын  
хөтөлбөрүүдийн менежер

## НЭР ТОМЬЁО, ОЙЛГОЛТЫН ХҮРЭЭ

	Нэр томьёо	Тайлбар
1.	Бэлгийн хүчирхийлэл	Бэлгийн хүчирхийлэл гэдэг нь эхнэр, нөхөр, гэр бүлийн бусад гишүүн, хамтран амьдрагч, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, тэдгээрийн асрамж, хамгаалалтад байгаа этгээд, тухайн гэр бүлд хамт амьдарч байгаа этгээд болон тусдаа амьдарч байгаа төрүүлсэн, үрчлэн авсан хүүхэд, төрсөн, үрчлэн авсан эцэг, эх, ах, эгч, дүү нь өөрийн эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан гэр бүлийн тухай хуулийн үйлчлэлд хамаарах хүнийг бэлгийн шинжтэй аливаа үйлдэлд албадахыг хэлнэ.
2.	Бэлгийн мөлжлөг	Монгол Улсын Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/-ийн 12.3 дугаар зүйлд “Хохирогчид хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж; эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан зорчих эрхийг хязгаарлахгүйгээр бусадтай бэлгийн харьцаанд албадан оруулсан” үйлдлийг Бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг хэмээн хуульчилсан.
3.	Гэр бүлийн хүчирхийлэл	Монгол улсын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 5.1.1-д зааснаар 5.1.1. “гэр бүлийн хүчирхийлэл” гэж энэ хуулийн 3 дугаар зүйл 1-д заасан этгээд энэ хуулийн үйлчлэлд хамаарах хүний сэтгэл санаанд дарамт учруулах, эдийн засаг, бэлгийн эрх чөлөө, бие махбодод халдсан үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ гэж заасан.
4.	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил	Монгол улсын Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 3.1-т “Гэмт хэрэг, зөрчлийн тухай мэдээллийг судалсны үндсэн дээр гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхэд нөлөөлж байгаа шалтгаан, нөхцөл, хүчин зүйлсийг тогтоож, түүнийг арилгахад чиглэсэн эдийн засаг, нийгэм, эрх зүйн болон зохион байгуулалтын бусад арга хэмжээний нийлбэр цогц мөн” гэж заасан.
5.	Статистик ач холбогдол	Судалгааны үр дүн нь түүврийн эсвэл хувьсагчуудын санамсаргүй шинж байдлаас үүдэн гарч ирсэн эсэхийг шалгах, хамааран болон үл хамааран хувьсагч хооронд бодитой хамаарал бий эсэхийг шалгадаг. Өгөгдсөн таамаглал нь батлагдаж буй эсэхийг хувьсагчийн р-утгад үндэслэн тооцдог.
6.	Үйлчилгээ үзүүлэгч	Хохирогч/даван туулагчийг эргэн нийгэмшүүлэх, нөхөн сэргээх, дасан зохицож эргэн хэвийн амьдралд ороход шаардлагатай нийгэм, сэтгэл зүйн, эрүүл мэндийн, болон хууль эрх зүйн туслалцаа, хамгаалалтын үйлчилгээг цогцоор үзүүлдэг, үйлчилгээ үзүүлэх чадавхтай, энэ чиглэлд мэргэшсэн, тусгай зөвшөөрөлтэй төрийн болон төрийн бус байгууллага (ТББ).

# ХУРААНГУЙ

Японы Хүүхдийг Ивээх Сан (ХИС), Нэгдсэн Үндэстний Байгууллагын Итгэлцлийн Сан (НҮБИС)-ийн санхүүжилттэйгээр 2021-2024 оны хооронд “Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төслийг хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд, IRIM судалгааны хүрээлэн нь “Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төслийн суурь үзүүлэлтүүдийг тодорхойлох, өнөөгийн нөхцөл байдлыг үнэлэх ерөнхий зорилго бүхий суурь судалгааг гүйцэтгэлээ. Уг суурь судалгаа нь дараах хоёр зорилтуудыг дэвшүүлэн ажиллав. Үүнд:

- (i) төслийн ахиц, үр нөлөөг үнэлж болохуйц зорилгын шалгуур үзүүлэлтийн суурь түвшнийг тодорхойлох;
- (ii) төслийн үйл ажиллагааны төлөвлөлтийг боловсронгуй болгох, төлөвлөгдсөн үйл ажиллагааны цар хүрээ болон боломжит үр нөлөө, төслийн шалгуур үзүүлэлтүүдийг хэмжих гэсэн зорилтууд багтана.

Судалгааны өгөгдөл цуглуулах ажлыг төслийн зорилтот дүүргүүд болох Баянгол, Баянзүрх, Чингэлтэй, Сүхбаатар болон Сонгинохайрхан дүүргүүдийн зорилтот сургуулиуд, байгууллагуудыг хамруулан гүйцэтгэлээ. Суурь судалгааны мэдээллийг тоон болон чанарын судалгааны аргыг ашиглан цуглуулсан. Тухайлбал, төслийн зорилтот бүлэг 12-18 насны сурагч охидоос асуулга болон фокус бүлгийн ярилцлага, харин хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудаас чанарын ярилцлагын аргаар мэдээллүүдийг цуглуулан дүн шинжилгээ хийв. Эдгээрээс гадна Монгол Улсад мөрдөгдөж буй хүүхэд хамгааллын үйлчилгээний эрх зүйн орчныг тоймлон судалсан.

Судалгааны үр дүнг төслийн шалгуур үзүүлэлтүүдийн дагуу ангилж, нарийвчлан, шинжилж, холбогдох үр дүнг тусгасан ба үүнтэй адилаар шалгуур үзүүлэлтүүд тус бүрд харгалзах санал зөвлөмжийг нарийвчлан боловсруулав. Төслийн хяналт шинжилгээ, үнэлгээний хүрээнд заасан шалгуур үзүүлэлт болон суурь судалгааны үр дүнд тогтоосон суурь үзүүлэлтүүдийг дараах хүснэгтэд харуулав.


**Хүснэгт 1. Төслийн суурь үзүүлэлтүүд**

#	Шалгуур үзүүлэлтүүд	Мэдээллийн эх сурвалж	Суурь түвшин
1	Хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар сайн гэж хариулсан оролцогчдын хувь	<b>Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа:</b> 12-18 насны сурагч охид, Хамтарсан багийн гишүүд, Сургуулийн удирдлага, багш, НА	43.4%
		<b>Хариу арга хэмжээ:</b> 12-18 насны сурагч охид, Хамтарсан багийн гишүүд, Сургуулийн удирдлагууд, багш, НА Төрийн байгууллагын мэргэжилтнүүд, ТББ мэргэжилтнүүд, Хохирогч охид	19.6%

2	КОВИД-19 цар тахал нь гэр бүл, сургууль, олон нийтийн түвшинд өөрийн аюулгүй байдалд эрсдэл үүсгэсэн гэж тодорхойлсон охидын хувь	12-18 насны сурагч охид, Төрийн байгууллагын мэргэжилтнүүд ТББ мэргэжилтнүүд	19.1%
3	Зорилтот 5 дүүргийн төр, иргэний нийгмийн байгууллагын (ИНБ) ажилтнууд хохирогч төвтэй, гэмтлийн дараах сэтгэцийн гэмтэлд суурилсан үйлчилгээ үзүүлэх аргачлалыг ашиглан гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод тусламж, үйлчилгээ үзүүлэх чадвартай гэж тодорхойлсон ажилтнуудын хувь	Хамтарсан багийн гишүүд, Төрийн байгууллагын мэргэжилтнүүд Хохирогч охид ТББ Нэг цэгийн үйлчилгээ, Түр хамгаалах	10%
4	‘Сургуулийн удирдлага, багш, сурагчид бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийг багасгахад сургуулийн үүрэг, оролцоо, сургууль дээрх жендэрийн эрүүл, зөв орчныг төлөвшүүлэх арга замууд, үе тэнгийнхэн бие биеэ хамгаалах, урьдчилан сэргийлэх аргын тухай, хохирогч-төвтэй арга зүйн талаар сургуулийн орчинд хүүхдийн эрхийн зөрчлийн гомдол гаргах зэрэг ойлголттой’ гэж тодорхойлсон хувь	12-18 насны сурагч охид, Сургуулийн удирдлага, багш, НА	38.3%
5	‘12-18 насны охидын ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, дараах үйлчилгээг цахимаар авах боломж бүрдсэн эсэх, хаанаас тусламж авахаа мэддэг’ гэж тодорхойлсон охидын хувь	12-18 насны сурагч охид	19.7%

Эх сурвалж: Суурь судалгааны үр дүн

Судалгааны үр дүнд илэрсэн эдгээр суурь үзүүлэлтийг шалгуур үзүүлэлт тус бүрээр доорх хэсэгт холбогдох үр дүнгийн хамтаар дэлгэрүүлэн тайлбарлалаа.

 **Шалгуур үзүүлэлт 1:**  
‘Хүүхэд хамгааллын үйл ажиллагааны чанар сайн’ гэж хариулсан оролцогчдын хувь.

Судалгаанд оролцогч охидын 43.4 хувь нь хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чанарыг 19.6 хувь нь хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх үйлчилгээний чанарыг тус тус “сайн” гэж үнэлжээ. Чанарын ярилцлагад хамрагдсан

нийгмийн ажилтан, сургуулийн нийгмийн ажилтан, Нэг цэгийн үйлчилгээний ажилтан, Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв (СЭМУТ)-ийн ажилтан гэх мэт үйлчилгээ үзүүлэгчид нь хохирогчийг нэн шаардлагатай үйлчилгээнд холбон зуучлах үйлчилгээ үзүүлдэг бөгөөд гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэргийн хохирогчдод зөвлөгөө өгч байсан туршлагатай байна. Эдгээр үйлчилгээг үзүүлэхдээ “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” /шинэчилсэн найруулга/, “Хүүхэд хамгааллын тухай” хуулиуд, тэдгээрийг даган гарсан журмуудын хүрээнд үзүүлдэг байна.

Урьдчилан сэргийлэх болон хариу үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчин бүрдсэн хэдий ч, институтын хүчин зүйлс нь үйлчилгээний чанарт сөргөөр нөлөөлж байна. Тухайлбал, үйлчилгээ үзүүлж буй байгууллагын мэргэжилтнүүдийн тогтворгүй байдал, мэргэжлийн болоод мэргэшсэн ажилтан дутмаг байдал, кейс дээр ажиллах санхүүжилт шийдвэрлэгдээгүй байдал

зэрэг нь бэрхшээл болж байгааг үйлчилгээ үзүүлэгчид дурдаж байлаа. Үйлчилгээ үзүүлэгч төрийн байгууллагын хувьд сэтгэцийн гэмтэлд суурилсан, хохирогч төвтэй арга зүйг үзүүлж байсан туршлага дутмаг ба нэн шаардлагатай үйлчилгээг үзүүлэхийн тулд мэргэжлийн ТББ руу дамжуулдаг гэв. Эдгээр үр дүн нь хохирогчдод үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах шаардлага байгааг харуулж байна.



### Шалгуур үзүүлэлт 2:

КОВИД-19 цар тахал нь гэр бүл, сургууль, олон нийтийн түвшинд өөрийн аюулгүй байдалд эрсдэл үүсгэсэн гэж тодорхойлсон охидын хувь

Суурь судалгаанд хамрагдсан сурагч охидын 19.1 хувь нь гэр бүл, сургууль, олон нийтийн түвшин дэх аюулгүй байдлын эрсдэлийг КОВИД-19 цар тахал нэмэгдүүлсэн гэж үзжээ. Мөн охидын 19 хувь нь гэр бүлийн орчинд, 13 хувь нь цахим орчинд эрсдэлд орсоноо хүлээн зөвшөөрсөн. Охидын 30.6 хувь нь сургуулийн

орчинг, 20.3 хувь нь амьдран суугаа газраа хамгийн эрсдэлтэй орчин гэж үзсэн. Гэр бүлийн орчинд КОВИД-19 цар тахлын үед орлого багассанаас үүдэн сэтгэлзүйн болон бие махбодын хүчирхийлэл гарсан бол цахим орчинд бэлгийн дарамт үзүүлж буй хувийн захидал ирэх болсон тухай дурдагджээ. Харин сургуулийн орчинд КОВИД-19 цар тахал халдвар авах өндөр магадлалтай гэж үзсэн бол амьдарч буй орчны хүрээнд архи дан согтуурах явдал ихсэж буйг охид болон холбогдох мэргэжилтнүүд онцолжээ.



### Шалгуур үзүүлэлт 3:

Зорилтот 5 дүүргийн төр, иргэний нийгмийн байгууллагын (ИНБ) ажилтнууд сэтгэцийн гэмтэлд суурилсан, хохирогч төвтэй арга зүйд суурилсан үйлчилгээг үзүүлэх аргачлалыг ашиглан гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод тусламж, үйлчилгээ үзүүлэх чадвартай гэж тодорхойлсон ажилтнуудын хувь

Хамтарсан багийн гишүүдийн 10 хувь нь сэтгэцийн гэмтэлд суурилсан, хохирогч төвтэй арга зүйн талаар ойлголт, мэдлэгтэй, хүүхэлд хамгааллын үйлчилгээнд нэвтрүүлсэн туршлагатай бол 90 хувь нь ямар ч мэдлэг, туршлагагүй болохоо мэдэгдсэн. Гэхдээ хамтарсан багийн гишүүд нь сэтгэцийн гэмтэлд суурилсан, хохирогч төвтэй арга зүйг нэвтрүүлэхэд шаардлагатай зарим үр чадварыг бусад сургалтууд, кейс дээр ажиллах явцдаа олж авсан тохиолдлууд дурдагдаж байв. Одоогийн байдлаар сэтгэцийн гэмтэлд

суурилсан, хохирогч төвтэй арга зүй бүхий үйлчилгээг зөвхөн төрийн бус байгууллага тэр дундаа Хөөрхөн зүрх болон Хүчирхийллийн эсрэг үндэсний төв зэрэг ТББ-ууд бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэргийн хохирогч/даван туулагчдад үзүүлж байна. Хамтарсан



### Шалгуур үзүүлэлт 4:

Сургуулийн удирдлага, багш, сурагчид бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийг багасгахад сургуулийн үүрэг, оролцоо, сургууль дээрх жендэрийн эрүүл, зөв орчныг төлөвшүүлэх арга замууд, үе тэнгийнхэн бие биеэ хамгаалах, урьдчилан сэргийлэх аргын тухай, хохирогч-төвтэй арга зүйн талаар сургуулийн орчинд хүүхдийн эрхийн зөрчлийн гомдол гаргах зэрэг ойлголттой гэж тодорхойлсон хувь

багуудын гишүүд болон албан хаагчдын зүгээс сэтгэцийн гэмтэлд суурилсан, хохирогч төвтэй арга зүйг заах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх сургалтад хамрагдах сонирхлоо илэрхийлж байсан нь хэрэгцээ шаардлага их байгааг харуулж байлаа.

Судалгаанд хамрагдсан сурагч охидын 72.2 хувь нь өөрсдийгөө бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн талаар ерөнхий мэдлэгтэй гэж үнэлжээ. Асуулга судалгааны үр дүнгээс харахад, охидын 46.5 хувь нь бэлгийн хүчирхийллийн талаар, 30.1 хувь нь бэлгийн мөлжлөгийн талаар үнэн, зөв мэдлэгтэй байгаа

нь дунджаар 38.3 хувь нь бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн талаар ойлголт, мэдлэг сайтай байна гэж дүгнэж болохоор байна. Дийлэнх охид өөрийгөө болон үе тэнгийн найз нөхдөө хамгаалах, аливаа эрсдэлээс зайлсхийх шаардлагатайг ухамсарласан байдаг ба энэ байдал нь дунд ангийн охидтой харьцуулахад ахлах ангийн охидод илүү ажиглагдаж байв. Охидын дийлэнх нь аюултай, эрсдэлтэй нөхцөл байдалд орвол өөрийгөө хэрхэн хамгаалах талаар мэдээлэл, заавар, зөвлөгөөг эцэг, эхээсээ болон хүүхэд хамгааллын 108 утасны үйлчигээний төвөөс, харин цөөн хувь нь л хүүхэд хамгааллын хамтарсан баг, холбогдох хичээл, баг, хорооны нийгмийн ажилтан, брошур, танилцуулга, нугалбар зэргээс мэдээлэл авч байна. Энэ нь хүүхэд хамгааллын талаар заавар, зөвлөгөө өгдөг мэдээллийн эх сурвалжийн тоог нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна Мөн охид хэн нэгнээс тусламж авч, хамгаалуулахдаа тэдний нэр төрд халдахгүй, сэтгэл зүйд сөргөөр нөлөөлөхгүй, нэмж эрсдэлд оруулахгүй, хүүхдийн эрхийг дээдэлсэн, шударга зарчимд тулгуурласан хүүхэд хамгааллын үйлчилгээ хүсэж байгаа нь судалгаагаар тогтоогдсон.



#### Шалгуур үзүүлэлт 5:

12-18 насны охидын ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, дараах үйлчилгээг цахимаар авах боломж бүрдсэн эсэх, хаанаас тусламж авахаа мэддэг гэж тодорхойлсон охидын хувь

Судалгаанд хамрагдсан нийт сурагч охидын 58.8 хувь нь охидын эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, дараах үйлчилгээг цахимаар авах боломж бүрдсэн гэж үзсэн. Хэрвээ охидын эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн эсвэл өртөх эрсдэлтэй нөхцөл байдалд сурагч охидын 19.7 хувь нь хаанаас тусламж авахаа

мэддэг гэж хариулжээ. Гурван охин тутмын хоёр нь эрсдэл, аюул тохиолдвол хамгийн түрүүнд эцэг, эх, асран хамгаалагчдаа ханддаг байна. Харин хоёр охины нэг нь хүүхдийн тусламжийн 108 утсанд эсвэл цагдаад ханддаг аж. Хүүхэд хамгааллын хамтарсан баг, хүүхдийн төлөө ажилладаг ТББ, хүүхэд, гэр бүл хөгжлийн төв, сургуулийн удирдлага, багш, сургуулийн болон баг, хорооны нийгмийн ажилтан, баг, хорооны засаг даргад хандах охидын тоо харьцангуй цөөн байгаа нь тэд эдгээр хүмүүс, байгууллагад хандах боломжтойг мэдэхгүй байгаатай холбоотой. Ойролцоогоор охидын 20 хувь нь хаанаас тусламж авч, хэрхэн хамгаалуулах талаар мэддэггүйгээсээ шалтгаалан охид бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн тохиолдолд хэн нэгэнд хандаж, тусламж авч чаддаггүй байна. Охид телевиз, радио, цахим хуудас, Facebook зэрэг нийгмийн сүлжээг түлхүү ашиглаж, мэдээлэл олж авч байна. Тиймээс тэдэнд чиглэсэн үнэн, зөв мэдээллийг өгөхдөө олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээг ашиглах нь тохиромжтой.

# 1. СУУРЬ СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

## 1.1 Судалгааны зорилго ба хамрах хүрээ

“Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төсөл нь Улаанбаатар хотын 5 дүүргийн 12-18 насны охидыг КОВИД-19 цар тахлын хүчин зүйлийн улмаас хүндэрсэн хүчирхийлэл, мөлжлөгт өртөх эрсдэлээс эрүүл мэнд, хүүхэд хамгаалал, боловсролын үйлчилгээгээр дамжуулан хамгаалах гэсэн үндсэн зорилготой юм.

Иймд төслийн суурь судалгааны зорилго нь “Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төсөл хэрэгжихээс өмнөх суурь үзүүлэлтүүдийг тодорхойлох, өнөөгийн нөхцөл байдлыг үнэлэх юм. Ингэхдээ (i) төслийн ахиц, үр нөлөөг үнэлж болохуйц төслийн зорилгын шалгуур үзүүлэлтийн суурь түвшнийг тодорхойлох; болон (ii) төслийн үйл ажиллагааны төлөвлөлтийг боловсронгуй болгох, төлөвлөгдсөн үйл ажиллагааны цар хүрээ болон боломжит үр нөлөө, төслийн зорилтын шалгуур үзүүлэлтүүдийг хэмжих юм. Энэхүү зорилгод хүрэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд:

- Зорилтот дүүрэг тус бүрийн холбогдох тоон болон чанарын судалгааны мэдээллээр төслийн зорилгын зорилтот хоёр шалгуур үзүүлэлтүүдийг хэмжих,
- Зорилтот 5 дүүргийн төр, иргэний нийгмийн байгууллага (ИНБ)-ын ажилтнууд сэтгэцийн гэмтэлд суурилсан, хохирогч төвтэй арга зүйд суурилсан үйлчилгээ үзүүлэх аргачлалыг ашиглан гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод тусламж, үйлчилгээ үзүүлэх чадвартай эсэхийг судлах,
- Сургуулийн удирдлага, багш, сурагчид жендэрээс үүдэлтэй хүчирхийллийн тухай, охидын бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийг багасгахад сургуулийн үүрэг, оролцоо, сургууль дээрх жендэрийн эрүүл, зөв орчныг төлөвшүүлэх арга замууд, үе тэнгийнхэн бие биеэ хамгаалах, урьдчилан сэргийлэх аргын тухай, сэтгэцийн гэмтэлд суурилсан, хохирогч төвтэй арга зүйн талаар, үйлчилгээ үзүүлэгчдээс цаг тухайд нь тусламж, үйлчилгээ авах, сургуулийн орчинд хүүхдийн эрхийн зөрчлийн гомдол гаргах зэрэг ойлголттой эсэхийг судлах,
- 12-18 насны охидын бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, чиглэлд дараах үйлчилгээг цахимаар авах боломж бүрдсэн эсэх, хаанаас тусламж авахаа мэддэг болсон (цахимаар болон биеэр) талаарх чанарын болон тоон судалгаа хийх зэрэг зорилтууд багтаж байна.


## 1.2 Судалгааны арга зүй

### 1.2.1. Арга зүй

Суурь судалгаа нь үндсэн гурван үе шатнаас бүрдэх ба доорх дүрсэд эдгээр шатуудыг нарийвчлан дүрсэлсэн болно.



**Дүрс 1.** Суурь судалгааны үйл явц



Эхлэлтийн шатанд суурь судалгааны хэрэглэгдэхүүнүүдийг боловсруулан, захиалагч талаас санал аван эцэслэсэн. Үүний дараа мэдээлэл цуглуулалтын шатанд холбогдох бүх оролцогч талуудтай холбогдон мэдээлэл цуглуулалтад бэлтгэж, улмаар судлаачдаа бэлтгэн судалгаа авсан болно. Мэдээлэл цуглуулалтын бүхий л явцад чанарын шаардлага хангахуйц мэдээлэл цуглуулахын тулд мэдээллийн чанарын хяналтыг гүйцэтгэсэн. Цаашлаад судалгааны эцсийн шатад цугларсан мэдээллийг оруулан, дата боловсруулалт хийгдэж суурь судалгааны эцсийн тайланг боловсруулсан.

**1.2.2. Судалгааны түүвэр**

Тоон судалгааны түүврийн хэмжээг тогтоохдоо зорилтот дүүргийн түвшинд төлөөлөхүйц байдлаар тодорхойлсон. Түүврийн хэмжээ болон аргачлалыг гаргахдаа олон давхраат түүврийн аргыг ашиглав. Сонгогдсон дүүргүүдэд суралцаж буй 12-18 насны сурагч охидыг түүвэрлэн авсан ба дүүрэг бүрээс сонгогдсон 3 сургууль бүрийн 1 сургууль нь дүүргээсээ алслагдмал байрших сургууль (хотын захын сургуулиуд) байхаар сонгов. Ингэхдээ судалгаанд хамрагдсан 14 болон түүнээс доош насны охидыг дунд анги, 15 болон түүнээс дээш насны охидыг ахлах ангийн охид гэж бүлэглэв.

**Хүснэгт 2.** Түүврийн хэмжээ

Дүүргүүд	Дунд болон ахлах ангид суралцагчдын тоо	Түүвэрлэгдсэн сургуулийн тоо	Нийт түүврийн хэмжээ
Сонгинохайрхан	21815	3	135
Сүхбаатар	20149	3	128
Баянзүрх	31519	3	197
Баянгол	21616	3	133
Чингэлтэй	11850	3	73
<b>Бүгд</b>	<b>106949</b>	<b>15</b>	<b>664</b>

Тоон судалгааны түүврийг бүрдүүлэхдээ судалгааны баг захиалагч талын дэмжлэгтэйгээр зорилтот дүүргүүдийн сонгогдсон 15 сургуулийн захиргаатай хамтран ажилласан. Сургуулийн захиргаа болон холбогдох мэргэжилтнүүдтэй холбогдсоноор зорилтот сурагчдыг тодорхойлж урьдчилан тооцсон түүврийн тооцооллын дагуу уулзаж судалгаа авах хуваарийг гарган ажиллав. Тоон судалгаанд хамрагдсан сургуулиудыг Хүснэгт 3-т харуулав.

**Хүснэгт 3. Зорилтот 15 сургууль ба сургууль тус бүрийн түүврийн хэмжээ**

Дүүрэг	Сургууль	Судалгаанд оролцогчдын тоо
Баянзүрх дүүрэг	79-р сургууль	65
	148-р сургууль	66
	85-р сургууль	66
Сонгинохайрхан дүүрэг	9-р сургууль	45
	107-р сургууль	45
	121-р сургууль	45
Чингэлтэй дүүрэг	24-р сургууль	24
	117-р сургууль	24
	57-р сургууль	24
Баянгол дүүрэг	13-р сургууль	44
	19-р сургууль	44
	20-р сургууль	44
Сүхбаатар дүүрэг	16-р сургууль	43
	31-р сургууль	43
	3-р сургууль	42
<b>Нийт</b>		<b>664</b>

**Чанарын судалгааны түүврийг бүрдүүлэхдээ** жендерт суурилсан хүчирхийлэл болон бэлгийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр ажилладаг гол талууд болох төрийн байгууллагын албан хаагчид, хамтрагч болон үйлчилгээ үзүүлэгч иргэний нийгмийн, олон нийтэд түшиглэсэн, төрийн бус байгууллагуудын мэргэжилтнүүдийг сонгон авч судалсан. Мөн зорилтот 15 сургуулийн 14-18 насны сурагч охид болон хохирогч болсон охидыг холбогдох байгууллагууд, сургуулиудын нийгмийн ажилтнуудтай хамтран сонгон авч чанарын судалгаанд хамруулсан.


**Хүснэгт 4. Чанарын судалгааны оролцогчид**

#	Арга	Оролцогч байгууллагууд	Тоо
1	Хагас бүтэцлэгдсэн ярилцлага	<ul style="list-style-type: none"> <li>Шүүх эмнэлгийг түшиглэсэн нэг цэгийн үйлчилгээ</li> <li>ГССҮТ-ийг түшиглэсэн нэг цэгийн үйлчилгээ</li> <li>Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв</li> <li>Дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар/хэлтэс</li> <li>Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар</li> <li>Дүүргийн нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр</li> <li>Дүүргийн хүүхдийн асуудал хариуцсан байцаагч</li> <li>Зорилтот 15 сургуулийн нийгмийн ажилтан, захирал, сэтгэл зүйч</li> <li>Хамтарсан багийн гишүүд</li> </ul>	n=1 n=1 n=1 n=5 n=1 n=4 n=5 n=18 n=10
2	Голлох мэргэжилтний ярилцлага	<ul style="list-style-type: none"> <li>Хөөрхөн зүрх ТББ</li> <li>Хүүхэд хамгааллын Үндэсний сүлжээ</li> <li>Гүүд нэйборс ОУБ</li> <li>Гүнж төв ТББ</li> <li>Хүчирхийллийн эсрэг Үндэсний төв ТББ</li> </ul>	n=1 n=1 n=1 n=1 n=1
3	Фокус бүлгийн ярилцлага	Зорилтот 15 сургуулийн 14-18 насны сурагч охид	n=25
4	Кейс судалгаа	Бэлгийн хүчирхийллийн хохирогч болсон 12-18 насны охид	n=5

### 1.2.3. Мэдээлэл цуглуулалт

Суурь судалгаа нь Дүрс 2-т үзүүлсний дагуу тоон болон чанарын судалгаа гэсэн үндсэн хоёр бүрэлдэхүүн хэсгээс бүрдсэн болно.

#### Дүрс 2. Суурь судалгааны бүрэлдэхүүн хэсгүүд



#### Бүрэлдэхүүн 1. Тоон судалгаа

Суурь судалгааны тоон судалгаанд нийт 664 сурагч охид хамрагдсан. Тоон судалгаанд Computer Assisted Personal Interviewing (CAPI) буюу компьютерт суурилсан биечлэн мэдээлэл цуглуулах аргыг ашигласан ба дунджаар нэг судалгаа 25-30 минут үргэлжилсэн. Тоон мэдээлэл цуглуулалтыг 2021 оны 12 сарын 06-аас 13-ны хооронд зохион байгуулав.

#### Бүрэлдэхүүн 2. Чанарын судалгаа

Чанарын судалгааны хүрээнд кейс судалгаа (КС), фокус бүлгийн ярилцлага (ФБЯ), голлох мэргэжилтний ярилцлага (ГМЯ), хагас бүтэцлэгдсэн ярилцлага (ХБЯ), баримт бичгийн шинжилгээ (ББШ) аргуудыг ашигласан. Чанарын судалгааны мэдээлэл цуглуулалтыг 2021 оны 12 дугаар сарын 13-аас 2022 оны 1 дүгээр сарын 14-ны хооронд зохион байгуулав.

Чанарын судалгааны түүхий өгөгдөлд “Grounded Theory Approach” буюу Системчилсэн дүн шинжилгээний аргын дагуу дүн шинжилгээ хийж дараах алхмуудын дагуу шинжилгээг гүйцэтгэсэн:

- Бүх ярилцлагуудын транскрипци/протокол хийсэн.
- Транскрипци/протокол бүхий ярилцлагуудыг аналитик хүрээнд (холбогдох судалгааны асуултад) суурилан кодолж, мөн шинээр гарч ирсэн сэдвүүдийг нэгтгэсэн.
- Шинээр гарч ирж буй сэдвүүдэд зориулж кодлогдсон мэдээллийг задалж, цэгцэлж, уншсан.
- Кодыг нэгтгэх замаар сэдвүүдийг тодорхойлсон.
- Давтагдсан өгөгдлүүдээс үүссэн тодорхой хэв маягийг боловсруулсан.
- Тайлагнах үйл явцад чанарын судалгааны ярилцлагуудыг тоон судалгааны ижил үр дүнгүүдтэй нэгтгэсэн.

### 1.2.4. Мэдээллийн чанарын хяналт

Чанарын хяналтын баг мэдээлэлд гарч болох асуудлыг илрүүлж, бүртгэл хөтлөх улмаар тухайн алдааг засаж, залруулах байдлаар судалгааны үндсэн багт тогтмол дэмжлэг үзүүлж ажилласан ба судалгааны ярилцлагууд нь аудио бичлэгээр баталгаажсан. Өгөгдлийн бүрэн бүтэн, найдвартай байдлыг хангахын тулд мэдээлэл цуглуулах явцад мэдээллийн чанарын хяналтыг нэгэн зэрэг зохион байгуулсан. Үүнд дараах төрлийн чанарын хяналтууд багтсан.

**Хүснэгт 5. Тоон мэдээлэл цуглуулалтын арга болон чанарын хяналтын төрөл**

Хяналтын төрөл	Агуулгын хяналт	Аудио бичлэг тулгах хяналт
Хяналтын төрлийн тайлбар	Чанарын хяналтын ажилтан нь сервер дээр цуглуулсан өгөгдлийг байнга хянаж, асуулгын логик бүтэц, уялдаа холбоог шалгаж, талбайн судлаачдад шаардлагатай зааврыг өгнө.	Авсан ярилцлага бүрийг аудио рекордоор баримтжуулан хадгалах ба энэ төрлийн чанарын хяналтыг цугларсан нийт мэдээлэл оруулалтын 30%-д хийх ба нийт цугларсан асуумжаас санамсаргүйгээр сонгож хийнэ. Анкет тус бүрийн мэдээллийн санд оруулсан өгөгдлийн алдаагүй байдал 99-өөс доошгүй хувьтай байна.
Нэр нууцалсан асуумж	100% хийгдсэн	30% хийгдсэн
Алдааны хувь	0.2 хувь	0.1 хувь
Чанарын ярилцлагын транскрипци	NA	100% хийгдсэн
Алдааны хувь	NA	0.6 хувь

### 1.3 Судалгааны хязгаарлагдмал тал

Суурь судалгааг гүйцэтгэх хугацаа нь КОВИД-19 цар тахлын эрчимтэй тархалтын үе байсантай холбоотойгоор мэдээлэл цуглуулалтын процедур, арга зүйгээс үүдэн уг тайлан нь дараах хэд хэдэн хязгаарлагдмал талуудыг агуулж байна. Үүнд:

- Суурь судалгааны мэдээллийг зорилтот сургуулийн сурагчдаас санамсаргүй түүврийн аргыг ашиглан цуглуулахыг зорьсон ч, цаг үеийн нөхцөл байдалтай холбоотойгоор судалгааны баг талуудтай биечлэн уулзах, бүх сурагчдаас санамсаргүй байдлаар түүвэрлэх боломж хязгаарлагдмал байв.
- Мөн тоон мэдээлэл цуглуулалтыг хугацаа анх төлөвлөсөн хугацаанаас багассан ба энэ нь сурагчдын улирлын амралт эрт эхэлсэн ба зарим тохиолдолд сурагчид цахимаар хичээллэж байсантай холбоотой юм. Тиймээс судалгааны багийнхан богино хугацаанд судлаачдын тоог нэмж, зорилтот сургуулиудын нийгмийн ажилтнуудтай нягт хамтарч ажиллан богино хугацаанд мэдээлэл цуглуулалтыг амжилттай зохион байгуулсан. Тиймээс, зорилтот сургуулийн удирдлага, багш нарын тусламжтайгаар сурагчдыг сонгож, оролцохыг зөвшөөрсөн сурагч охидыг мэдээлэл цуглуулалтад хамруулсан.
- Зарим холбогдох төрийн байгууллагуудын мэргэжилтнүүд нэгдсэн сургалтад хамрагдсантай холбогдуулан ярилцлагын цагийг хойшлуулах тохиолдлууд гарсан.
- Судалгааны нэг зорилтот бүлэг нь хохирогч охидууд байсан бөгөөд тэдгээрээр хариу арга хэмжээний чанар, хүртээмжийг үнэлүүлэхээр зорьж байсан. Гэвч хохирогч охидыг хайж олох, эцэг эхээс зөвшөөрөл авах оролдлогууд ихээхэн цаг авсан. ТББ-ууд ихэвчлэн охидод хариу арга хэмжээ үзүүлж байгаа учраас байгууллагын мэдээллийн нууцлал, асуудлын эмзэг байдалтай холбоотойгоор мэдээлэл цуглуулах явц ихээхэн удааширсан. ХИС-гийн дэмжлэгтэйгээр ИНБ-ын мэргэжилтнүүдтэй хамтран ярилцлагуудыг биечлэн болон цахимаар зохион байгуулав.


### 1.4 Судалгаанд оролцогчдын ерөнхий шинж

Судалгааны арга зүйн хэсэгт дурдсанчлан суурь судалгаанд зорилтот бүлгийг төлөөлөхүйц 5 дүүргийн зорилтот 15 сургуулийн нийт 664 сурагч охид хамрагдсан. Сурагч охидыг насны бүлгээр харьцуулан харвал 12-18 насны охид харьцангуй тэгш тоогоор хамрагдсан байна.

Судалгаанд оролцсон сурагч охидын 95% нь өөрийн албан ёсны асран хамгаалагчтайгаа хамт амьдардаг гэсэн бол үлдсэн 5% нь амьдардаггүй гэх хариултыг өгсөн байна. Өөрийн асран хамгаалагчтайгаа амьдардаггүй охидын 57.6% нь өвөө эмээгийн дээ амьдардаг гэсэн бол 42.4% нь ах, дүү хамаатан садныдаа амьдардаг гэсэн байна. Харин оролцогчдын 61.4% нь 5 ба түүнээс дээш өрхийн гишүүнтэйгээ амьдардаг гэжээ. Сурагч охидын 19.1%-д гэр бүлд нь өрх толгойлсон хүн байдаг гэсэн бол 9.3%-д нь хөгжлийн бэрхшээлтэй хүн байдаг гэсэн хариултуудыг өгчээ.

Сурагч охидын амьдран суугаа газар болон амьдардаг сууцны төрлийг харьцуулан харвал нийт оролцогчдын 46.5% нь гэр хороололд амьдардаг ба тэдний 96.1% нь сууцны тусдаа байшин (хашаа гэр/энгийн байшин)-д амьдардаг байна (Дүрс 3).

Дүрс 3. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл



## 2. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

### 2.1 Хүүхэд хамгааллын үйлчилгээний эрх зүйн орчин, тулгамдаж буй асуудал

Энэ хэсэгт хүүхдийн эрхийг хангах, хамгаалах эрх зүйн орчин, ялангуяа хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалтын талаар дурдах болно.

#### 2.1.1 Хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоо

Монгол Улсад оршин суугаа хүн ам 2021 онд 3,253,300 болж өссөн бөгөөд нийт хүн амын 39.1 хувь буюу 1,272,400 (үүнээс) нь 0-19 насныхан<sup>1</sup>. Монгол Улс нь хүүхдийг нийгмийн бүх орчинд хүчирхийлэл, дарамт, мөлжлөг, үл хайхрах байдлаас ангид байлгах, тэдний хамгаалагдах эрхийг хуулиар баталгаажуулах бодлого хэрэгжүүлснээр хүүхдийн эсрэг хүчирхийллийг бүх орчинд хориглосон дэлхийн 49<sup>2</sup> дэх орон болсон. Түүнчлэн, Монгол Улс нь хүний эрхийн олон улсын 60 гаруй гэрээнд нэгдэн орсон ба 1990 онд НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай Конвенц, түүний нэмэлт протоколууд болох Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг протоколд нэгдэн орсон байдаг. Мөн Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 8 суурь Конвенцыг соёрхон баталсан. Тухайлбал, Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах тухай 182 дугаар Конвенцыг, Ажил эрхлэх насны доод хязгаарын тухай 138 дугаар Конвенцыг тус тус баталжээ. Үүний дагуу, Монгол Улс нь хүүхдийг нийгмийн бүх орчинд хүчирхийлэл, дарамт, мөлжлөг, үл хайхрах байдлаас ангид байлгах, тэдний хамгаалагдах эрхийг хуулиар баталгаажуулах бодлого хэрэгжүүлснээр хүүхдийн эсрэг хүчирхийллийг бүх орчинд хориглосон дэлхийн 49<sup>3</sup> дэх орон болсон. Мөн Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 8 суурь Конвенцыг соёрхон баталсан. Тухайлбал, Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах тухай 182 дугаар Конвенцыг, Ажил эрхлэх насны доод хязгаарын тухай 138 дугаар Конвенцыг тус тус баталжээ.

Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй 500 гаруй хуулийн 60 орчим хууль тогтоомжид хүүхдийн эрхийн талаарх шууд болон шууд бус байдлаар зохицуулсан байдаг, эдгээрээс эрүүгийн, захиргааны, хөдөлмөрийн, гэр бүлийн, боловсролын, эрүүл мэндийн, нийгмийн халамжийн түүнчлэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд 10 гаруй хуульд хүүхдийг гэмт халдлагаас хамгаалах, урьдчилан сэргийлэх агуулга бүхий хэм хэмжээ тусгагдсан байна.<sup>4</sup> Тухайлбал, 2012 онд Хүн худалдаалахтай тэмцэх тухай<sup>5</sup>, 2015 онд Хүүхэд харах үйлчилгээний тухай, 2016 онд Хүүхдийн эрхийн тухай, 2016 онд Хүүхэд хамгааллын тухай, 2015 онд шинэчилсэн Эрүүгийн хууль<sup>6</sup>, 2017 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх

1 YCX, Статистикийн өврийн дэвтэр 2021, Улаанбаатар. [https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=ovriin\\_devter\\_2021\\_mon.pdf&ln=Mn](https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=ovriin_devter_2021_mon.pdf&ln=Mn)

2

3 Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр, МУ-ын Засгийн газрын 2017 оны 270 дугаар тогтоолын хавсралт

4 МУ-ын Хууль сахиулах их сургууль, "МУ-д насанд хүрээгүй хүмүүсээс болон хүүхдийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөл" сэдэвт судалгааны ажлын тайлан (2013-2017 он), 2019 он, хуудас 13

5 Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдийг хамгаалах зохицуулалт тусгайлан тусгагдсан.

6 Шинэчилсэн Эрүүгийн хуульд хүүхдийн эсрэг гэмт хэргийн тусгай бүлэг болгон тусгасан.

тухай<sup>7</sup> хууль тогтоомж батлагдсанаар хууль болон тэдгээрийг дагаж гарсан журмуудаар хүүхдийн эрхийг хангахад төр, иргэн, хуулийн этгээдийн оролцоо болон хүүхдийг үл хайхрах байдал, дарамт, мөлжлөг гэх мэт хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэр, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хариу үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулж байна.

Эрх зүйн шинэчлэлийн зурвас үеэс эхлэн<sup>8</sup> өдгөө хүртэл үргэлжлэн хэрэгжиж буй эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн ажил эрчимтэй явагдсаар 2015 онд шинэчилсэн Эрүүгийн хууль батлагдан<sup>9</sup> 2017 оны 07 дугаарын 01 өдрөөс мөрдөгдөж эхэлсэн ба хүүхдийн эсрэг гэмт хэргийг тусгай бүлэг<sup>10</sup> болгон хуульчилсан. Мөн хуулийн 12-р бүлэгт:

- Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт Хүчиндэх (12.1 дугаар зүйл),
- Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах (12.2 дугаар зүйл),
- Бэлгийн мөлжлөг (12.3 дугаар зүйл),
- Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох (12.5 дугаар зүйл),
- Биеэ үнэлэхийг зохион байгуулах (12.6 дугаар зүйл)<sup>11</sup> зэрэг гэмт хэргүүд оржээ.

Шинэчилсэн Эрүүгийн хуулийн дагуу бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийг бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт тооцох болсон байна.



#### Шигтгээ 1. Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний зохицуулалт

...Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх зохицуулалт тодорхой болсон хэдий ч үйлчилгээ тус тусдаа хохирогч хүүхдэд хүрч байна. Хохирогчийн нууцлалыг хангаж чаддаггүй. Мэргэшсэн хүний нөөц байдаггүй.

...Нэг талаас хохирогч хүүхэд айдаг “Хэнд хэлэх вэ, яах вэ? гээд. Нөгөө талаас томчууд эсхүл багш, нийгмийн ажилтнууд нууцыг нь задруулдаг. Мэргэжилтний ур чадвар, бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэргийн кейс дээр ажилласан туршлага бага байгаа нь нөлөөлдөг гэж бодож байна.

*Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын төлөөлөлтэй хийсэн ярилцлагын хэсгээс...*

Тогтолцооны хувьд, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн<sup>12</sup> 14-р зүйлийн 14.1 дэх хэсэгт Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг улсын хэмжээнд хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр, аймаг, нийслэл, сум, дүүрэгт түүний иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн даргаар удирдуулсан орон тооны бус зөвлөл зохицуулах тухай заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдаар ахлуулсан 34 гишүүнтэй зохицуулах зөвлөл байгуулж, түүний ажиллах журмыг Засгийн газрын 2020 оны 107-р тогтоолоор баталжээ. Улсын хэмжээнд тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг дагнан зохицуулах үүрэг бүхий дэд зөвлөлийг зохицуулах зөвлөлийн дэргэд ажиллуулж болно гэж зааснаас үзвэл хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо нь Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, түүний дэргэд үйл ажиллагааг явуулж буй гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд зөвлөл юм.

7 Хүүхдийг гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах зохицуулалтыг тусгайлан хуульчилсан.

8 Хууль зүйн магистр Г.Оюунболд “Эрүүгийн хуулийн шинэчлэлийн тухай” сэдэвт нийтлэлд эрх зүйн шинэчлэлийн зурвас үеийг шинэ Үндсэн хууль батлагдсан 1992 оноос эхэлсэн гэж тайлбарлажээ.


9 Төрийн мэдээллийн эмхэтгэл 2016 он, №7

10 Эрүүгийн хуулийн 16 дугаар бүлэг нь Хүүхдийн эсрэг гэмт хэргийг тусгайлан зохицуулсан. 2002 оны Эрүүгийн хуулийн 17 дугаар бүлэгт хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг гэж зохицуулж байсан.

11 2020 оны 01-р сарын 10-ны өдөр нэмэлт өөрчлөлтөөр орсон.

12 Төрийн мэдээллийн эмхэтгэл, 2019 он, №42

**Дүрс 4. Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо**



Тус дэд зөвлөлд нийт 13 гишүүнтэй бөгөөд төрийн байгууллагын 8 газрын дарга, захирал, 4 төрийн бус байгууллагын тэргүүн, нэг олон улсын байгууллагын төлөөллөөс бүрджээ. Хүүхэд хамгааллын тогтолцоонд Хөдөлмөр, нийгмийн хамгаалал яам, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл нь голлох шийдвэр гаргагч, бодлого боловсруулагчид болно.

**Шигтгээ 2. Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэхэд гардаг асуудлууд**

...10 жилийн өмнөхтэй харьцуулахад хүүхэд хамгааллын эрх зүйн орчин сайжирсан. Хууль эрх зүйн орчин бүрдсэн хэдий ч хууль хэрэгжүүлэгч албан хаагчийн чадвар, чадавх, туршлагажсан байдлаас хамаараад хууль, дүрэм, журмыг хэрэгжүүлж чадахгүй байна.

...Магадлан итгэмжлэлд орсон байгууллагын хувьд гэрээгээр үйлчилгээ үзүүлээд байхад үйлчилгээний зардал, санхүүгийн асуудлыг цаг хугацаанд нь шилжүүлдэггүй. Мөн үйлчилгээний зардал маш бага байдаг. Хүний нөөцийн зардал байдаггүй.

*Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын төлөөлөлтэй хийсэн ярилцлагын хэсгээс...*

Дээрх тогтолцооны нэг хэсэг болох Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг **Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар** нь Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн хүрээнд хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага юм. Тус газар нь хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр төрийн бодлого, шийдвэр, хууль тогтоомж, төсөл, үндэсний хөтөлбөр, олон улсын гэрээ конвенцийн хэрэгжилтийг хангах, сурталчлах, хөгжил оролцоог дэмжих, эрсдэл хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хамгааллын үйлчилгээг үзүүлэхэд салбар дундын зохицуулалтыг хангах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны чиглэл байгууллага<sup>13</sup> юм. Тус газраас гадна 30 гаруй газар, хэлтэс үндэсний болон орон нутгийн түвшинд үйл ажиллагаа явуулж байна.

13 www.fcy.gov.mn



Мөн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нь үндэсний хэмжээнд хүүхэд хамгаалалтай холбоотой төсөв, санхүүжилт, зарцуулалтыг хариуцдаг. Тус газрын хүүхэд хамгааллын зардал нь жил бүр нэмэгдсэн байдлаас харахад хүүхдийн эсрэг хүчирхийллийн хариу арга хэмжээг сайжруулахад анхаарлаа хандуулж буй илэрхийлэл юм. 2019 онд хүүхэд хамгааллыг төсөв нь 7.6 тэрбум төгрөг байснаа 2020 онд 8 тэрбум төгрөг болж батлагджээ.<sup>14</sup>

Хүүхэд хамгааллын тогтолцоо нь олон талт, салбар дундын хамтын ажиллагаа нэн чухал бөгөөд тэдгээр нь нэгэн зүг чигт харж ажиллах нь хамгийн тэргүүн зэргийн алхам юм. Тиймээс дээрх тогтолцоо хэрхэн ажиллаж байгаа талаарх судалгаанд оролцогчдоос тодруулахад салбар дундын хамтын ажиллагаа дутагдалтай байдаг. Хохирогч хүүхдийн кейсээс харахад урт хугацааны нөхөн сэргээх үйлчилгээ байхгүй, бэлгийн хүчирхийлэл тэр дундаа ураг төрлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг тусгаарлах, хамгаалал үйлчилгээ хангалтгүй байгаа нь судалгааны үр дүнгээс харагдсан.



### Шигтгээ 3. Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх байгууллагууд ба тэдний чиг үүрэг

...Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх түр хамгаалах байр Засгийн газрын 31-р тогтоолоор байгуулагдаад ажиллаж байна. Хүүхдийн тусламжийн 108 утас, Өнөр бүл хүүхдийн төв, олон улсын хүүхдийн Найрамдал төв нь ГБХЗХГ-ын харьяанд байдаг. Агентлаг нь бодлогын таван газартай. Хяналт шинжилгээ үнэлгээ, Төрийн захиргаа удирдлагын газар, Мэдээлэл технологийн газар, Хүүхдийн эрхийн хэрэгжилтийн газартай. Хүүхэд хамгааллын кэйс менежмент хариуцсан мэргэжилтний албан үүрэгт бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдүүдтэй харилцах чиг үүрэг багтсан байдаг.

*Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын төлөөлөлтэй хийсэн ярилцлагын хэсгээс...*

Сүүлийн жилүүдэд насанд хүрээгүй хүний бэлгийн эрх чөлөөний эсрэг үйлдэгдэж буй гэмт хэргийн өсөлт, шалтгаан нөхцөлийг дараах байдлаар дурджээ. Тухайлбал,

- Цагдаагийн байгууллагад бүртгэгдэж байгаа хүчиндэх гэмт хэргийн тоо тасралтгүй өсөж байгаа ба ялангуяа сүүлийн 3 жилийн хугацаанд огцом өсөж, ойролцоогоор өдөрт 1 хэрэг бүртгэгдэн, шалгагдаж байна. Хохирогчдын 80% орчим нь 10-29 насны охид, залуу эмэгтэйчүүд, 46.8% нь 8-17 насны охид байна<sup>15</sup>.
- Мөн хүчиндэх гэмт хэргийн гаралт нь орон нутагт 2017 онд 48.4 хувь, 2018 онд 48.0 хувиар өсжээ. Хүчирхийлэл үйлдэгчийн төрсөн болон өссөн, боловсрол эзэмшсэн нутаг дэвсгэрийг нь авч үзвэл 70 орчим хувь нь орон нутгийн иргэд байгаа бол Улаанбаатар хотын харьяалалтай байх нь харьцангуй цөөн байна. Гэмт хэрэг үйлдэгдсэн нутаг дэвсгэрийн хувьд Улаанбаатар хотод 34 буюу 50.0 хувь, баруун бүсэд 3 буюу 4.4 хувь, зүүн бүсэд 13 буюу 19.1 хувь, хангайн бүсэд 2 буюу 2.9 хувь, төвийн бүсэд 16 буюу 23.5 хувийг эзэлж байна.
- Цагдаагийн байгууллагад хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 12.1-12.6 дугаар зүйл) 2019 онд 610, 2020 онд 505, 2021 онд 540 нь гэмт хэрэг бүртгэгдсэн. Үүнээс хүчиндэх гэмт хэрэг нь 2019 онд 481, 2020 онд 401, 2021 онд 439 улсын хэмжээнд бүртгэгдсэн байна<sup>16</sup>. 2020 онд хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас хохирсон 502 хүний 79.3 хувь (398 хүн) нь эмэгтэй, 66.3 хувь (333 хүн) нь 18 хүртэлх насны хүүхдүүд байна<sup>17</sup>.
- НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн UPR III циклд энэ асуудлаар тусдаа бие даасан тайланд<sup>18</sup>

14 www.vip76.mn

15 Б.Энхболд, С.Гантулга, Б.Мөнхзул "Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэгт ял оногдуулж буй байдалд хийсэн дүн шинжилгээ" тайлан, 2019 он

16 Police.gov.mn

17 BookLibraryDownload.ashx (1212.mn)

18 Нээлттэй нийгэм хүрээлэн, Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэгт хүргүүлсэн хөндлөнгийн тайлан, 2019 он, Улаанбаатар хот, хуудас 11

насанд хүрээгүй, бага насны хүүхэд ялангуяа охидын эсрэг хүчиндэх гэмт хэрэг үүнд ураг төрлийн бэлгийн хүчирхийлэл нэмэгдэж байгаа ч энэ төрлийн гэмт хэрэгт өртөж буй бага насны хүүхэд, ялангуяа охидын эрхийг хамгаалах эрх зүйн орчин дутмаг байна гэж тайлагнажээ. Мөн ураг төрлийн болон таньдаг хүндээ хүчиндүүлсэн тохиолдолд хуулийн байгууллагад мэдээлдэггүй, мэдээлсэн ч томчууд хоорондоо “тохиролцоод” хүүхэд хохироод үлддэг асуудал байсаар байгаа нь хохирогчийн эрх ашгийг бүрэн төлөөлж чадаж байгаа эсэхэд эргэлзээ төрүүлж байгааг УЕПГ-ын 2019 оны судалгааны үр дүн харуулжээ. Бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 30 хувиар өссөн албаны статистик байгаа ч ихэнх тохиолдолд хохирогчид хуулийн байгууллагад хандахгүй өнгөрөөх, хандсан ч хэрэгсэхгүй болгох, өргөдлөө татаж авах, тохиролцох зэргээр асуудал орхигдож байгаа талаар тус тус дурдсан байна.

Дээрхээс дүгнэхэд Монгол Улсад бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг жилээс жилд нэмэгдэж байгааг харуулахын зэрэгцээ бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэрэгт охид, өсвөр насны хүүхдүүд илүүтэй өртөж байна. Иймээс энэ төрлийн гэмт хэргийг эрт илрүүлэх, хохирогч/даван туулагчийг хамгаалах, тэдэнд хариу үйлчилгээ үзүүлэх үйлчилгээг хөгжүүлэх, салбар дундын хамтын ажиллагааг бэхжүүлэх шаардлага байгааг харуулж байна.

### 2.1.2. Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэргийн хохирогч/даван туулагч хүүхдэд хариу үйлчилгээ үзүүлэх холбоотой эрх зүйн зохицуулалт, тулгамдаж буй асуудал

Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой гол хуульд 2012 оны Хүн худалдаалахтай тэмцэх тухай<sup>19</sup>, 2015 оны шинэчилсэн Эрүүгийн хууль, 2016 оны Хүүхдийн эрхийн тухай<sup>20</sup>, Хүүхэд хамгааллын тухай<sup>21</sup>, 2017 оны Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай<sup>22</sup>, 2017 оны Зөрчлийн тухай хууль тогтоомжийг нэрлэхээр байна. Ингэснээр хүүхдүүдийн хуулиар олгогдсон эрүүл, аюулгүй орчинд амьдрах, хамгаалуулах, сурч боловсрох, хөгжих, нийгмийн амьдралд оролцох эрх, эрх чөлөөг хангахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн юм. (Хүснэгт 6).

#### Хүснэгт 6. Хүүхэд хамгааллын үйлчилгээний эрх зүйн орчин

Хүүхэд хамгааллын үйлчилгээтэй холбоотой зүйл заалтууд	
Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль <sup>23</sup>	<p>Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн асуудал хариуцсан захиргааны төв байгууллага нь тус хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дэх хэсэгт заасан ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих, <b>хохирогчийг хамгаалах, халамж, үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг</b> бүхий төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжих, туслалцаа үзүүлэх;</p> <p>Хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь <b>хүн худалдаалахад өртөх эрсдэлтэй хүүхдийг хамгаалах</b>, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулж, сургалт, судалгаа, хяналт шинжилгээ, үнэлгээ хийн улсын хэмжээнд цаашид авах арга хэмжээний санал боловсруулах үүрэгтэй.</p> <p>Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдэд хуулийн 12 дугаар зүйлд <b>Хохирогчид үзүүлэх халамж, үйлчилгээг</b> тусгасан ба эрүүл мэндийн нөхөн сэргээх эмчилгээ, сэтгэцийн нөхөн сэргээх эмчилгээ, ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах, хууль зүйн туслалцаа, гадаад улсад хохирогч болсон Монгол Улсын иргэнийг эх оронд буцаан авчрах зэрэг <b>үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлэх</b> зохицуулалттай.</p>

19 Төрийн мэдээллийн эмхэтгэл, 2012, №7

20 Төрийн мэдээллийн эмхэтгэл, 2016, №9

21 Төрийн мэдээллийн эмхэтгэл, 2016, №9

22 Төрийн мэдээллийн эмхэтгэл, 2017, №5

23 Төрийн мэдээллийн эмхэтгэл, 2012, №7

Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль <sup>24</sup>	Хүүхдийг эрүүл, аюулгүй орчинд харах үйлчилгээг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулсан.
Хүүхдийн эрхийн тухай хууль <sup>25</sup>	Хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, бие махбодийн шийтгэл, сэтгэл санааны дарамт, үл хайхрах байдал болон мөлжлөгийн аливаа хэлбэрээс нийгмийн бүх орчинд хамгаалагдах эрх болон хүүхэд эрхээ зөрчсөн тохиолдолд өөрөө болон итгэмжит төлөөлөгчөөр дамжуулан холбогдох байгууллагад хандан гомдол гарган шийдвэрлүүлэх эрхийг тус тус тусгажээ. Түүнчлэн эрх нь зөрчигдсөн хүүхдийн <b>дагнасан үйлчилгээгээр</b> хангаж, хамгаалах, нөхөн сэргээх, нийгмийн халамж, асрамжийн зэрэг шаардлагатай үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулахыг тус асуудлыг эрхэлсэн орон нутгийн байгууллагад үүрэгджээ.
Хүүхэд хамгааллын тухай хууль <sup>26</sup>	Эрсдэлт нөхцөлд байгаа, гэмт хэргийн хохирогч болсон, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, ял шийтгүүлж, албадлагын арга хэмжээ авагдсан, сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан хүүхдийг нийгэмд хэвийн амьдрахад нь тусалж, дэмжих чиглэлээр <b>хариу үйлчилгээг</b> үзүүлэхээр заасан. Хариу үйлчилгээнд эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх, аюулгүй байдлыг хангах, дэмжих, холбон зуучлах, нийгмийн харилцаанд дасган зохицуулах, эргэн нэгтгэх үе шат бүхий үйл ажиллагааг хамруулна. Эдгээр үйлчилгээг төрийн байгууллага эсхүл тухайн чиглэлээр мэргэшсэн иргэн, <b>магадлан итгэмжлэгдсэн</b> <sup>27</sup> хуулийн этгээд төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх замаар үзүүлнэ. Үйлчилгээ үзүүлж байгаа төрийн байгууллага болон хуулийн этгээд тусгайлан бэлтгэгдэж, мэргэшсэн хүний нөөцтэй байна
Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль <sup>28</sup>	Гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, хохирогч, түүний гэр бүлийн бусад гишүүний амь нас, эрүүл мэнд, <b>аюулгүй байдлыг хангах, үйлчилгээ үзүүлэх</b> , урьдчилан сэргийлэх тогтолцоо, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоож өгсөн. Тус хуулийн 4-р бүлэгт <b>хүүхдийг гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах тусгай зохицуулалтыг</b> хуульчилан өгсөн. Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогчийн эрхийг Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд зааснаар хангахаар тусгажээ.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль<sup>29</sup> зааснаар бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдийг хамгаалах зохицуулалтыг тусгахдаа хүүхэд хохирогч болсон бол цагдаагийн байгууллага, хамгаалах байрны ажилтан нь түүний эцэг, эхийг нэн даруй олж тогтоох, хохирогч хүүхдийг эцэг, эхийг олж тогтоогоогүй тохиолдолд түүнийг асран хамгаалах, харгалзан дэмжих этгээдийг тухайн сум, дүүргийн Засаг дарга томилох үүрэгтэй. Хохирогч хүүхдийг хамгаалах байранд байрлуулахдаа насанд хүрсэн хохирогчоос тусад нь байрлуулна. Хохирогч хүүхдийг сургуульд хамруулах үүргийг тухайн сум, дүүргийн Засаг дарга хариуцах зохицуулалтыг тус тус тусгажээ.

24 Төрийн мэдээллийн эмхэтгэл, 2015 он, №28

25 Төрийн мэдээллийн эмхэтгэл, 2016, №9

26 Төрийн мэдээллийн эмхэтгэл, 2016, №9

27 Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэг дэмжих, холбон зуучлах үйлчилгээг явуулахад магадлан итгэмжлэлд хамрагдах зохицуулалттай. Энэ ч хүрээнд энэхүү магадлан итгэмжлэлийн журам 2021 онд дахин батлагдсан.

28 Төрийн мэдээллийн эмхэтгэл, 2017, №5

29 Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 3.1.1. “хүн худалдаалах” гэж хүнийг **биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, хууль бусаар албадан хөдөлмөрлүүлэх, эс, эд эрхтнийг нь авч ашиглан мөлжих зорилгоор хүнд хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, түүнчлэн өөр хүнийг хяналтдаа байлгаж байгаа этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлөх, хахуульдах аргаар хүнийг элсүүлсэн, тээвэрлэсэн, нуун далдалсан, дамжуулсан, хүлээн авсан хууль бус үйлдлийг;**



#### Шигтгээ 4. Хохирогч даван туулагчид үйлчилгээ үзүүлэх бүрэлдэхүүн

...Ядаж Улаанбаатар хотын хэмжээнд зөвхөн энэ төрлийн асуудалд үйлчилгээ үзүүлдэг нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, цагдаа, хамгаалах байрны ажилтан, эрүүл мэндийн ажилтан гэх мэт бүрэлдэхүүнтэй хохирогч/даван туулагчдад үйлчилгээ үзүүлдэг нэгж байгаасай гэж хүсдэг.

*Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын төлөөлөлтэй хийсэн ярилцлагын хэсгээс...*

Бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдийг хамгаалах байранд байрлуулахад насанд хүрсэн хүнээс тусад нь байрлуулах хуулийн зохицуулалттай. Гэтэл өнөөдрийн байдлаар энэ төрлийн гэмт хэргийн хохирогч хүүхдийг байрлуулах дагнасан тусгай хамгаалах байр байхгүй байгаа талаар ганцаарчилсан ярилцлагад оролцогчид илэрхийлж байсан.


**Хүүхэд хамгааллын тухай хууль**, хуулийг даган гарсан журмууд нь төрийн байгууллагуудын чиг үүрэг, салбар дундын хамтын ажиллагаа, зохион байгуулалтыг тодорхой болгосны зэрэгцээ хохирогчдод хариу үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчинд ахиц дэвшил багагүй гарсан. Тус хуулийн 10 дугаар зүйлд Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг хуульчилсан. Үүнд:

#### Хүснэгт 7. Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний тухай зүйл заалт

Хариу үйлчилгээ	Хэн, ямар үйлчилгээ үзүүлэх
Мэдээлэл хүлээн авах, илрүүлэх, шалгах	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчил, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар ирүүлсэн мэдээ, мэдээллийг нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтан, хамтарсан баг, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хууль сахиулагч хүлээн авч шалгаж, шаардлагатай арга хэмжээ авна.  Мэдээ, мэдээллийг хүлээн авах, илрүүлэх зорилгоор яаралтай тусламжийн 24 цагийн утас ажиллуулна.
Нөхцөл байдлын үнэлгээ хийх	Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх зорилгоор нөхцөл байдлын үнэлгээ хийнэ. Үнэлгээ нь хүүхдийн амьдарч байгаа орчин, хүүхдэд үүссэн нөхцөл байдал, хүүхдийн эрхийн эсрэг үйлдэл, эс үйлдэхүйн аюул, эрсдэлийн түвшнийг үнэлэх, шалгах, дүгнэх үе шаттай.  Эрсдэлд байгаа хүүхдэд нөхцөл байдлын үнэлгээ хийх журмыг гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Хууль зүйн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүнтэй хамтран батална.
Аюулгүй байдлыг хангах	Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ үзүүлэх санал, дүгнэлтийг хамтарсан баг, нийгмийн ажилтан гаргана. Тухайн шийдвэрийн хэрэгжилтэд хүүхдийн эрхийн ажилтан хяналт тавина.  Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний стандартыг тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, үйлчилгээ үзүүлэх журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
Дэмжих, холбон зуучлах	Нөхцөл байдлын үнэлгээгээр хүүхдэд тусламж, үйлчилгээ үзүүлэх дүгнэлт гарсан бол иргэний бүртгэл, сэтгэл зүй, хууль зүй, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн болон бусад шаардагдах үйлчилгээнд нийгмийн ажилтан холбон зуучилна.  Холбон зуучлах үйлчилгээний хэрэгжилтэд хүүхдийн эрхийн ажилтан хяналт тавина.

Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйлчилгээ үзүүлэх	Аймаг, дүүргийн Засаг дарга орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралтай зөвшилцөн хүүхдийн эрхийн хууль зүйн хороог байгуулах ба тус хорооны ажлын албаны үүргийг орон нутгийн хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн байгууллага хэрэгжүүлнэ.
Гэр бүлд нь эргэн нэгтгэх	Нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтан хүүхэд асрах хувилбарт болон төвлөрсөн асрамжийн үйлчилгээнээс хүүхдийг гэр бүлд нэгтгэх үйл ажиллагааг зохион байгуулж хяналт тавина.

Эдгээр үйлчилгээг төрийн байгууллага эсхүл тухайн чиглэлээр мэргэшсэн иргэн, магадлан итгэмжлэгдсэн<sup>30</sup> хуулийн этгээд төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх замаар үзүүлнэ. Үйлчилгээ үзүүлж байгаа төрийн байгууллага болон хуулийн этгээд тусгайлан бэлтгэгдэж, мэргэшсэн хүний нөөцтэй байхыг шаарддаг.

 Шигтгээ 5. Хүүхэд хамгааллын үйлчилгээний санхүүгийн байдал

...Магадлан итгэмжлэлд орсон байгууллагын хувьд гэрээгээр үйлчилгээ үзүүлээд байхад үйлчилгээний зардал, санхүүгийн асуудлыг цаг хугацаанд нь шилжүүлдэггүй. Мөн үйлчилгээний зардал маш бага байдаг. Хүний нөөцийн зардал байдаггүй.

*Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын төлөөлөлтэй хийсэн ярилцлагын хэсгээс...*

Хуулийн хүрээнд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг заавал магадлан итгэмжлэлд хамрагдсан байгууллага эрхлэн явуулах зохицуулалттай. Энэ ч хүрээнд 2016 онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/330 тоот тушаалын хавсралтаар ‘Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх магадлан итгэмжлэл журам’<sup>31</sup>-ыг анх баталсан. 2021 оны 12-р сарын 24-нд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/210 тоот тушаалаар шинэчилсэн Хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэх хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх журмыг баталжээ. Журамд орсон өөрчлөлтийг харьцуулсан хүснэгтийг Хавсралт 1-ээс дэлгэрүүлэн үзнэ үү.

Тус журамд орсон өөрчлөлтөөс тоймлон харахад:

1. 2021 оны журмын зорилго илүү өргөн хүрээтэй болсон. Тухайлбал, Хүүхдийн эрхийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6 дах хэсгийг үндэслэн Хохирогчид үйлчилгээ үзүүлэх төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх журам нь зорилгод багтсан байна.
2. 2021 оны журамд магадлан итгэмжлэх орон тооны бус зөвлөл 9 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд Зөвлөлийн бүрэлдэхүүнийг хүүхэд, гэр бүл хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. 2016 оны журамд тус зөвлөлийн бүрэлдэхүүнийг гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын тушаалаар батлах зохицуулалттай байжээ.
3. Төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэл шалгуур үзүүлэлтийг 80 ба түүнээс дээш хувийг хангасан байгууллагад 2 жилийн хугацаанд олгох зохицуулалтыг 2021 оны журамд тусгасан. 2016 оны журамд шалгуур үзүүлэлтийг 90 ба түүнээс дээш хувийг хангасан байвал итгэмжлэл олгох зохицуулалттай байсныг бууруулсан байна.
4. 2021 оны журамд шинэ зохицуулалт орж ирсэн ба тэр нь хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын эрх, үүргийн тусгайлан тусгаж өгчээ.

30 Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэг дэмжих, холбон зуучлах үйлчилгээг явуулахад магадлан итгэмжлэлд хамрагдах зохицуулалттай. Энэ ч хүрээнд энэхүү магадлан итгэмжлэлийн журам 2021 онд дахин батлагдсан.

31 2021 оны 12-р сарын 24-д хүчингүй болгосон.

Эндээс дүгнэхэд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэхдээ илүү нарийвчилсан харилцааг зохицуулж, улмаар орон тооны бус зөвлөлийн гишүүдийг нэмэгдүүлж, тэдгээрийн ажиллах журмыг Засгийн гишүүн батлах зохицуулалттай болсон. Энэ нь хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэхэд байгууллага нь илүү мэргэшсэн, тогтвортой, үйлчилгээг хүртээмжтэй, хариуцлагатай хүргэхэд анхаарч буй илэрхийлэл юм.



#### Шигтгээ 6. Хүүхэд хамгааллын үйлчилгээг хүртээмжтэй байлгах санал

...Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн асуудлаар салбар дундын уялдаа холбоог хангах чиглэлээр бодлогын түвшинд ажиллах, нөлөөлөх, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар манлайлан бусад яам, хэрэгжүүлэгч агентлаг, хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагуудыг татан оролцуулдаг байх хэрэгтэй байна.

*Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын төлөөлөлтэй хийсэн ярилцлагын хэсгээс...*

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль<sup>32</sup> нь хохирогч төвтэй хандлагад суурилсан, төрийн захиргааны болон гүйцэтгэх байгууллагуудын чиг үүргийг тодорхой болгохын зэрэгцээ салбар дундын хамтын ажиллагаа, зохион байгуулалтыг зохицуулсан, хохирогчийг хамгаалах үйлчилгээг нэг дороос үзүүлэх Нэг цэгийн үйлчилгээний төв (НЦҮТ), Түр хамгаалах байр (ТХБ)-ыг бий болгох, хохирогчид долоон төрлийн үйлчилгээг төрөөс үнэ төлбөргүйгээр үзүүлэхээр хуульчилж өгснөөр онцлог юм. Хамтарсан багийн<sup>33</sup> зохион байгуулалтыг анхан шатны нэгж болох хороо, сум, багт анх удаа бий болгосон. 2021 оны байдлаар Монгол Улсын хэмжээнд нийт 715 багийн 6,065 гишүүнтэй хамтарсан баг<sup>34</sup> ажиллаж байна. Мөн НЦҮТ, ТХБ бий болсноор хохирогчийг хамгаалах үйлчилгээг нэг дороос үзүүлэх, авах боломжийг бүрдүүлсэн.

2021 онд НҮБ-ын Тусгай илтгэгчийн тайланд Монгол Улсын хэмжээнд төрийн болон иргэний нийгмийн байгууллагууд хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төв байгуулж одоогийн байдлаар нийт 323 ортой 38 нэгж байгуулагдсан байна<sup>35</sup> гэжээ. Харин Азийн хөгжлийн банкны захиалгаар хийгдсэн “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эсрэг үйлдэгдэж буй гэр бүлийн хүчирхийллийн талаарх чанарын судалгаа” тайланд үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа Нэг цэгийн үйлчилгээний төв, Түр хамгаалах байрны тоог нийтдээ 41 гэж дурдсан байна. Хүснэгт 5-ыг харна уу.

**Хүснэгт 8.** Үндэсний хэмжээд үйл ажиллагаа явуулж буй түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн тоо, 2020 оны 10 сарын байдлаар

Байгууллагын төрөл	Түр хамгаалах байр	НЦҮТ
Эрүүл мэндийн байгууллагад түшиглэсэн	0	3
Цагдаагийн байгууллагад түшиглэсэн	4	2
Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газарт түшиглэсэн	17	13
Төрийн бус байгууллагад түшиглэсэн	2	0
<b>Нийт</b>	<b>23</b>	<b>18</b>

Үйлчилгээ үзүүлэгч төрийн байгууллагын мэргэжилтнүүдийн хувьд бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэрэгт өртсөн хохирогч хүүхдийг НЦҮТ, ТХБ-д хүлээн авч түр хамгаалалтад

32 Төрийн мэдээллийн эмхэтгэл, 2017, № 5

33 Хамтарсан багт тухайн сум, хорооны Засаг даргаар ахлуулан өрхийн эмч, сум, хороо, сургуулийн, халамжийн, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн нийгмийн ажилтан, цагдаагийн алба хаагч, энэ чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагын төлөөллийн бүрэлдэхүүнтэй.

34 Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн мэдээлэл

35 НҮБ-ын Хүний эрхийн тусгай илтгэгч Рийм Алсалем 2021 оны 11 дүгээр сарын 29-с 12 дугаар сарын 08-д ажилласан урьдчилсан ажиглалт, санал зөвлөмжийн тайлан

авдаг бөгөөд зарим тохиолдолд урт хугацааны нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулах зорилгоор үйлчилгээ үзүүлэгч ТББ-руу шилжүүлдэг гэв.



### Шигтгээ 7. Хохирогчид/даван туулагчдыг хүлээн авч байрлуулах байр

...Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн хохирогчид/даван туулагчдыг байрлуулдаг газар гэж тусдаа байх хэрэгцээ байдаг. Одоо байгуулагдсан газрууд бүгд гэр бүлийн хүчирхийллийн хохирогч/даван туулагчдад илүүтэй үйлчилгээ үзүүлдэг.

*Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын төлөөлөлтэй хийсэн ярилцлагын хэсгээс...*

Төслийн хүрээнд сонгогдсон дүүргүүд болох Сүхбаатар, Баянзүрх, Баянгол, Чингэлтэй дүүргүүдэд НЦҮТ болон ТХБ байдаг ба харин Сонгинохайрхан дүүргийг хувьд одоогоор Түр хамгаалах байр байхгүй байна. Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр тус дүүрэгт Түр хамгаалах байр баригдаж байгаа талаарх мэдээлэлтэй байлаа.

Дээрх хүүхдийн хамгааллын тогтолцоо, хариу үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой эрх зүйн орчны талаар товч дурдсан. Эдгээр хууль тогтоомж, журмыг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг чанарын ярилцлагад хамрагдсан нийт 63 үйлчилгээ үзүүлэгч байгууллагын төлөөллөөс тодруулахад дараах зүйлсийг дурджээ. Тухайлбал,

- 2016 оны Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4.1.5 дах хэсэг буюу Хамтарсан баг гэж гэр бүлийн болон бусад орчинд үйлдэгдсэн хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчил, эрсдэлт нөхцөлд хариу үйлчилгээг үзүүлэх анхан шатны нэгж гэсэн зохицуулалтыг 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдөр хүчингүй болсонд тооцсон. Улмаар тус зохицуулалтыг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан Хамтарсан багийн зохицуулалтад хамааруулах болсон. Ингэснээр зөвхөн гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд хамгааллын асуудалд Хамтарсан баг ажиллаж байна.
- Урт хугацааны нөхөн сэргээх үйлчилгээ, сэтгэл заслын үйлчилгээнд хохирогчийг хамруулахаар мэргэжлийн төрийн бус байгууллага руу шилжүүлэх шаардлага гардаг. Гэтэл Хүүхэд хамгааллын хуулийн хүрээнд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх бол заавал магадлан итгэмжлэлд хамрагдсан байх шаардлага тавьдаг. Тэрхүү магадлан итгэмжлэл нь хэт өндөр шалгууртай.
- Нэг цэгийн үйлчилгээний төв, Түр хамгаалах байрууд бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэргийн хохирогч/даван туулагч хүүхдийг байрлуулах, хүлээн авах сонирхолгүй ба ихэвчлэн гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хүлээн авах тохиолдол байна.
- Урт хугацааны нөхөн сэргээх үйлчилгээг хэн, хаана, яаж үзүүлэх нь тодорхой бус.
- Холбон зуучлах үйлчилгээгээр хүүхдийн кейсийг шилжүүлэх тохиолдолд эргэн мэдээлэх үйл явц хангалтгүй байдаг.
- Салбар дундын хамтын ажиллагаа сул.
- Хүний нөөц тогтвортой бус, байнга өөрчлөгддөг. Үйлчилгээ үзүүлэх чиглэлээр ажиллаж буй мэргэжилтнүүдийн хувьд цалин урамшуулал багатай.

Эцэст нь дүгнэхэд, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль тогтоомжид хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалт тус тус тусгасан байна. Хууль тогтоомжийн хүрээнд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг кейсээс хамаарч тухайлбал, хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хүүхэд, эрсдэлт нөхцөлд байгаа, гэмт хэргийн хохирогч болсон, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, ял шийтгүүлж, албадлагын арга хэмжээ авагдсан, сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх

үйлчилгээний төрөл, хэлбэр, үе шат бүрийг тус тус хуульчилжээ. Ингэснээр хүүхэд бүрийг хамгаалалтад авах, эрх зүйн орчин бүрдсэн мэт боловч хууль тогтоомжийг хэрэгжүүлж буй мэргэжилтнүүдийн хувьд хүүхэд хамгааллын хууль тогтоомжийн хэрэгжилт дунд, хариу үйлчилгээ үзүүлэх тогтолцоо хангалтгүй, салбар дундын хамтын ажиллагаа өнөөг хүртэл бэхжээгүй байна гэж дүгнэсэн.

## 2.2 Хүүхэд хамгаалал, бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн талаарх сурагчдын ойлголт, мэдлэг

Энэхүү бүлэгт сурагч охидын хүүхэд хамгааллын талаарх ойлголт, мэдлэг болон урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний чанар, хүртээмжтэй холбоотой үр дүнг танилцуулах болно. Тиймээс энэхүү хэсэг нь сурагч охидоос авсан тоон болон чанарын мэдээлээс гадна, оролцогч талуудтай хийсэн ярилцлагын мэдээлэлд суурилсан болно. Ингэснээр төслөөс үр өгөөж хүртэгсэд төсөл хэрэгжсэнээр хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар сайжирсан эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх суурь ойлголт, мэдлэгтэй эсэхийг тодорхойлох ач холбогдолтой.

### 2.2.1 Хүүхэд хамгааллын талаарх ойлголт, мэдлэг

Аливаа эрсдэлт орчинд, аюултай нөхцөл байдалд хүүхэд өөрийгөө бүрэн хамгаалах чадваргүй байдаг. Тиймээс эцэг, эх, асран хамгаалагчид, гэр бүлийн гишүүд, сургууль, цэцэрлэгийн удирдлагууд, багш, сурган хүмүүжүүлэгчид, нийгмийн ажилтнууд, баг, хороо, аймаг, дүүргийн хүүхэд хамгааллын байгууллагууд, цагдаа, хууль хяналтын байгууллагууд нийгмийн бүхий л орчинд хүүхдийг хамгаалах үүрэгтэй. Улаанбаатар хотын Баянзүрх, Сонгинохайрхан, Чингэлтэй, Баянгол болон Сүхбаатар дүүргүүдийн нийт 664 охиноос асуумж судалгаа авч, охид хүүхэд хамгааллын талаар хэр ойлголт, мэдлэгтэй байгааг үнэллээ. Ингэхдээ судалгаанд хамрагдсан 14 болон түүнээс доош насны охидыг дунд анги, 15 болон түүнээс дээш насны охидыг ахлах ангийн охид гэж бүлэглэв.




#### Шалгуур үзүүлэлт:

Төслийн зорилтын шалгуур үзүүлэлт: Сургуулийн удирдлага, багш, сурагчид бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийг багасгахад сургуулийн үүрэг, оролцоо, сургууль дээрх жендэрийн эрүүл, зөв орчныг төлөвшүүлэх арга замууд, үе тэнгийнхэн бие биеэ хамгаалах, урьдчилан сэргийлэх аргын тухай, хохирогч төвтэй арга зүйн талаар сургуулийн орчинд хүүхдийн эрхийн зөрчлийн гомдол гаргах зэрэг ойлголттой гэж оролцогчдын 38.3% нь тодорхойлсон байна.

Хүүхэд бусдаар хамгаалуулах хэрэгцээ шаардлагатай гэж үзсэн хувь дунд ангийн охидтой харьцуулахад ахлах ангийн охидод илүү байна. Судалгаанд хамрагдсан дунд ангийн 334 охидын 91.3% нь, ахлах ангийн 330 охидын 93.9% нь хүүхэд бусдаар хамгаалуулах хэрэгцээ, шаардлагатай гэж үзжээ. Хүүхэд бусдаар хамгаалуулах шаардлагатай гэж хариулсан өөрийн албан ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэйгээ хамт амьдардаггүй охидын эзлэх хувь асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэйгээ хамт амьдардаг охидын хариулттай харьцуулахад 1.3%-иар өндөр байна (Дүрс 5).



Дүрс 5. Хүүхэд бусдаар хамгаалуулах шаардлагатай эсэх талаарх охидын үзэл бодлын ялгаа, (n=664)



Өгөгдлийн эх сурвалж: Охидоос авсан нэр нуусан асуумж

Гэр хороололд амьдардаг охид хүүхэд хамгаалуулах шаардлагатай гэдэг ойлголт харьцангуй сул, нийтийн байранд амьдардаг охид эрсдэлт, аюултай нөхцөлд орж, хамгаалуулах шаардлагатай тулгарч байна. Дүрс 5-ын сүүлийн хоёр дүрслэлд амьдран суугаа газар, сууцны төрлөөс хамаарч хүүхэд бусдаар хамгаалуулах шаардлагатай эсэх талаарх охидын үзэл, бодлын ялгааг үзүүлэв. Хүүхэд бусдаар хамгаалуулах шаардлагатай гэж үзсэн охидын хувь байшин хороололд амьдардаг охидтой харьцуулахад гэр хороололд амьдардаг охидын хувьд харьцангуй бага байгаагаас гэр хороололд амьдардаг охид хүүхэд хамгаалуулах шаардлагатай гэдэг ойлголт харьцангуй сул байгааг илэрхийлнэ. Бие даасан тохилог хаус сууцанд амьдардаг охидын 87.5% нь хүүхэд бусдаар хамгаалуулах шаардлагатай гэж үзсэн байхад нийтийн байранд амьдардаг охид 100% хүүхэд бусдаар хамгаалуулах шаардлагатай гэж үзжээ. Эндээс харахад бие даасан тохилог хаус сууцанд амьдардаг охид эрсдэлт, аюултай орчин орж, хамгаалуулах хэрэгцээ шаардлага харьцангуй бага гардаг байхад нийтийн байранд амьдардаг охид эрсдэлт, аюултай нөхцөлд орж, хамгаалуулах шаардлага гарсныг батлан харуулж байна.

Хүүхдийг хэн хамгаалах талаар мэддэг охидын тоо харьцангуй цөөн байна. Монгол Улсын Хүүхэд хамгааллын тухай хуульд эцэг эх, ах эгч, гэр бүлийн гишүүд, найз нөхөд, хамаатан садан, цагдаа, хуулийн байгууллага, багш, нийгмийн ажилтан, цэцэрлэг/сургуулийн удирдлага, баг/хорооны нийгмийн ажилтан, хүүхдийн төлөө байгууллага, орон нутгийн хүүхэд хамгааллын хамтарсан баг бүгд гэр бүл, цэцэрлэг, сургууль, олон нийтийн болон цахим орчинд хүүхдийг

хамгаалах үүрэгтэй гэж заасан байдаг. Судалгаанд хамрагдсан нийт 620 охидын 6.7% нь л эдгээр бүх байгууллага хүүхдийг хамгаалах үүрэгтэй болохыг мэдэж байв.

Хүүхдийг хэн хамгаалах ёстой вэ гэсэн асуултад нийт 620 субъектийн 83% болон түүнээс дээш хувийг мэдэж байвал сайн мэддэг, 33.4-66.7%-ийг мэдэж байвал дунд, 33.3%-аас бага хувийг мэдэж байвал муу буюу мэдэхгүй байна гэж үнэллээ. Судалгаанд хамрагдсан охидын 51% нь хүүхдийг хэн хамгаалах талаар муу мэддэг, эсвэл бүр мэдэхгүй байгаа бөгөөд дөнгөж 11% нь энэ талын мэдлэг харьцангуй сайн байна.

Хамгаалах ёстой талуудыг нэрлэсэн байдлыг харахад, судалгаанд хамрагдсан сурагч охидын 96.3% нь эцэг эх, ах эгч, гэр бүлийн гишүүд, 47.9% нь багш, нийгмийн ажилтан, цэцэрлэг/сургуулийн удирдлага, 47.4% нь хуулийн байгууллага, 41.6% нь хүүхдийн төлөө байгууллага, орон нутгийн хүүхэд хамгааллын хамтарсан баг нь хүүхдийг хамгаалах ёстой гэж тус тус үзжээ.

**Хүснэгт 9.** Хүүхэд хамгаалах ёстой хүн мөн гэж үзсэн охидын хариулт, n=620



Өгөгдлийн эх сурвалж: Охидоос авсан нэр нуусан асуумж

Хүүхэд хамгааллын талаар ихэнх охид эцэг, эхээсээ мэдээлэл авдаг бол зарим нь 108 дугаарын утаснаас болон багшаасаа мэдээлэл авдаг гэж хариулжээ. Огт мэдээлэл авч байгаагүй гэж үзсэн охид ч цөөнгүй хувийг эзэлж байв. Асуумж судалгаанд хамрагдсан 664 охидын 8.1% нь аюултай, эрсдэлтэй байдалд орвол өөрийгөө хэрхэн хамгаалах талаар мэдээлэл, заавар, зөвлөгөөг хаанаас авахаа мэддэггүй гэж хариулсан байна. Мэддэг гэж хариулсан охидын (n=610) 78% нь эцэг, эхээсээ, 49.3% нь хүүхэд хамгааллын 108 дугаарын утас, 36.1% нь багшаасаа хичээлийн бус цагаар зөвлөгөө, заавар, мэдээлэл авдаг гэж хариулжээ. Хүснэгт 10-аас харахад охид орон нутгийн хүүхэд хамгааллын хамтарсан баг, холбогдох хичээл, баг/хорооны нийгмийн ажилтан, брошюр, танилцуулга, нугалбар зэрэг эх сурвалжаас зөвлөгөө, заавар, мэдээлэл авах нь ховор байна.

**Хүснэгт 10.** Аюултай, эрсдэлтэй байдалд орвол өөрийгөө хэрхэн хамгаалах талаар хаанаас мэдээлэл, заавар, зөвлөгөө авдаг мэдээллийн эх сурвалж

№	Эх сурвалж	Нийт 2336 хариултаас		Асуултад хариулсан 610 сурагчаас
		Давтамж	Эзлэх хувь	
1	Эцэг эх	481	20.5	78.0
2	Хүүхэд хамгааллын 108 утас	304	13.0	49.3
3	Багшаас хичээлийн бус цагаар	223	9.5	36.1
4	Хүүхдийн төлөө байгууллага	205	8.7	33.2
5	Сургуулийн нийгмийн ажилтан	194	8.3	31.4
6	Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл (ТВ, радио, цахим хуудас, нийгмийн сүлжээ: facebook, twitter г.м)	187	8.0	30.3
7	Ах эгч	174	7.4	28.2
8	Найз нөхөд	171	7.3	27.7
9	Сургуулийн орчин	148	6.3	24.0
10	Орон нутгийн хүүхэд хамгааллын хамтарсан баг	81	3.5	13.1
11	Холбогдох хичээл	76	3.2	12.3
12	Баг/хорооны нийгмийн ажилтан	50	2.1	8.1
13	Брошюр, танилцуулга, нугалбар	18	0.8	2.9
14	Цэцэрлэгийн эрхлэгч	14	0.6	2.3
15	Бусад	10	0.4	1.6
	<b>Нийт</b>	<b>2336</b>	<b>100.0</b>	

Өгөгдлийн эх сурвалж: Охидоос авсан нэр нуусан асуумж

Охидын дийлэнх нь гэр бүл, сургуулийн орчинд аюултай, эрсдэлт нөхцөл үүсэхэд өөрийгөө хэрхэн хамгаалах талаар мэддэг гэж үзжээ. Харин гудамж, талбай, олон нийтийн газар, интернэт, цахим орчинд эрсдэл үүсвэл өөрийгөө хэрхэн хамгаалах талаар охидын мэдлэг хангалтгүй байна. Монгол Улсын Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан гэр бүл, сургууль, гудамж, талбай, олон нийтийн газар, интернэт, цахим орчинд ямар нэгэн аюултай нөхцөл байдал үүсвэл өөрийгөө хэрхэн хамгаалах талаар мэдлэгийг судалгаанд хамрагдсан охидоор үнэлүүлж, үр дүнг Хүснэгт 11-д үзүүлэв.

**Хүснэгт 11.** Аюултай нөхцөл байдлаас өөрийгөө хэрхэн хамгаалах талаар мэдлэгээ үнэлсэн охидын өөрийн үнэлгээ, n=664

Орчин	Сайн		Дунд		Муу		Мэдэхгүй	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Гэр бүлд	228	34.3	389	58.6	31	4.7	16	2.4
Сургууль дээр	222	33.4	354	53.3	69	10.4	19	2.9
Гудамж, талбай, олон нийтийн газар	150	22.6	311	46.8	158	23.8	45	6.8
Интернэт, цахим орчинд	322	48.5	225	33.9	95	14.3	22	3.3

Өгөгдлийн эх сурвалж: Охидоос авсан нэр нуусан асуумж

Гэр бүлийн орчинд аюултай нөхцөлөөс өөрийгөө хэрхэн хамгаалах талаар Дунд ангийн охидын 8%, харин ахлах ангийн охидын 6% мэдэхгүй, эсвэл муу мэднэ гэж хариулжээ. Харин сургуулийн орчинд аюултай нөхцөлөөс өөрийгөө хэрхэн хамгаалах талаар мэдлэг, ойлголтод насны ялгаа харагдсангүй. Тодруулбал, 12-14 насны 334 охидын 14% нь энэ талаар мэдэхгүй, эсвэл муу мэднэ гэж хариулсан байхад 15-18 насны 330 охидын 13% нь мөн ингэж хариулжээ.

*Гудамж, талбай, олон нийтийн газар* аюултай нөхцөлөөс өөрийгөө хэрхэн хамгаалах талаар мэдлэг, ойлголтод насны ялгаа мөн харагдсангүй. Тодруулбал, 12-14 насны 334 охидын 30.8% нь, 15-18 насны 330 охидын 30.3% нь мэдэхгүй, эсвэл муу мэднэ гэж хариулсан.


*Интернэт, цахим орчинд* 12-14 насны 334 сурагчийн 19.8% нь, 15-18 насны 330 охидын 15.5% нь аюултай нөхцөлөөс өөрийгөө хэрхэн хамгаалахыг мэдэхгүй, эсвэл муу мэднэ гэж хариулжээ.

Гудамж, талбай, олон нийтийн газар, интернэт, цахим орчинд эрх нь зөрчигдөж, аюулгүй байдалд нөлөөлөх эрсдэлтэй зүйл тохиолдвол хэнд хандахаа мэдэхгүй охидын тоо харьцангуй олон байна. Гэр бүлийн орчинд хүүхдийн эрх зөрчигдөх, аюулгүй байдалд нөлөөлөх эрсдэлтэй зүйл тохиолдоход охидын 48% нь эцэг эх, ах эгч, гэр бүлийн хэн нэгэнд, 23% нь цагдаа, хуулийн байгууллагад, 11% нь хүүхдийн төлөө байгууллага, орон нутгийн хүүхэд хамгааллын хамтарсан багт тус тус хандана гэж хариулжээ. Харин сургуулийн орчинд эрсдэлтэй зүйл тохиолдвол, охидын 59% нь багш, нийгмийн ажилтан, цэцэрлэг/сургуулийн удирдлагад, үлдсэн хэсэг нь эцэг эх, ах эгч, гэр бүлийн гишүүд, цагдаа, хуулийн байгууллага, найз нөхөд, хамаатан садандаа хандана гэжээ. Гудамж, тайлбай, олон нийтийн газар эрсдэлтэй зүйл тохиолдвол охидын 53% нь цагдаа, хуулийн байгууллагад, үлдсэн хэсэг нь эцэг эх, ах эгч, гэр бүлийн гишүүд (19%), орчин тойронд ойр байгаа хэн нэгэнд (7%), хүүхдийн төлөө байгууллага, орон нутгийн хүүхэд хамгааллын хамтарсан баг (4%), баг/хорооны нийгмийн ажилтанд (4%), найз нөхөд хамаатан садандаа (3%) хандана гэсэн хариултыг өгсөн байна. Интернэт, цахим орчинд хүүхдийн эрх зөрчигдөх, аюулгүй байдалд нөлөөлөх эрсдэлтэй зүйл тохиолдвол охидын 42% нь эцэг эх, ах эгч, гэр бүлийн гишүүндээ, 31% нь цагдаа, хуулийн байгууллагад, 10% нь найз нөхөд, хамаатан садандаа, 6% нь хүүхдийн төлөө байгууллага, орон нутгийн хүүхэд хамгааллын хамтарсан багт хандана гэж хариулжээ.

Дээрх бүгдээс үзэхэд хүүхдийн эрх зөрчигдөх, аюулгүй байдалд нөлөөлөх эрсдэлтэй зүйл гэр бүлийн орчинд тохиолдвол охид эцэг эх, ах эгч, гэр бүлийн хэн нэгэнд гишүүнд хандах бол сургуулийн орчинд багш, нийгмийн ажилтан, цэцэрлэг/сургуулийн удирдлагад хандах төлөвтэй байна. Гудамж, талбай, олон нийтийн газарт бол цагдаа, хуулийн байгууллагад, интернэт, цахим орчинд бол эцэг эх, ах эгч, гэр бүлийн хэн нэгэн гишүүнд эсвэл цагдаа, хуулийн байгууллагад хандах төлөвтэй байна. Харин судалгаанд хамрагдсан охидын дунджаар 5% орчим нь хүүхдийн эрх зөрчигдөж, эрсдэлтэй байдалд орвол хэнд хандахаа мэдэхгүй байна гэж хариулсан байгааг төсөл анхааралдаа авч, үйл ажиллагаагаа чиглүүлэх хэрэгтэй байна. Тодруулбал, гэр бүлийн орчинд охидын 4%, сургуулийн орчинд охидын 3%, гудамж, талбай, олон нийтийн газарт охидын 6%, интернэт, цахим орчинд охидын 6% нь хэнд хандаж, тусламж хүсэхээ мэдэхгүй байна гэж хариулжээ.

**Дүрс 6. Хүүхдийн эрх зөрчигдөх, аюулгүй байдалд нөлөөлөх эрсдэлтэй зүйл тохиолдоход хамгийн түрүүнд хандаж, тусламж хүсэх субъект, n=664**

- Эцэг эх, ах эгч, гэр бүлийн гишүүд
- Цагдаа, хуулийн байгууллага
- Багш, нийгмийн ажилтан, цэцэрлэг / сургуулийн удирдлага
- Найз нөхөд, хамаатан садан
- Хэнд хандахаа мэдэхгүй байна.
- Хүүхдийн төлөө байгууллага, орон нутгийн хүүхэд хамгааллын хамтарсан баг
- Орчин тойрны хэн нэгэнд
- Баг/хорооны нийгмийн ажилтан
- Надад хамааралгүй тохиолдолд хэн нэгэнд хандах шаардлагагүй.



Өгөгдлийн эх сурвалж: Охидоос авсан нэр нуусан асуумж

Дүрс 5-аас харахад хүүхдийн эрх зөрчигдөх, аюулгүй байдалд нөлөөлөх эрсдэлтэй зүйл гэр бүлийн орчинд тохиолдвол охид эцэг эх, ах эгч, гэр бүлийн хэн нэгэнд гишүүнд хандах бол сургуулийн орчинд багш, нийгмийн ажилтан, цэцэрлэг/сургуулийн удирдлагад хандах төлөвтэй байна. Гудамж, талбай, олон нийтийн газарт бол цагдаа, хуулийн байгууллагад, интернэт, цахим орчинд бол эцэг эх, ах эгч, гэр бүлийн хэн нэгэн гишүүнд эсвэл цагдаа, хуулийн байгууллагад хандана гэжээ. Харин судалгаанд хамрагдсан охидын дунджаар 5% орчим нь хүүхдийн эрх зөрчигдөж, эрсдэлтэй байдалд орвол хэнд хандахаа мэдэхгүй байна гэж хариулсан байгааг төсөл анхааралдаа авч, үйл ажиллагаагаа чиглүүлэх хэрэгтэй байна. Тодруулбал, гэр бүлийн орчинд охидын 4%, сургуулийн орчинд охидын 3%, гудамж, талбай, олон нийтийн газарт охидын 6%, интернэт, цахим орчинд охидын 6% нь хэнд хандаж, тусламж хүсэхээ мэдэхгүй байна гэж хариулжээ.

Асуумж судалгаанд хамрагдсан нийт сурагч охидын 82% нь хүүхдэд тааламжтай, хүүхдийн эрхийг дээдэлж, нэр төрд халдахгүй, сэтгэл зүйд сөрөг нөлөөлөхгүй, нэмж эрсдэлд оруулахгүй, шударга зарчимд тулгуурлан эрхээ хамгаалуулах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн байна.

Дүрс 7. Хүүхэд хэн нэгнээр хамгаалуулахдаа чухалчлах зарчим, n=664



Өгөгдлийн эх сурвалж: Охидоос авсан нэр нуусан асуумж


Тиймээс хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлдэг мэргэжилтэн, байгууллагууд хүүхдүүдийн энэ хүсэл, хэрэгцээ, шаардлагад нийцсэн үйлчилгээ үзүүлэхэд илүү анхаарч, үйл ажиллагаагаа явуулах шаардлагатай байна.

### 2.2.2. Охидын бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн талаарх ойлголт мэдлэг, тусламж эрэлхийлэх зан үйл

Охидын дийлэнх нь бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн талаар ерөнхий мэдээлэлтэй хэдий ч ямар үйлдлийг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөг гэж ойлгох талаар гүнзгийрүүлсэн мэдлэгтэй охидын тоо харьцангуй цөөн байна. Судалгаанд хамрагдсан нийт 664 охидын 72.3% нь бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн талаар ерөнхий мэдлэгтэй гэж өөрийгөө үнэлсэн бол үлдсэн 28% нь мэдэхгүй гэж хариулжээ. Энэ хариултад охидын нас, амьдран сууж буй газар, сууцны төрөл, асран хамгаалагчтайгаа амьдардаг эсэх зэрэг нь нөлөөлсөн эсэхийг шинжилж, Дүрс 8-д үр дүнг нэгтгэн үзүүлэв. Дунд ангийн охидтой харьцуулахад ахлах ангийн охидын дийлэнх нь бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн талаар мэддэг байна. Өөрийн албан ёсны асран хамгаалагчтайгаа хамт амьдардаг охидын 71.8%, асран хамгаалагчтайгаа амьдардаггүй охидын 81.8% нь охидын эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн талаар мэднэ гэж хариулжээ. Иймд асран хамгаалагчтайгаа амьдардаггүй охид бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртөх эрсдэлтэй орчинд амьдардаг байж болзошгүй нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Амьдран сууж буй орон сууцны төрлөөс хамаарч, охидын хариултад ялгаа байгаа эсэхийг шинжлэхэд нийтийн байранд амьдардаг охидыг бие даасан тохилог сууц буюу хаусанд амьдардаг охидтой харьцуулахад бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн талаар мэднэ гэж хариулсан хувь нь даруй 24.5 пунктээр өндөр байв. Үүнээс гадна хүүхэд бүр бусдаар хамгаалуулах шаардлагатай гэж ухамсарласан охидын 74% нь, бусдаар хамгаалуулах шаардлагагүй гэж үзсэн охидын 51% нь бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн талаар мэднэ гэж хариулжээ.

**Дүрс 8.** Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн талаар мэддэг охидын эзлэх хувь, n=664



Өгөгдлийн эх сурвалж: Охидоос авсан нэр нуусан асуумж

Охид бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн талаар мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, сургуулийн орчин, эцэг, эхээсээ түлхүү авдаг байна. Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн талаар ойлголт, мэдлэгтэй гэж өөрийгөө үнэлсэн охидоос мэдээлэл авсан эх сурвалжийг тодруулахад 58.8% нь олон нийтийн мэдээллийн хэрэгслээс, 48.5% нь сургуулийн орчноос, 46.9% нь эцэг, эхээсээ, 28.5% нь найз, нөхдөөсөө, 19.6% нь ах эгчээсээ, үлдсэн хувь нь сургуулийн нийгмийн ажилтан, хүүхдийн төлөө ажилладаг төрийн бус байгууллага, хүүхдийн байгууллага, хүүхэд хамгааллын 108 утас, брошюр, танилцуулга, нугалбар, орон нутгийн хүүхэд хамгааллын хамтарсан баг, баг, хорооны нийгмийн ажилтан, цэцэрлэг, сургуулийн эрхлэгчээс мэдээлэл авдаг гэжээ.

**Хүснэгт 12.** Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн талаар мэдээлэл авдаг эх сурвалж, n=480


№	Эх сурвалж	Охидын тоо	Элэх хувь
1	Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл (ТВ, радио, цахим хуудас, нийгмийн сүлжээ: facebook, twitter г.м),	282	58.8
2	Сургууль	233	48.5
3	Эцэг эх	225	46.9
4	Найз нөхөд	137	28.5

5	Ах эгч	94	19.6
6	Сургуулийн нийгмийн ажилтан	58	12.1
7	Хүүхдийн төлөө ажилладаг төрийн бус байгууллага	54	11.3
8	Хүүхдийн байгууллага	48	10.0
9	Хүүхэд хамгааллын 108 утас	27	5.6
10	Брошюр, танилцуулга, нугалбар	23	4.8
11	Бусад	15	3.1
12	Орон нутгийн хүүхэд хамгааллын хамтарсан баг	12	2.5
13	Баг, хорооны нийгмийн ажилтан	6	1.3
14	Сургуулийн захирал	5	1.0

Өгөгдлийн эх сурвалж: Охидоос авсан нэр нуусан асуумж

Дүрс 9-өөс харахад сурагч охидын 57.7% нь 1-2 тооны эх сурвалжаас, 34% нь 3-4 тооны эх сурвалжаас мэдээлэл авдаг байна. 5 болон түүнээс олон тооны эх сурвалжаас мэдээлэл авдаг охидын эзлэх хувь 8.3%-ийг л эзэлж байв. Эндээс охид бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн талаар харьцангуй цөөн эх сурвалжаас мэдээлэл авдаг ба тэдний дийлэнх олонх нь ТВ, радио, цахим хуудас, нийгмийн сүлжээ: Facebook, Twitter гэх мэт олон нийтийн мэдээллийн хэрэгслээс эсвэл сургуулийн орчноос мэдээлэл авдаг нь харагдлаа.

**Дүрс 9.** Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн талаар мэдээлэл авдаг эх сурвалжийн тоо, n=480



Өгөгдлийн эх сурвалж: Охидоос авсан нэр нуусан асуумж

Дээр өгүүлсэнчлэн судалгаанд хамрагдсан нийт охидын 72.2% нь бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн талаар ерөнхий ойлголт, мэдлэгтэй гэж өөрийгөө үнэлсэн хэдий ч охидын 46.5% нь бэлгийн хүчирхийллийг илэрхийлэх үйлдлүүдийг, 30.1% нь бэлгийн мөлжлөгийг илэрхийлэх үйлдлүүдийг зөв нэрлэсэн байна. Эндээс охидын дунджаар 38.3% нь бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн талаар ойлголт, мэдлэгтэй гэж дүгнэж болно.

Нийт охидын 10% бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртөх эрсдэлтэй орчинд амьдарч байна. Танай гэр бүлийн орчинд бэлгийн хүчирхийлэл, мөлжлөг, дарамт шахалт тохиолдох эрсдэл хэр зэрэг байна вэ гэсэн асуултад судалгаанд хамрагдсан нийт охидын 90% нь огт байхгүй, 7% нь бага зэрэг, 2% нь дунд, 1% нь өндөр эрсдэлтэй гэж тус тус хариулжээ. Охидын насны онцлог, асран хамгаалагчтайгаа амьдардаг эсэхээс хамаарч энэ хариултад ялгаа байгаа эсэхийг шинжлэхэд ахлах ангийн охидоос нэг нь ч өндөр эрсдэлтэй гэж үнэлээгүй байхад дунд ангийн охидын 0.9% нь өндөр эрсдэлтэй гэж үнэлсэн байна (Хүснэгт 13).



**Хүснэгт 13.** Гэр бүлийн орчинд бэлгийн хүчирхийлэл, мөлжлөг, дарамт шахалт тохиолдох эрсдэлээ үнэлсэн охидын тоо, насны ангиллаар, n=664

Эрсдэлийн зэрэг	Огт байхгүй	Бага зэрэг	Дунд зэрэг эрсдэлтэй	Өндөр эрсдэлтэй
Нийт охид, n=664	90.0%	7.0%	2.0%	1.0%
12-14 нас, n=334	89.2%	8.4%	1.5%	0.9%
15-18 нас, n=330	91.8%	6.7%	1.5%	0.0%

Өгөгдлийн эх сурвалж: Охидоос авсан нэр нуусан асуумж

Асран хамгаалагчтайгаа амьдардаггүй охидыг өөрийн албан ёсны асран хамгаалагчтайгаа амьдарч буй охидтой харьцуулахад гэр бүлийн орчинд бэлгийн хүчирхийлэл, мөлжлөг, дарамт шахалтад орох эрсдэл өндөр байна. Асуумж судалгаанд хамрагдсан асран хамгаалагчтайгаа хамт амьдардаг охидын 90.8% нь гэр бүлийн орчинд бэлгийн хүчирхийлэл, мөлжлөг, дарамт шахалт огт байдаггүй гэж хариулсан нь өөрийн хууль ёсны асран хамгаалагчтайгаа амьдардаггүй охидын хариултаас даруй 6 пунктээр өндөр байна (Хүснэгт 14).


**Хүснэгт 14.** Асран хамгаалагчтай хамт амьдардаг эсэх байдлаас хамаарч гэр бүлийн орчинд бэлгийн хүчирхийлэл, мөлжлөг, дарамт шахалт тохиолдох эрсдэлээ үнэлсэн охидын тоо, n=664

Асран хамгаалагчтай хамт амьдардаг эсэх	Огт байхгүй	Бага зэрэг	Дунд зэрэг эрсдэлтэй	Өндөр эрсдэлтэй
Асран хамгаалагчтайгаа хамт амьдардаг, n=631	90.8%	7.3%	1.4%	0.5%
Асран хамгаалагчтайгаа хамт амьдардаггүй, n=33	84.8%	12.1%	3.0%	0.0%

Өгөгдлийн эх сурвалж: Охидоос авсан нэр нуусан асуумж

Судалгаанд хамрагдсан 664 охидын 382 нь буюу 57.5% нь ойр дотны найз, эгч, ах, дүү, хамаатан садан, танилууд дунд бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртөж байгаагүй, 27.9% нь өртөж байсан/өртөх дөхсөн, 14.6% нь энэ талаар мэдэхгүй гэж хариулжээ. Ойр дотны найз, эгч, ах, дүү, хамаатан садан, танилууд дунд бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртөж /өртөх дөхсөн гэж хариулсан охидын эзлэх хувь харьцангуй өндөр хувийн жин байгаа тул судалгааны багийн анхаарлыг ихээхэн татаж байна. Тиймээс охидын нас, асран хамгаалагчтайгаа хамт амьдардаг эсэх, амьдран сууж буй байршил зэргээс хамаарч энэ хариулт ялгаатай эсэхийг дэлгэрүүлэн шинжилж, үр дүнг Дүрс 10-д үзүүлээ.

**Дүрс 10.** Ойр дотнын найз, эгч, ах, дүү, хамаатан садан, танилууд дунд бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртөж байсан/өртөх дөхөж байсан гэж хариулсан охидын тоо, n=664



Асран хамгаалагчтайгаа хамт амьдардаггүй охидын 42.4% нь ойр дотны найз, эгч, ах, дүү, хамаатан садан, танилууд дунд бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртөж байсан/өртөх дөхөж байсан гэж хариулсан нь өөрийн асран хамгаалагчтайгаа амьдардаг охидын мөн хариултаас даруй 15.3 пунктээр өндөр байна. Энэ нь өөрийн асран хамгаалагчтайгаа амьдардаггүй охид бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртөх илүү магадлалтай орчинд амьдарч байгааг илтгэнэ. Амьдран сууж буй байршил, орчноос хамаарсан статистикийн ач холбогдолтой ялгаа ажиглагдсангүй.

Бусдыг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртөхөөс сэргийлэх, хамгаалахын тулд охид хэнд хандахаа төдийлөн сайн мэдэхгүй байна. Үе тэнгийнхэн бие биеэ хамгаалах, аливаа эрсдэл, аюулаас урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрхийн гомдол гаргах ойлголт, мэдлэгтэй эсэхийг үнэлэх зорилгоор охидоос найз охин, хамаатан, садны хэн нэгэн бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн тохиолдолд охид хаана, хэнд хандахыг тодруулав. Хүснэгт 15-с дүгнэхэд гурван охин тутмын хоёр нь эрсдэл, аюул тохиолдолд хамгийн түрүүнд эцэг, эх, асран хамгаалагчдаа ханддаг байна. Харин хоёр охины нэг нь хүүхдийн тусламжийн 108 утсанд мөн хоёр охины нэг нь цагдаад ханддаг аж. Хүүхэд хамгааллын хамтарсан баг, хүүхдийн төлөө ажилладаг ТББ, гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, сургуулийн удирдлага, багш, сургуулийн болон баг, хорооны нийгмийн ажилтан, баг, хорооны засаг даргад хандах охидын тоо харьцангуй цөөн байгаа нь тэд эдгээр хүмүүс, байгууллагад хандах боломжтойг мэдэхгүй байгаатай холбоотой. Эрсдэлтэй, аюултай нөхцөл байдал үүсэхэд хэнд хандахаа ч мэдэхгүй охидын эзлэх хувь нийт охидын 1.5% байгааг энд онцолъё.

**Хүснэгт 15.** Найз охин, хамаатан садны хэн нэгэн бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн тохиолдолд охидын хандах хүн, байгууллага, n=664


№	Хандах хүн	Давтамж	Эзлэх хувь
1	Эцэг эх, асран хамгаалагч	433	65.2
2	Хүүхдийн тусламжийн 108 утас	315	47.4
3	Цагдаа	311	46.8
4	Хүүхэд хамгааллын хамтарсан баг	152	22.9
5	Хүүхдийн төлөө ажилладаг ТББ	140	21.1
6	Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс/төв	91	13.7
7	Багш	81	12.2
8	Сургуулийн нийгмийн ажилтан	80	12.0
9	Ах эгч	77	11.6
10	Эмч	65	9.8
11	Найз нөхөд	64	9.6
12	Хамаатан садан	52	7.8
13	Өвөө/эмээ	25	3.8
14	Баг/хорооны нийгмийн ажилтан	17	2.6
15	Сургуулийн захирал	15	2.3
16	Баг/хорооны Засаг дарга	11	1.7
17	Мэдэхгүй	10	1.5
18	Өөрт хамаагүй тул хэн нэгэнд хандахгүй.	5	0.8

Өгөгдлийн эх сурвалж: Охидоос авсан нэр нуусан асуумж

Интернэт, цахим орчин, гудамж, талбай, олон нийтийн газарт охидын эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөг үйлдэгдэх магадлалтай гэж үзсэн охидын тоо харьцангуй олон байна.

Судалгаанд хамрагдсан охид охидын эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөг үйлдэгдэх магадлал хамгийн өндөр эрсдэлтэй орчин нь интернэт, цахим орчин, дараа нь гудамж, талбай, олон нийтийн газар гэж үзсэн. Интернэт, цахим орчинд илүү эрсдэлтэй гэж судалгаанд хамрагдсан таван дүүргийн охидын дунджаар 74.0% нь үзсэн бол Баянгол, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргийн охидын эзлэх хувь дунджаас дээгүүр байна. Гудамж, талбай, олон нийтийн газар илүү эрсдэлтэй гэж судалгаанд хамрагдсан таван дүүргийн охидын дунджаар 68.6% нь үнэлсэн бол Баянгол, Сонгинохайрхан дүүргийн охидын хариулт дунджаас өндөр байгааг анхаарч төслийн үйл ажиллагааг чиглүүлэх хэрэгтэй.

**Дүрс 11.** Охидын эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөг үйлдэгдэх магадлал өндөр орчин гэж үнэлсэн охидын тоо, дүүргээр, n=664



Өгөгдлийн эх сурвалж: Охидоос авсан нэр нуусан асуумж

**Шигтгээ 8.** Цахим орчинд охид бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртөх магадлал өндөр

...Энэ явдал яг надад тохиолдож байсан. Би өөрөөсөө ганц, хоёр ах хүнтэй цахимаар найзууд байж байгаад үерхдэг байсан. Тэр хүн рүүгээ өөрийнхөө зургийг явуулсан чинь тэр зургийг маань photoshop-оор янзлаад, хагас нүцгэн байдалтай болгоод над руу явуулчихсан байсан. Гэтэл тэр хүний фейсбүүкээр өөр хүн ороод тэр зургийг маань харчихаад над руу явуулж чиний зургийг чинь тараана, инстаграм дээр “Ариухан амьдар бузрууд аа” гэх хаяг руу явуулчихна шүү гэж сүрдүүлж байсан. Би тийм үйлдэл хийгээгүй хэдий ч надад маш дарамттай санагдаад 7 хоног хүнтэй харьцахгүй өөрийгөө тусгаарласан. Тэр хугацаандаа ер нь би тэгээгүй юм чинь гэж бодсон хэдий ч миний царайг эвлүүлчихсэн болохоор би юм шиг харагдаад хэцүү байсан учраас сэтгэл зүйч гэсэн фейсбүүк пейж хуудас руу хандаад, хариуцдаг хүнтэй нь холбогдож байсан. Тэр хүний хэлснээр бол энэ хэрэг нь насанд хүрээгүй хүнийг буруу үлгэр дуурайлал үзүүлж, уруу татсан хэргээр шүүхээр явах хэрэг гэсэн. Миний судалснаар шүүхээр явсан ч эмэгтэй талыг биш эрэгтэй талыг нь өмөөрсөн шийдвэр гардаг бөгөөд ямар нэгэн хүчирхийлэлд өртсөн охидыг буруутгадаг буюу тэр охин өөрөө л задгай байсан болохоор хүчирхийлэлд өртсөн гэх хандлагатай байдаг гэж сонсож байсан. Би одоо тэр явдлыг мартсан хэдий ч хааяа бодоход муухай санагддаг.

*ЕБС-ийн сурагчидтай хийсэн фокус бүлгийн ярилцлагаас*

Охидын үзэж байгаагаар эцэг, эх, асран хамгаалагчдын хараа хяналт сул байгаа нь охидыг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртөх эрсдэлийг нэмэгдүүлж байна. Охидын биеэ авч яваа байдал, бэлгийн болон ёс зүйн боловсрол, эрх зүйн боловсрол хангалтгүй, муу байгаа тохиолдолд охид бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртөхөд хүргэж байна. Судалгаанд хамрагдсан охидоос бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртөж буй шалтгааныг тодруулахад гэр бүлийн хараа хяналт

сул, гадаад төрх, биеэ авч явж буй байдал, цахим орчин дахь дарамт, сүрдүүлэгт өртөх охидод чиглэсэн бэлгийн болон ёс зүйн боловсрол, эрх зүйн боловсрол олгох мэдээлэл, сургалт хангалтгүй, хойд эцэг, эхтэй байх гэсэн таван хариулт хамгийн олон давтагдсан байна. Харин гэр бүл нь таагүй уур амьсгалтай, гэр бүлийн хэн нэгэн гишүүн нь архины хамааралтай байх, сургуулийн орчинд үе тэнгийнхний ялгаварлан гадуурхалт, дээрэлхэлтэд өртсөн байх, амьжиргааны түвшин доогуур, санхүүгийн боломжгүй байдал, эрт бэлгийн харилцаанд орсон байх зэрэг хариултыг таван охин тутмын нэг нь сонгосон байна. КОВИД-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалсан хэрэгжүүлж буй хөл хорио, зарим хязгаарлалтууд гэх мэт үйл ажиллагаа, хичээлдээ сонирхолгүй, сурлагадаа тааруу байх, шилжиж ирсэн орон нутагтаа бүртгэлгүй байх, биеэ хамгаалах чадваргүй зэрэг шалтгааныг харьцангуй цөөн охид сонгожээ.


**Хүснэгт 16.** Охид бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртөх магадлал үүсгэдэг шалтгааныг үнэлсэн охидын тоо, n=664

№	Шалтгаан	Давтамж	Эзлэх хувь
1	Гэр бүлийн хараа хяналт сул байх	369	55.6
2	Гадаад төрх, биеэ авч явж буй байдал	328	49.4
3	Цахим орчин дахь дарамт, сүрдүүлэгт өртөх	295	44.4
4	Охидод чиглэсэн бэлгийн болон ёс зүйн боловсрол, эрх зүйн боловсрол олгох мэдээлэл, сургалт хангалтгүй	285	42.9
5	Хойд эцэг эхтэй байх	276	41.6
6	Гэр бүл нь таагүй уур амьсгалтай, гэр бүлийн хэн нэгэн гишүүн нь архины хамааралтай байх	225	33.9
7	Сургуулийн орчинд үе тэнгийнхний ялгаварлан гадуурхалт, дээрэлхэлд өртсөн байх	199	30.0
8	Амьжиргааны түвшин доогуур, санхүүгийн боломжгүй байдал	133	20.0
9	Эрт бэлгийн харилцаанд орсон байх	130	19.6
10	КОВИД-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалсан хэрэгжүүлж буй үйл ажиллагаа (хөл хорио, зарим хязгаарлалтууд гэх мэт)	46	6.9
11	Хичээлдээ сонирхолгүй, сурлагадаа тааруу байх	44	6.6
12	Шилжиж ирсэн орон нутагтаа бүртгэлгүй байх	35	5.3
13	Хэлж мэдэхгүй байна.	23	3.5
14	Биеэ хамгаалах чадваргүй	13	2.0

Өгөгдлийн эх сурвалж: Охидоос авсан нэр нуусан асуумж

Охид бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртвөл бусдаас тусламж авч, хамгаалуулж чаддаггүй гэж үзсэн охидын тоо харьцангуй олон байна. Судалгаанд хамрагдсан нийт охидын 19.7% нь охид бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн үедээ хэн нэгнээс тусламж авч, хамгаалуулж чаддаг бол 58.6% чаддаггүй байна. Энэ нь охидыг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах, тэдэнд тусламж үзүүлэх үйл ажиллагаа маш хангалтгүй, дутмаг байгаатай холбоотой юм. Охид бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн үедээ хэн нэгнээс тусламж авч, хамгаалуулж чаддаггүй гэж үзсэн охидын эзлэх хувийг дүүргээр ангилж, Дүрс 12-д үзүүллээ. Зургаас харахад бүх дүүргийн хувьд охидын дийлэнх олонх нь охид бэлгийн хүчирхийлэл мөлжлөгт өртсөн үедээ тусламж авч, хамгаалуулж чаддаггүй гэж үзсэн ба Чингэлтэй дүүргийн охидын хариулт бусад дүүргээс харьцангуй доогуур байна.

**Дүрс 12.** Охид бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн үедээ хэн нэгнээс тусламж авч, хамгаалуулж чаддаггүй байх магадлалтай гэж үзсэн охидын эзлэх хувь



Өгөгдлийн эх сурвалж: Охидоос авсан нэр нуусан асуумж

Мэдээллийн нууцыг хадгалж, охидын нэр төрд сөргөөр нөлөөлөхгүйгээр хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэх шаардлагатай байна. Охид бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн үедээ хэн нэгнээс тусламж авч, хамгаалуулж чаддаггүй гэж хариулсан охидоос шалтгааныг судалгааны ажлын хүрээнд тодруулав. Дүрс 13-аас харахад охид мэдээллийн нууцлал алдагдаж, нэр төрд сөргөөр нөлөөлөхөөс эмээж, бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн охид бусдаас тусламж авч, хамгаалуулж чаддаггүй байх гэсэн хариултыг түгээмэл сонгожээ. Иймд хүүхэд хамгааллын байгууллага, хувь хүмүүс хүүхдүүдийн мэдээллийн нууцыг хадгалах, нэр төрд халдахгүй байхад онцгой анхаарах шаардлагатай байна. Ялангуяа, Чингэлтэй, Баянгол болон Баянзүрх дүүргүүдийн хүүхэд хамгааллын байгууллага, хувь хүмүүс энэ асуудлыг анхааралтай авах шаардлагатай байна.

**Дүрс 13.** Охид бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн үедээ тусламж авч чаддаггүй шалтгааны талаар охидын үнэлгээ



Өгөгдлийн эх сурвалж: Охидоос авсан нэр нуусан асуумж

Хүүхэд хамгааллын талаар охидын ойлголт, мэдлэг сул тохиолдолд бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртвөл тусламж авч чадахгүй байхад нөлөөлөх магадлалтай. Охидын 23% буюу ойролцоогоор таван охин тутмын нэг нь хэрхэн тусламж авах, хэрхэн хамгаалуулах талаар мэддэггүйгээсээ шалтгаалж, охид бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн үедээ тусламж авч чаддаггүй гэж хариулсан байна.



#### Шигтгээ 9. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн охидод туслах, хамгаалах үйлчилгээ мүү

...Манай Монголд охид бэлгийн хүчирхийлэлд өртөж байгаа нь хохирсон хүнийг биш хохироосон хүнд нь тусалдаг тогтолцоотой байдагтай холбоотой. Хохирч байгаа охид нь ерөөсөө тусламж, дэмжлэг авахгүй, хуулиараа ч гэсэн үйлдсэн этгээд нь 450 мянган төгрөг өгөөд салчихдаг. Ямар ч сургалт, үйл ажиллагаа явуулдаггүй. Тэгэхээр манай Монгол сургалтад хамруулаад, хүүхдүүдээ багаас нь зөв өсгөөд, хохирогчдод таатай нөхцөл бий болгож, шийдэж байвал хүчирхийлэл багасах байх гэж бодож байна. Одоо бол би хүчирхийлчихсэн юм чинь энэ яав л гэж би мөнгө төлөөд гарчих юм чинь гэх сэтгэхүйтэй байгаа гэтэл тэр охин цаанаа маш их сэтгэлийн хохиролтой үлддэг. Ер нь аливаа үйл явдлын талаар хүнд хэлэх эсвэл хэлэхгүй нь тухайн хүнээсээ шалтгаалдаг байх. Зарим өөртэй итгэлгүй, ганцаардмал хүүхдүүдэд ийм үйл явдал тохиолдвол маш их нуудаг, найздаа ч ярьдаггүй, дээрээс нь хаана хандахаа бас мэддэггүй.

*ЕБС-ийн сурагчидтай хийсэн фокус бүлгийн ярилцлагаас*

Эндээс бэлгийн хүчирхийлэл, мөлжлөг, хүүхдийн эрхийн зөрчлийн талаар хэнд хандах, хэрхэн тусламж авч, хамгаалуулах боломжтой талаар мэдлэг, мэдээлэл олгох төрөл бүрийн ажлыг хийх зайлшгүй шаардлагатай байгаа нь харагдаж байна. Энэ тал дээр төсөл болон холбогдох байгууллага, мэргэжилтнүүд анхаарал хандуулах хэрэгтэй.

Хүүхэд хамгааллын үйлчилгээг зайлшгүй сайжруулах, сэтгэцийн гэмтэлд суурилсан, хохирогч төвтэй арга зүйг ашиглан хохирогч хүүхдэд дахин сэтгэцийн гэмтэл учруулахгүй, хохирогчид ээлтэй үйлчилгээ үзүүлж чаддаг тогтолцоог бүрдүүлэх нэн шаардлагатай байна. Нийт 664 охидын 19% буюу ойролцоогоор таван охины нэг нь хүчирхийлэл, мөлжлөг үйлдэгчийн зүгээс ирэх дарамт, шахалт, дахин хүчирхийлэл, мөлжлөгт өртөхөөс айдаг шалтгаанаар охид бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн үедээ хэн нэгэнд хандан тусламж авч, хамгаалуулж чаддаггүй гэж хариулсан байна. Мөн судалгаанд хамрагдсан охидын 9% нь хэн нэгэн өөрт нь тусалж, хамгаалж чадна гэдэгт эргэлздэг гэж хариулсан нь энэ дүгнэлтийг мөн нотолно. Бусдад итгэхгүй, эрхээ хамгаалуулж чадахгүй охид өөрийгөө буруутгах хандлагатай болдог. Судалгаанд хамрагдсан охидын 12% нь охид бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн үедээ тусламж авч чаддаггүй шалтгаан нь тэд өөрийгөө буруутгах хандлагатай байдаг учраас бусдад ханддаггүй, бусдаас тусламж хүсдэггүй гэж хариулжээ.



## Шигтгээ 10. Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн охид хамгаалуулж чаддаггүй

....Яг хүмүүст ярихаар хохироосон хүнийх нь буруу биш, хохирогч охиных нь буруу болчихоод байдаг. Хүүхдүүд чи задгай хувцасладаг биз дээ, чи өөрөө ингээд байсан биз дээ наадах чинь тэгэх нь аргагүй шүү дээ гэх мэтчилэн өөр рүү нь чиглэсэн хандлагатай, хохирогч охины нэр төрийг нь их гутаадаг. Би өмнө нь охид задгай хувцасладаг болохоороо л ийм зүйлд өртсөн байх гэж боддог байсан гэхдээ яг өөрөө тийм байдалд ороод ирсэн чинь ойлгосон, их хэцүү санагддаг юм билээ. Тэр нэг ганц охиныг гурван streamer залуу хүчирхийлсэн хэрэг гарч байсан шүү дээ. Тэр охин нь аягүй их уйлаад л, үйл явдлаа ярьж байхад нь хүмүүс тэр охинд итгээгүй, чи худлаа ярьж байна өөрөө согтуу байсан юм чинь тэр гурван залуу буруугүй гэх мэтчилэн шүүх нь хүртэл тэр охины буруу болгож харагдуулаад тэр гурван хүн одоо ямар ч хэрэг энэ тэр хийсэн юмгүй ингээд чөлөөтэй явж байгаа. Тэгээд л ер нь хохирч байгаа хүнд нь хамгийн их дарамт учирдаг. Манай өсвөр насны хүүхдүүд цуу ярианд аягүй их итгэдэг, ерөөсөө үнэн зөвийг ялгаж чаддаггүй. Тэгэхээр сургалтууд, хүчирхийллийн талаар ойлголтууд маш их хэрэгтэй. Охидыг аягүй их янхан гэх мэт муухай үгээр дууддаг. Жишээлбэл, нэг хүүхэдтэй үерхэж байгаад, өөр хүнтэй үерхсэн охин байх юм бол тэр охиныг юу ч хийгээгүй байхад нь янзын бүрээр ярьдаг. Тэгээд л сургууль дээр тэр яриа нь тархаад наадах чинь тийм охин шүү дээ, янз бүрийн хүмүүстэй явалддаг охин гээд л цуурхал тараачихдаг. Тэгээд л нөгөө цуурхалд нь насан туршид нэрд нь нөлөөлөөд л яваад байдаг. Жоохон хичээлдээ сайн явангуут наадах чинь тийм охин, явдалтай, ийм тийм наадахаа битгий дэмж тийм болохоороо л ингэж явж байгаа юм гээд муулах хандлагатай байдаг.

*ЕБС-ийн сурагчидтай хийсэн фокус бүлгийн ярилцлагаас*

### 2.3 Хүүхэд хамгааллын үйлчилгээ, чанар хүртээмж

#### 2.3.1. Хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны өнөөгийн нөхцөл байдал, чанар, хүртээмж

Энэхүү дэд бүлэгт урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чанарын суурь үзүүлэлтийг тодорхойлохдоо сургуулийн удирдлага, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нартай хийсэн ганцаарчилсан ярилцлага, хамтарсан багийн гишүүд болон үйлчилгээ үзүүлэгч байгууллагын төлөөлөлтэй хийх хагас бүтэцлэгдсэн ярилцлага, охидтой хийсэн фокус бүлгийн ярилцлага, кейс судалгааны үр дүнд суурилав. Ажлын даалгаварт тусгагдаагүй ч охидын эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртөхөд нөлөөлж буй хүчин зүйлүүдийг тодруулахыг зорьсон. Учир нь урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь охид бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгийн талаарх ойлголт, мэдлэг, түүнд өртөхөд нөлөөлж буй хүчин зүйлүүдийг бууруулах, шалтгаан нөхцөлийг арилгахад чиглэгдэх ёстой.

Хүүхэд гэмт хэрэг, зөрчил, эрсдэлт нөхцөл байдалд орохоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд дараах үзүүлэлтийг авч үзсэн. Үүнд:

- Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд
- Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах мэргэжилтнүүдийн үр чадвар, мэргэжил арга зүйн зөвлөгөө

Хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чанарыг ЕБС-ийн суралцагч охид, хамтарсан багийн гишүүд болон сургуулийн удирдлага, нийгмийн ажилтнуудын охидын эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн талаарх мэдлэг болон мэргэжилтнүүдийн урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулж буй үр чадварыг өөрийн үнэлгээний дундаж үзүүлэлтэд тулгуурлан гаргав.



#### Шалгуур үзүүлэлт:

Төслийн зорилтын шалгуур үзүүлэлт: Хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чанарыг оролцогчдын зүгээс **43.4 хувь** нь сайн гэж үнэлсэн.

**Хүснэгт 17.** Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чанарыг сайн гэж үзсэн дундаж хувь, оролцогч талуудаар

Талбарууд	(a) Мэдлэг	(b) Үйлчилгээ үзүүлэх ур чадвар	(a)+(b) Үйлчилгээний чанар
Дундаж	39.9	46.9	43.4
Хамтарсан багийн гишүүд	42.6	42.5	42.5
Сургуулийн удирдлага, нийгмийн ажилтнууд	38.8	36.6	37.7
Ерөнхий боловсролын сургуулийн суралцагч охид	38.3	61.6	49.9

Судалгааны үр дүнгээр охидын эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн талаарх ойлголт, мэдлэг дутмаг байна. Бүлгээр нь ангилан харвал, хамтарсан багийн гишүүдийн 42.6 хувь, ерөнхий боловсролын сургуулиудын удирдлага, нийгмийн ажилтнуудын 38.8 хувь нь ойлголт, мэдлэгээ сайн гэж үнэлсэн. Асуулга судалгааны үр дүнгээр бэлгийн хүчирхийлэл (46.5 хувь) болон бэлгийн мөлжлөгийн (30.1 хувь) талаар зөв хариултыг охидын 38.3 хувь нь сонгосон. Сургуулийн орчинд охидын эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах үр чадвар сайтай гэж охидын 61.6 хувь буюу 3 охин тутмын хоёр нь, хамтарсан багийн гишүүдийн 42.5 хувь, сургуулийн удирдлага, нийгмийн ажилтнуудын 36.6 хувь үнэлсэн. Охид урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулж буй мэргэжилтнүүдийн үр чадварыг илүү үнэлсэн нь хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд үр дүнтэй болсныг илтгэж байна.

### 2.3.1.1. Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа

Судалгаанд хамрагдсан 25 хорооны болон сургуулийн нийгмийн ажилтнаас 40 хувь нь мэргэжлийн, хамгийн олон жил нь 16 жил, хамгийн бага нь 4 сар ажиллаж байгаа бөгөөд 3 нийгмийн ажилтан өөр албан ажлыг хавсарган гүйцэтгэдэг байна. Мэргэжлийн нийгмийн ажилтнууд гол төлөв төрийн захиргааны байгууллага, орон нутгийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, боловсролын болон олон улсын байгууллагад ажилласан туршлагатай байв.

Охидын эсрэг бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийг хамтарсан байдлаар зохион байгуулж байна. ГБХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцооны анхан шатны нэгж нь хамтарсан баг юм. ГБХ-тэй тэмцэх тухай хуулийн 20 дугаар зүйлд зааснаар “Хамтарсан баг нь өрхийн эмч, сум, хороо, сургуулийн, халамжийн, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн нийгмийн ажилтан, цагдаагийн алба хаагч, энэ чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг ТББ-ын төлөөллөөс бүрдэх бөгөөд хамтарсан багийг тухайн сум, хорооны Засаг дарга ахална” гэжээ. Мөн хамтарсан багийн чиг үүрэгт гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулахаар заасан.

Хамтарсан баг нь охидын эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд иргэд, олон нийтэд зориулсан сургалт, сурталчилгааг зохион байгуулах, олон нийтийг татан оролцуулах ажлууд хангалтгүй, орхигдуулж байна. Хамтарсан баг нь төрийн бус байгууллагуудтай хамтран ЕБС-иудад сүүлийн 2 жил КОВИД-19 цар тахлын нөлөөгөөр хүүхдийг гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр төлөвлөсөн арга хэмжээнүүдийг хийхэд бэрхшээл учирсан байна. Харин 2021 оны 9 дүгээр сараас эхлэн хүүхдийн эрх, охидын эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар сургалтуудыг танхим болон цахим хэлбэрээр зохион байгуулсан байна. Фокус бүлгийн ярилцлагаар



охидын эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгөөс урьдчилан сэргийлэхтэй холбоотой бэлгийн хүчирхийллийн мэдээллийг эрүүл мэндийн хичээл болон төрийн бус байгууллагуудаас ирсэн мэргэжилтнүүдийн хүүхдийн эрхийн сургалтаар авсан байна. Гэхдээ өгч буй мэдээлэл нь тийм ч үр дүнтэй байгаагүйг оролцогчид онцолсон. Асуулга судалгааны үр дүнгээс үзэхэд охидын бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн талаарх мэдээллийг 70.2 хувь нь гэр бүл дотроо, 74.2 хувь нь сургууль дээрээ, 72.9 хувь нь цахим орчноос авч байгаагаас үзэхэд охид 2-3 эх сурвалжуудаас авдаг болох нь батлагдаж байна. Цахим орчинд мэдээллийг авч буй охидын 47.1 хувь нь бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдээлэл, зөвлөгөөг фэйсбүкийг ашиглан авсан бол үлдсэн хувь нь нийгмийн сүлжээгээр зөвхөн охидод зориулсан хаалттай группуудын коментуудыг унших, контентыг үзэх, амьдралын түүх уншин тодорхой мэдээлэлтэй болсон байна.


**Матриц 1.** Хамтарсан багийн охидын эсрэг бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгт өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд (n=10)

№	Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Үр дүн
1.1	Бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгт өртөж болзошгүй эрсдэлтэй охидыг илрүүлэх, мэдээлэх,	Эрсдэлт нөхцөл байгаа гэр бүлд сард 1-2 удаа гэрээр айлчлан очиж нөхцөл байдалтай танилцах (Хорооны хамтарсан багийн гишүүд)	Үл хайхрах байдалд өртсөн хүүхдийг илрүүлж, тодорхой арга хэмжээг авдаг.
1.2	таслан зогсоох үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх	Хэсгийн ахлагчтай хамтран бэлгийн хүчирхийлэлд өртөж болзошгүй охидын судалгааг авах (Хорооны хамтарсан баг)	Судалгаанд суурилан эрсдэлтэй охидод тогтмол хараа хяналт тавьдаг.
2.1	Охидын эсрэг бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд зориулсан сургалт, сурталчилгааг зохион байгуулах	Хүмүүжлийн эерэг арга хөтөлбөрөөр дамжуулан хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх (Хүүхдийг Ивээх Сан)	57 эцэг эх, асран хамгаалагчдад
3.1	Охидын эсрэг бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгт өртөхөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийг татан оролцуулах	“Хүчирхийллийн эсрэг хамтдаа” аяны хүрээнд Баярмаа охины гэр бүлд туслах нь контент хийх (Хүүхдийн тусламж 108 утасны үйлчилгээний төв, Эрхэм инээмсэглэл ТББ, Гэмтэл согог судлалын үндэсний төв)	Цахимаар контентыг түгээн иргэдэд нөлөөллийн ажлыг зохион байгуулсан. Уг контентыг үзсэн өрх толгойлсон ээж нар асуудлыг эрт илрүүлснээр гэр бүл, үр хүүхдээ хамгаалж болохыг ойлгосон.
4.1	Охидын эсрэг бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгт өртөхөөс урьдчилан сэргийлэх	Охидын өдөрлөг зохион байгуулах (Good neighbors Mongolia ОУБ)	2 удаа, ЕБС-ийн ахлан ангийн нийт 98 охид хамрагдсан. Ариун цэврийн хэрэглээг хэрхэн зөв хэрэглэх талаар зааж сургасан.
4.2	чиглэлд төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах	Охидын өдөрлөг зохион байгуулах (Хөөрхөн зүрх ТББ)	2 удаа, нийт 50 охидыг хамруулсан
4.3		Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх (Дэлхийн зөн ОУБ)	2 охин зөвлөгөө авснаар сэтгэл зүйн хувьд тайван болсон.
4.4		Эрүүл мэндийн хичээлийн хүрээнд нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрх сэдвээр лекц унших (Өрхийн эрүүл мэндийн төв)	ЕБС-ийн ахлах ангийн охид 40 гаруй охид хамрагдсан.

4.5		Өөрийн санал дээр үндэслэн охидын үзлэгт хамруулах (Сургуулийн удирдлага, Өрхийн эрүүл мэндийн төв)	Өвчин болон хүсээгүй жирэмслэлтэй охидыг илрүүлэн эмчлэх, эцэг, эх, асран хамгаалагчтай нь уулзалт хийн асуудлыг шийдэхэд дэмжлэг болсон.
-----	--	---	---

Матриц 1-ээс үзэхэд Хорооны хамтарсан баг нь харьяа ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн охидод зориулан Охидын өдөрлөг, Нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрх сэдэвт сургалт, сэтгэл зүйн зөвлөгөөг зохион байгуулсан бөгөөд эдгээр үйл ажиллагаануудад давхардсан тоогоор 200 орчим охид хамрагдсан байна. Охидыг бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгт өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлд ихэвчлэн Олон улсын байгууллагуудын санаачлагаар үйл ажиллагааг зохион байгуулсан. Хамтарсан багийн гишүүдтэй хийсэн ярилцлагаар охидыг бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд хамтарсан багийн гишүүд (нийгмийн ажилтан, эмч, хэсгийн байцаагч, хэсгийн ахлагч зэрэг) гэрээр айлчлах хөтөлбөрийг хэрэгжүүлэх илүү үр дүнтэй гэж үзсэн. Хамтарсан багийн хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд гол төлөв ЕБС-ийн суралцагч охидод чиглэсэн байгаа нь хэдийгээр чухал боловч бусад оролцогч талууд болох иргэд, олон нийт, тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй ААНБ-ыг татан оролцуулах нь илүү үр дүнтэй.

ЕБС-иудад охидын эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд хуулиар үүрэг хүлээсэн төрийн байгууллагуудын оролцоо сул, хамтран ажиллах байдал хангалтгүй байна. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 6.1-т зааснаар сургалтын байгууллага хүүхэд хамгааллын бодлогыг тухай байгууллагад хэрэгжүүлэхдээ хөтөлбөр, төлөвлөгөө гарган, мөрдөн ажиллана гэжээ. БСШУЯ-ны сайдын А/476 дугаар тоот тушаалаар ЕБС-ийн орчин дахь Хүүхэд хамгааллын бодлого батлагдсан гарсан. Үүнтэй холбоотой 2019 оноос сургуулиудад сургуулийн захирлаар ахлуулсан сургалтын менежер, сургуулийн нийгмийн ажилтан, эмч, багш нараас бүрдсэн хүүхэд хамгааллын багийг байгуулан хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулан батлуулах ажил хийгдсэн байна. Судалгаанд хамрагдсан 15 сургуулийн Хүүхэд хамгааллын бодлого, үүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд охидын эсрэг бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр арга хэмжээ тусгагдаагүй байв. Тухайн сэдвийг гол төлөв хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд хөндөгддөг болох нь нийгмийн ажилтнуудтай хийсэн ярилцлагуудаас харагдсан.

 Шигтгээ 11. ЕБС-ийн Хүүхэд хамгааллын бодлого

...ЕБС-д дан ганц охид явдаггүй шүү дээ. Хүүхэд хамгааллын бодлого, төлөвлөгөөнд охидын эсрэг бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр арга хэмжээг тусгайлан оруулаагүй. Хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс болон гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд хүүхдийн эрх, хүүхдийн хөгжилтэй холбоотой арга хэмжээнүүдийг төрийн бус байгууллагын дэмжлэгтэйгээр хийгддэг.

*Сургуулийн нийгмийн ажилтантай хийсэн ярилцлагын хэсгээс*

Судалгааны ажлын хүрээнд ЕБС-ийн орчинд охидын эсрэг бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах сургуулийн удирдлага, нийгмийн ажилтнуудын үр чадварыг 6 үндсэн үзүүлэлтийн дунджаар тооцон гаргасан.

**Матриц 2.** Ерөнхий боловсролын сургуулиудад охидыг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд (n=18)

№	Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа	Хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд	Үр дүн
1.1	Бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгт өртөж	Судалгааг авах (сургуулийн нийгмийн ажилтан)	ЕБС-ийн ахлах ангийн суралцагчид
1.2	болзошгүй эрсдэлтэй охидыг илрүүлэх, мэдээлэх, таслан зогсоох үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх	Охидын өдөрлөг зохион байгуулах (Good neighbors Mongolia ОУБ)	5-12 ангийн суралцагчид, анги бүрээс 5 охин, 300 гаруй охид хамрагдсан.
1.3		Сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөө (сургуулийн сэтгэл зүйч)	
1.4		Охидын клуб	
1.5		Хүсэлтийн хайрцаг	10 охины эрсдэлтэй нөхцөл байдалд байгааг олж тогтоосон.
2.1	Охидын эсрэг бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх талаар суралцагчдад зориулсан сургалт, сурталчилгааг зохион байгуулах	Хүүхдийн эрхийн тухай мэдээлэл, брошюр, контентыг сургуулийн анги удирдсан багш нарын болон ангийн дарга нарын группээр дамжуулан суралцагчдад өгөх (сургуулийн нийгмийн ажилтан) Дунд ангийн суралцагчдад зориулсан үе тэнгийн дарамт, хүчирхийллийн талаарх сургалт (сургуулийн нийгмийн ажилтан) Бага ангийн суралцагчдад зориулж өөрийн биеийн хэсгийг нэрлэх, хамгаалах талаарх сургалт (сургуулийн нийгмийн ажилтан)	ЕБС-ийн ахлах ангийн суралцагчид, нийт 12 ангийн 367 суралцагч
2.2		Охид, эмэгтэйчүүдийг хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх (сургуулийн нийгмийн ажилтан )	ЕБС-ийн 6-12 ангийн суралцагчид, 3 жилийн хугацаанд 900 гаруй охидыг хамруулсан.
3.1	Охидын эсрэг бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгт өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлд төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах	Нөхөн үржихүйн эрүүл мэнд (Good neighbors Mongolia ОУБ)	ЕБС-ийн ахлах ангийн суралцагчид, 100 гаруй охид хамрагдсан.

Матриц 2-оос харахад Ерөнхий боловсролын сургуулийн орчинд охидыг бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгт өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн хүрээнд тодорхой ажлуудыг хийсэн байна. Чанарын судалгааны үр дүнгээр сургуулийн нийгмийн ажилтнууд нь хүний эрх, нөхөн үржихүйн эрүүл мэнд, охид, эмэгтэйчүүдийг хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалтад хамрагдан, уг сургалтуудыг сургууль дээрээ зохион байгуулж байгаагаар онцлог байна.

Охидын эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулагдсан ажил болон хамрагдалт дутмаг байна. Асуулга судалгааны үр дүнгээр 19.3 хувь нь охидын эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулагдсан сургалтад оролцсон бол 47.4 хувь нь ямар ч үйл ажиллагаанд оролцоогүй гэдгээ мэдэгдсэн. Арга хэмжээг гол төлөв олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр төрийн бус байгууллага, сургууль хамтран эсвэл ГБХЗХГ, хамтарсан багтай хамтран зохион байгуулжээ. Фокус бүлгийн ярилцлагаар сургууль дээр охидын эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгөөс урьдчилан сэргийлэхтэй холбоотой сургалтуудыг бүлгээр нь зохион байгуулдаг бөгөөд асуух зүйл байвал асуугаарай гэдэг ч охин бүр нээлттэй асууж чаддаггүй аж. Сургуулийн нийгмийн ажилтнуудын үзэж байгаагаар охидын насны онцлогоос хамаарч контент бэлтгэн мэдээллийн олон талт эх сурвалжуудаар хүргэх, сургалтуудыг танхимаар болон цахимаар оролцоонд суурилсан арга зүйгээр хийх нь илүү үр дүнтэй гэж үзсэн. Сүүлийн жилүүдэд сургуулиудад охидын клуб ажиллуулах болсноор жүжиглэсэн тоглолтоор асуудлыг тайлбарлах, өөр хоорондоо асуудлаа ярилцах, мэдээллээ солилцох зэрэг үйл ажиллагааг зохион байгуулдаг байна. Фокус бүлгийн ярилцлагад оролцсон охид сургуульд нь мэргэжлийн сэтгэл зүйчийг ажиллуулах болсонд таатай байгаа бөгөөд ганцаарчилсан зөвлөгөөг авах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн.

Мэргэжилтнүүдийн охидын эсрэг бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах үр чадвар, мэргэжил арга зүйн зөвлөгөөг сайн гэж үнэлсэн хувь бага байна. Мэргэжилтнүүд урьдчилан сэргийлэх чиглэлээр хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах, сургалт, нөлөөллийн ажлуудыг зохион байгуулах, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах зэрэг үр чадваруудыг эзэмшсэнээр хүүхдийг эрсдэлт нөхцөлд орохоос хамгаалж чадна. Судалгааны ажлын хүрээнд хамтарсан баг болон сургуулийн удирдлага, нийгмийн ажилтнуудын урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах үр чадварыг өөрийн үнэлгээнд тулгуурлан үнэллээ. Охидын эсрэг бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах хамтарсан багийн гишүүдийн 42.5 хувь, сургуулийн удирдлага, нийгмийн ажилтнуудын 36.6 хувь нь үр чадвараа сайн гэж үнэлсэн.

Хамтарсан багийн охидын эсрэг бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах үр чадварыг 4 үндсэн үзүүлэлтийн дунджаар тооцон харуулав.

**Хүснэгт 18.** Хамтарсан багийн урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах үр чадварын үнэлгээ, хувиар

№	Үндсэн үзүүлэлт	Сайн
1	Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хугацаатай хөтөлбөр, төлөвлөгөөг гаргах	40.0
2	Бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгт өртөж болзошгүй эрсдэлтэй охидыг илрүүлэх, мэдээлэх, таслан зогсоох үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх	30.0
3	Охидын эсрэг бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх талаар суралцагчдад зориулсан сургалт, сурталчилгааг зохион байгуулах	50.0
4	Охидын эсрэг бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгт өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлд төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах	50.0
<b>БҮГД</b>		<b>42.5</b>

Судалгаанд хамрагдсан Нийслэлийн Баянзүрх дүүрэг, Сонгинохайрхан дүүрэг, Чингэлтэй дүүрэг, Баянгол дүүрэг болон Сүхбаатар дүүргийн хороодын хамтарсан багийн гишүүдийн урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах үр чадварын үнэлгээнээс үзэхэд охидын

эсрэг бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх талаар суралцагчдад зориулсан сургалт, сурталчилгааг зохион байгуулах урьдчилан сэргийлэх чиглэлд төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах чиглэлээрх үйл ажиллагаа бусад үзүүлэлттэй харьцуулахад сайн байна. Хамтарсан багийн гишүүдийн хувьд урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах өөрсдийн үр чадварыг судалгаанд оролцогчдын 42.5 хувь сайн гэж үнэлсэн.

Сургуулийн удирдлага, нийгмийн ажилтнуудын охидын эсрэг бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах үр чадварыг 5 үндсэн үзүүлэлтийн дунджаар тооцон гаргав.

**Хүснэгт 19.** Сургуулийн удирдлага, нийгмийн ажилтнуудын урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах үр чадварын үнэлгээ, хувиар

№	Үндсэн үзүүлэлт	Сайн
1	Хүүхэд хамгааллын бодлогын хүрээнд төлөвлөгөөг баталж, үйл ажиллагаа нь тогтмолжих	50
2	Охидын эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийг таслан зогсоох, үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх	44.4
3	Охидыг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгааг зохион байгуулах	44.4
4	Охидыг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон нийтийг татан оролцуулах ажлыг зохион байгуулах	11.2
5	Охидыг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр эцэг эх, асран хамгаалагч, багш нарт сургалт, мэдээллийг өгөх	33.3
<b>БҮГД</b>		<b>36.6</b>

Хүснэгт 19-оос харахад ЕБС-иудад охидын эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах үр чадварын дундаж үзүүлэлт 36.6 хувьтай байна. Сургуулийн орчинд охидыг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон нийтийг татан оролцуулах болон эцэг эх, асран хамгаалагч, багш нарт сургалт, мэдээллийг өгөх зэрэг ажлууд хангалтгүй хийгдэж байгааг цаашид анхаарах шаардлагатай байна.

Хамтарсан багийн гишүүд болон сургуулийн удирдлага, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нар мэргэжиларгазүйн зөвлөгөөг хуулиар үүрэг хүлээсэн төрийн болон олон улсын байгууллагуудаас авч байна. Төрийн байгууллагууд хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлд мэргэжилтнүүдийг чадавхжуулахад нэлээн анхаарч ажиллаж байна. Гэр бүлийн хүчирхийллийн суурь шалтгаан эрх мэдлийн зөрүүтэй байдлыг багасгахын тулд иргэдийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх нь чухал бөгөөд энэ чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай хамтрах хүсэлтээ хороодын нийгмийн ажилтнууд илэрхийлж байв.

**Матриц 3. Мэргэжил арга зүйн зөвлөгөөг авч буй байгууллага**

№	Байгууллага	Хамтарсан багийн гишүүд	Ерөнхий боловсролын сургуулийн удирдлага, нийгмийн ажилтнууд, сэтгэл зүйч
1	Төрийн байгууллага	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (ГБХЗХГ), Дүүргүүдийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Гэмтэл согог судлалын үндэсний төвийн Нэг цэгийн үйлчилгээний төв	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (ГБХЗХГ) Дүүргийн цагдаагийн хэлтэс
2	Төрийн бус байгууллага	Төрийн бус байгууллагаас Хүчирхийллийн үндэсний төв, Ид шидийн орон хүүхэд хамгаалал, хөгжлийн төв	Дэлхийн зөн ОУБ
3	Олон улсын байгууллага	Хүүхдийг ивээх сан	Хүүхдийг ивээх сан
4	Их, дээд сургууль		Шинжлэх ухаан технологийн их сургууль (ШУТИС)

Хамтарсан багийн гишүүд нь сэтгэцийн гэмтэлд суурилсан, хохирогч төвтэй арга зүйн талаар ойлголт, мэдлэг хангалтгүй байна. Хамтарсан багийн гишүүдийн 90 хувь нь сэтгэцийн гэмтэлд суурилсан, хохирогч төвтэй арга зүйн талаар ойлголт, мэдлэг хангалтгүй, нэвтрүүлсэн туршлага байхгүй байна. Гэхдээ сэтгэцийн гэмтэлд суурилсан, хохирогч төвтэй арга зүйг нэвтрүүлэхэд шаардлагатай мэдлэгийг бусад сургалтууд, кейс дээр ажиллах явцдаа олж авсан нь судалгааны үр дүнгээс харагдлаа.

**Дүрс 14. Сэтгэцийн гэмтэлд суурилсан, хохирогч төвтэй арга зүйн талаарх мэдлэг**



Өгөгдлийн эх сурвалж: Хамтарсан багийн гишүүдтэй хийсэн ганцаарчилсан ярилцлага

Хамтарсан багуудад сэтгэцийн гэмтэлд суурилсан, хохирогч төвтэй арга зүйг нэвтрүүлэх хэрэгцээ шаардлага бий бөгөөд тус арга зүйн сургалтад хамрагдах хүсэлтээ хорооны нийгмийн ажилтнууд илэрхийлсэн.

Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулахад мэргэжилтнүүдэд дараах хүндрэл бэрхшээл гарч байна.

**Матриц 4. Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулахад тулгарч буй бэрхшээл**

Хамтарсан багийн гишүүд	Ерөнхий боловсролын сургуулийн удирдлага, нийгмийн ажилтнууд, сэтгэл зүйч
<ul style="list-style-type: none"> <li>• Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах төсөв байхгүй, шаардлагатай зардлыг өөрийн карманаасаа гаргадаг.</li> <li>• Хамтарсан багийн гишүүдтэй хамтран ажиллах тал дээр сул, ихэвчлэн өөр өөрийн үүрэгтээ ажлаа чухалчлаад хамтарсан багийн ажлыг дараа тавих хандлага гаргадаг.</li> <li>• Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулахад иргэдийн оролцоо сул.</li> <li>• Хорооны нийгмийн ажилтан мэргэжлийн бус, улс төрөөс хараат, халаа сэлгээ ихтэй байна.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Сургууль дээр урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд нэг ч төсөв хуваарилдаггүй.</li> <li>• Мэргэжлийн байгууллагуудын хоорондын уялдаа холбоо сул, хүнд суртал ихтэй.</li> <li>• Нийгмийн ажилтанд оногдох сурагчдын тоо их тул урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа бүлгийн сургалтаар л хязгаарлагдаж байна.</li> </ul>

Хамтарсан багийн түвшинд ч, сургуулийн түвшинд ч урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төсөв дутмаг байна. Аливаа нэгэн үйл ажиллагаа төсөвгүйгээр үр дүнтэй хэрэгжих боломжгүй. Хүүхэд хамгааллын төсөв нь Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.6-д заасны дагуу хүүхдийн асуудлаар хэрэгжүүлэх Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх буюу тусгай зориулалтын шилжүүлэг (ТЗШ)-ийн санхүүжилт хэлбэрээр төлөвлөгдөн зарцуулагдаж байна. ХНХЯ-ны тайлан мэдээллээр 2017 онд 900.1 сая төгрөг байсан бол 2018 онд 6.4 тэрбум төгрөг, 2019 онд 7.6 тэрбум төгрөг, 2020 онд 8.0 тэрбум төгрөгт хүрч даруй 8.8 дахин нэмэгдсэн хэдий ч хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулж буй хамтарсан баг, ЕБС-иудад ямар ч мөнгө хуваарилагдахгүй байгаа нь судлаачдын анхаарлыг татаж байв.

Хамтарсан багийн ажиллах, түүнийг санхүүжүүлэх журмыг Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/173, А/259, А/3801 тоот хамтарсан тушаалаар баталсан. Уг журмын 5 дугаар зүйлд хамтарсан багийн үйл ажиллагаанд шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсөв, хуулиар зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх тухай дурджээ. Хамтарсан багийн үйлчилгээний зардлын төсвийг сум, дүүрэг, аймаг, нийслэлийн засаг дарга нар жил бүр ГБХ-тэй тэмцэх үйл ажиллагааны зардалд тусгайлан төсөвлөж, иргэдийн төлөөлөгчийн хурлаар батлуулахаар зохицуулсан. Судалгаанд хамрагдсан хамтарсан багийн гишүүний 80 хувь нь, ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтнуудын 73 хувь нь урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд зохион байгуулагдаж буй арга хэмжээнүүдэд төсөв байхгүй, өөрсдийн нөөц боломжоороо, ялангуяа төрийн бус байгууллага болон олон улсын байгууллагын тусламж дэмжлэгтэйгээр хийдэг байна.



## Шигтгээ 12. Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулахад тулгарч буй бэрхшээл

... 2020-2021 онд хорооны хамтарсан баг дээр төсөв байгаагүй. Такси унааны зардлаа өөрсдөө гаргасан. Харин 2022 онд хорооны хамтарсан багт төсөв хуваарилна гэж сонссон.

*Хамтарсан багийн гишүүнтэй хийсэн ярилцлагаар*

... Сургуульд зохион байгуулагдаж буй үйл ажиллагаанууд олон улсын байгууллага, төрийн бус байгууллагын дэмжлэгтэйгээр зохион байгуулдаг.

*Сургуулийн нийгмийн ажилтантай хийсэн ярилцлагаар*

Үүний зэрэгцээ хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд хэрэгжүүлэх үүрэгтэй нийгмийн ажилтнуудын мэргэжлийн бус байдал, улс төрөөс хэт хараат, тогтвор суурьшилгүй байдал нь нөлөөлж буйг судалгаанд хамрагдсан мэргэжилтнүүд хэлж байв.

### 2.3.1.2. Охидыг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртөхөд нөлөөлж буй хүчин зүйлс, орчин

Ажлын даалгаварт тусгагдаагүй ч судалгааны баг чанарын мэдээлэлд тулгуурлан охид бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртөхөд нөлөөлж буй хүчин зүйлийг тодруулснаар өнөөгийн авч хэрэгжүүлж буй урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа хэр оновчтой болохыг харах боломжтой. Тодруулбал, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь охид бэлгийн хүчирхийлэлд өртөхөд нөлөөлж буй хүчин зүйлийг бууруулах, арилгахад чиглэгдэх ёстой.

Охидыг бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгт өртөхөд гэр бүлийн нөхцөл байдал ихээхэн нөлөөтэй байна. Чанарын судалгааны үрдүнгээр охидын бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгт өртөхөд гэр бүлийн нөхцөл байдал ихээхэн нөлөөтэй нь батлагдсан бөгөөд статистикийн тоо баримтуудтай ч уялдаж байв. Статистик мэдээллээс үзэхэд 2020 онд хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг бүртгэгдсэн 505 гэмт хэргийн 79.4 хувийг хүчиндэх гэмт хэрэг эзэлж байна. Уг гэмт хэргийн 334 буюу 66.1 хувь нь гэр, орон сууцад үйлдэгдсэн бөгөөд 406 буюу 80.9 хувийг хүчиндэх гэмт хэргийн хохирогч байв. Хүчиндэх гэмт хэргийн хохирогчдын 61.1 хувь нь 18 хүртэлх насныхан байв<sup>36</sup>. Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн хохирогчдын дийлэнх нь хууль хяналтын байгууллагад хандахгүй өнгөрөөдөг, хандсан ч хэрэгсэхгүй болох, өргөдлөө татаж авах, гомдолгүй тохиролцсон гэх зэргээр асуудал орхигддог байх талтай.

Чанарын судалгаагаар охид бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртөх эрсдэлийг дараах хүчин зүйлүүд нэмэгдүүлж байна.

- Охидын бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн талаарх ойлголт, мэдлэг хангалтгүй байгаа нь бэлгийн хүчирхийллийн хохирогч болох эрсдэлийг нэмэгдүүлж байна.
- Гэр бүлийн хэн нэгэн гишүүн нь архины хамааралтай байх нь охидыг бэлгийн хүчирхийлэлд өртөх эрсдэлийг нэмэгдүүлж байна.
- Эцэг, эх болон асран хамгаалагчийн боловсролын түвшин доогуур, хараа хяналт сул байх тусам охид бэлгийн хүчирхийлэлд өртөхөд нөлөөлж байна.
- Цахим орчны шүүлтүүргүй мэдээлэл нь охидыг бэлгийн хүчирхийлэлд өртөхөд нөлөөлж байна.

Охидын эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн талаарх ойлголт, мэдлэг хангалтгүй байна. Охидын бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгөөс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар ойлголт мэдлэг хангалтгүй байгаа гэж хамтарсан багийн гишүүд 30 хувь, сургуулийн нийгмийн ажилтнуудын

<sup>36</sup> УСХ (2021) Гэмт хэргийн статистик-2020, Улаанбаатар.



46.6, үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын төлөөллийн 23 хувь нь үзэж байна. Гэхдээ охидын ойлголт, мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн нийгмийн институцийн үйл ажиллагаа, уялдаа холбоо хангалттай байж үр дүн нь гарах юм.

**Матриц 5.** Хувь хүний түвшинд нөлөөлж буй хүчин зүйлүүд

Хамтарсан багийн гишүүд	Ерөнхий боловсролын сургуулийн удирдлага, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч	Фокус бүлгийн ярилцлага
<ul style="list-style-type: none"> <li>Охидын бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгийн талаарх ойлголт мэдлэг сул</li> <li>Охид эрсдэлт нөхцөл байдалд орсон тохиолдолд хаана хэнд хандан тусламж авах талаар мэдээлэл хангалтгүй</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Охидын бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгийн талаарх ойлголт мэдлэг сул</li> <li>Бусдын анхаарлыг татахуйц биеэ авч явах, хувцаслах</li> <li>Хөгжлийн бэрхшээлтэй байх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Охидын бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгийн талаарх ойлголт мэдлэг сул</li> <li>Бусдын анхаарлыг татахуйц биеэ авч явах, хувцаслах</li> <li>Охид эрсдэлт нөхцөл байдалд орсон тохиолдолд хаана хэнд хандан тусламж авах талаар мэдээлэл хангалтгүй</li> </ul>

Эх сурвалж: ТБ-ын ажилтнуудтай хийсэн ГЯ болон ЕБС-ийн сурагчидтай хийсэн ФБЯ

Гэр бүлийн хэн нэгэн гишүүн нь архины хамааралтай байх нь охидыг бэлгийн хүчирхийлэлд өртөх эрсдэлийг нэмэгдүүлж байна. Цагдаагийн байгууллагын 2021 гэмт хэргийн статистик мэдээгээр гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх онтой харьцуулахад 34.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна<sup>37</sup>. Уг хэрэг ихэнх тохиолдолд архидан согтуурах үедээ үйлдсэн гэжээ. Хамтарсан багийн гишүүдийн дийлэнх нь гэр бүлийн хэн нэгэн гишүүн архины хамааралтай байх нь охидыг бэлгийн хүчирхийлэлд өртөхөд хамгийн их нөлөөтэй гэж үзсэн. Кейс судалгаагаар эцэг, эх, асран хамгаалагч нь архины хамааралтай байгаа нь охидыг бэлгийн хүчирхийллийн хохирогч болоход нөлөөлсөн болох нь тогтоогдсон. Мөн асуулга судалгаанд хамрагдсан охидын 1.5 хувь нь гэртээ байхдаа айдас түгшүүртэй байгаагаар илэрхийлсэн.

**Матриц 6.** Гэр бүлийн түвшинд нөлөөлж буй хүчин зүйлүүд

Хамтарсан багийн гишүүд	Ерөнхий боловсролын сургуулийн удирдлага, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч	Фокус бүлгийн ярилцлага (n=5)
<ul style="list-style-type: none"> <li>Эцэг, эх, асран хамгаалагч нь архины хамааралтай байх</li> <li>Эцэг эхийн боловсролын түвшин доогуур байх</li> <li>Эцэг эх, асран хамгаалагчийн зүгээс хараа хяналт сул, үл хайхрах байдалд өртөх</li> <li>Гэр бүлд эмэгтэй хүүхэд дуулгавартай хүний хэлсэн зүйлийг үг дуугай биелүүлэх ёстой гэсэн жендэрт суурилсан хэвшмэл үзэл давамгайлах</li> <li>Эцэг, эхийн хоорондын харилцаа таарамжгүй, байнга хэрүүл маргаантай байх</li> <li>Гэр бүл салах</li> <li>Хойд эцэгтэй байх</li> <li>Эцэг эхийн охинтойгоо харилцах харилцаа таагүй байсантай холбоотой гэрээсээ явах</li> <li>Эцэг, эх, асран хамгаалагчийн хүүхэд хүмүүжлийн уламжлалт арга барилтай байх (зодох, шийтгэх, хараат байлгахыг оролдох гэх мэт)</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Эцэг, эх, асран хамгаалагч нь архины хамааралтай байх</li> <li>Эцэг эх, асран хамгаалагчийн зүгээс хараа хяналт сул, үл хайхрах байдалд өртөх</li> <li>Эцэг, эхийн хоорондын харилцаа таарамжгүй, байнга хэрүүл маргаантай байх</li> <li>Хойд эцэгтэй байх</li> <li>Гэр бүл салах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Эцэг эхийн хүмүүжил</li> <li>Эцэг эхийн таарамжгүй харилцаа</li> <li>Хамаатан садныхандаа айлчлах, түр байрлах</li> </ul>

Эх сурвалж: ТБ-ын ажилтнуудтай хийсэн ГЯ болон ЕБС-ийн сурагчидтай хийсэн ФБЯ

37 Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2021 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ, Улаанбаатар.



### Шигтгээ 13. Архины хамааралтай байдал

...Эцэг, эх болон асран хамгаалагч нь архины хамааралтай гэр бүлд ихэвчлэн охид бэлгийн хүчирхийлэлд өртөж байна. Архидалт хүний бөөгнөрөлийг үүсгэж, ухаан санаа самуурсан үед дур хүслээ хангах сэдэл төрдөг.

...Архины хамраалтай гэр бүлд хүүхэд үл хайхрах байдалд өртөх, эцэг эхийн хоорондын таарамжгүй харилцаанаас үүдэн сэлгүүцэх, хэсэх байдлаар охид хохирогч болдог.

...Аав нь хөгжлийн бэрхшээлтэй, айл саахалт залуу аавтай нь архидах үедээ охины орох гарах цагийг мэдэн түлхүүрийн нуудаг газрын олж аваад гэрийн онгойлгож хүчирхийлсэн тохиолдол гарсан.

*Эх сурвалж: Хамтарсан багийн гишүүнтэй хийсэн ярилцлага*

...Гэр хорооллын алслагдмал байршилд амьдардаг, хойд эцэг нь архины хамааралтай ийм нөхцөлд охид бэлгийн хүчирхийлэлд өртөх эрсдэл нэмэгдэж байна.

*Эх сурвалж: Сургуулийн нийгмийн ажилтантай хийсэн ярилцлага*

Эцэг, эх болон асран хамгаалагчийн боловсролын түвшин доогуур, хараа хяналт сул байх тусам охид бэлгийн хүчирхийлэлд өртөхөд нөлөөлж байна. Кейс судалгаагаар бэлгийн хүчирхийлэлд өртсөн охидын эцэг эхийн боловсролын түвшинг харахад дийлэнх нь бага болон бүрэн дунд боловсролтой байв. Эцэг, эх, асран хамгаалагч нарын боловсролын түвшин доогуур байгаа шалтгааныг судлан үзэхэд хөгжлийн бэрхшээлтэй, ар гэрийн асуудлаас шалтгаалан сурах боломжгүй болсон байв. Мөн хамтарсан багийн гишүүдтэй хийсэн ярилцлагаар боловсрол багатай гэр бүл охидоо дуулгавартай байх, том хүний үг, үйлдлийг үг дуугүй, хүлцэнгүй дагах үүрэгтэй гэсэн жендэрийн хэвшмэл хандлагаар хүмүүжүүлэх нь түгээмэл байдаг байна.



### Шигтгээ 14. Эцэг эхийн боловсролын түвшний доогуур байдал

...Охид бэлгийн хүчирхийлэлд өртөхөд эцэг, эх, асран хамгаалагчийн боловсролын түвшин маш их нөлөөлж байна. Гарсан тохиолдлуудыг харахад ихэнх эцэг эх нь бүрэн дунд боловсролоос доогуур байна. Боловсролын түвшин доогуур байх тусам ажилгүйдэл, ядуурал, архидалт зэрэг нийгмийн асуудалд өртөмтгий болдог. Гэхдээ уг асуудалд гэр бүлийн санхүүгийн нөхцөл байдал шууд бус, харин дам байдлаар нөлөөлж байгааг хэлэх нь зүйтэй.

*Эх сурвалж: Хамтарсан багийн гишүүнтэй хийсэн ярилцлага*

Хүүхэд гэр бүлээсээ хайр халамж, тусламж дэмжлэгийг хүсч байдаг. Хамтарсан багийн гишүүнтэй хийсэн ярилцлагаар эцэг эх, асран хамгаалагчид охидыг хараа хяналтгүй орхин ажилд явсан хойгуур гол төлөв ойр дотны эсвэл таньдаг хүн уг үйлдлийг хийдэг болохыг баталсан.



### Шигтгээ 15. Эцэг эх, асран хамгаалагчийн хараа хяналт сул байдал

...Ээжийн ажилтай хойгуур нь хамтран амьдрагч нь охиныг хүчирхийлсэн тохиолдол гарсан.

...Эцэг, эхийн ажилдаа явсан хойгуур хамаатан садан эсвэл хөрш нь хүчирхийлэх тохиолдол гарч байна. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн ихэнх охид 6-10 насныхан байна.

*Эх сурвалж: Хамтарсан багийн гишүүнтэй хийсэн ярилцлага*


Охидыг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртөхөд цахим орчинд шүүлтүүргүй мэдээллийг авах, хүнтэй танилцах, амьдран суугаа газарт архи дан согтуурах нь түгээмэл, эрэгтэй хүн биед нь хүрэхийг байж болох зүйл, тоглоом гэж хүлээж авах зэрэг нь нөлөөлж буйг оролцогч талууд илэрхийлж байв.

**Матриц 7. Олон нийтийн түвшинд нөлөөлж буй хүчин зүйлүүд**

Хамтарсан багийн гишүүд	Ерөнхий боловсролын сургуулийн удирдлага, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч	Фокус бүлгийн ярилцлага
<ul style="list-style-type: none"> <li>Амьдран суугаа газарт иргэд архи дан согтуурах нь түгээмэл</li> <li>Хэт алслагдсан, дэд бүтэц сайтар хөгжөөгүй (гудамжинд гэрэлтүүлэг байхгүй, дутуу баригдсан барилга ихтэй)</li> <li>Цахим сүлжээгээр шүүлтүүргүй мэдээллийг авах, хүнтэй танилцах</li> <li>Шилжин ирсэн газраа албан ёсны бүртгэлгүй</li> <li>Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлд сургуулийн үүрэг оролцоо бага</li> <li>Хөршийн холбоо сул</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Цахим орчинд шүүлтүүргүй мэдээллийг авах, хүнтэй танилцах</li> <li>Эрэгтэй хүн биед нь хүрэхийг тоглоом гэж хүлээж авах</li> <li>Амьдран суугаа газарт иргэд архи дан согтуурах нь түгээмэл</li> <li>Хэт алслагдсан, дэд бүтэц сайтар хөгжөөгүй (гудамжинд гэрэлтүүлэг байхгүй, дутуу баригдсан барилга ихтэй)</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Цахим орчинд шүүлтүүргүй мэдээллийг авах, хүнтэй танилцах</li> <li>Эрэгтэй хүн биед нь хүрэхийг байж болох зүйл, тоглоом гэж хүлээж авах</li> </ul>

Эх сурвалж: ТБ-ын ажилтнуудтай хийсэн ГЯ болон ЕБС-ийн сурагчидтай хийсэн ФБЯ

Цахим орчны шүүлтүүргүй мэдээлэл нь охидыг бэлгийн хүчирхийлэлд өртөхөд нөлөөлж байна. Чанарын судалгааны үр дүнгээр охид цахим орчинд танилцсан хүнтэйгээ биеэр уулзан бэлгийн хүчирхийлэлд өртсөн тохиолдол гарч буй талаар мэдээллийг өгсөн. Тодруулбал, охин фэйсбүүкийн чатаар хүнтэй танилцан харилцдаг болж, хэсэг хугацааны дараа биеэр уулзахаар болсон. Охинтой уулзсан даруйдаа зочид буудал хамт орохыг тулган охин эсэргүүцсэн ч зургийг нь цахим орчинд тавина гэж сүрдүүлсэн байна. Энэ талаар гэр бүлийнхэндээ, ангийн багшдаа, цагдаад хэлж чадахгүй, сэтгэл зүйн дарамтад орсон тохиолдол гарсан байна.

 Шигтгээ 16. Цахим орчны шүүлтүүргүй мэдээлэл

...КОВИД-19 цар тахлын нөхцөл байдалд охид нийгмийн сүлжээгээр илүү их цагийг зарцуулах болж, хүнтэй танилцан уулзсанаар бэлгийн хүчирхийллийн хохирогч болсон тохиолдол гарсан. Охид анх удаа уулзах хүнийхээ талаар ямарч мэдээлэл байхгүй хэрнээ гэрт нь уулзана гэдэг бол ямар ч ойлголт мэдлэг байхгүй болохыг харуулж байна.

Эх сурвалж: Сургуулийн нийгмийн ажилтантай хийсэн ярилцлага

Судалгааны ажлын хүрээнд охидын бэлгийн хүчирхийлэлд өртөж буй орчин, үйлдэгчийг хамтарсан багийн гишүүдтэй, ЕБС-ийн нийгмийн ажилтнуудтай болон кейс судалгаагаар тодруулахад уг үйлдлийг гол төлөв гэр бүлийн орчинд төрсөн эцэг, хойд эцэг, хамаатан садан, таньдаг хүмүүс үйлдсэн. Цөөн тохиолдолд гэрт нь хонгуутаар ирсэн эцэг, эхийн найз нь үйлджээ. Ураг төрлийн болон таньдаг хүний зүгээс бэлгийн хүчирхийлэлд өртсөн тохиолдолд тохиолдолд хуулийн байгууллагад мэдээлдэггүй, мэдээлсэн ч томчууд хоорондоо “тохиролцоод” хүүхэд хохироод үлддэг асуудал байсаар байгааг УЕПГ-ын 2019 оны судалгааны үр дүнгээр мэдээлэгдсэн байдаг.



### Шигтгээ 17. Охидын бэлгийн хүчирхийлэлд өртөж буй орчин, үйлдэгч

...КОВИД-19 цар тахалтай холбоотой хөл хорионы үед аав, ээжийн ажилдаа явсан хойгуур ээжийн талын хамаатан нь охиныг хүчиндсэн хэрэг гарсан.

*Эх сурвалж: Хамтарсан багийн гишүүнтэй хийсэн ярилцлагаар*

...Хөдөө хамаатныдаа очоод шөнө айлчан их байсан тул бүгдээрээ хамтад нь ор засаад унтсан. Шөнө хамаатны нэг залуу охиныг оролдож эхэлсэн бөгөөд хүмүүсээс ичээд дуугарч чадахгүй байсаар байгаад хүчиндүүлсэн хэрэг гарсан.

*Эх сурвалж: Сургуулийн нийгмийн ажилтантай хийсэн ярилцлагаар*

...Хойд аав дүүг нь 1 настай байхаас эхлэн биеийг нь илэх, удаан ширтэх зэргээр мэдрэгдэж эхэлсэн. Ээжийн эзэнгүй үед намайг оролдож, хүчиндсэн.

*Эх сурвалж: Кейс судалгаагаар*

### 2.3.2. Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдал, чанар, хүртээмж

Энэ бүлэгт үйлчилгээ үзүүлэгч төрийн болон төрийн бус байгууллагуудын зүгээс үзүүлж буй хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний үе шат, чанар, хүртээмж, бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэргийн хохирогч/даван туулагчдад нэн шаардлагатай үйлчилгээний талаарх үр дүнг танилцуулна.

Ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагад оролцсон нийт 33 мэргэжилтнүүдийн зүгээс үзүүлж буй Хүүхэд хамгааллын тухай хуульд заагдсан үйлчилгээ үзүүлдэг ба тэрхүү үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмжид өгсөн үнэлгээний дунджаар тооцоход хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний чанар хүртээмжийг оролцогчдын 19.6 хувь сайн гэж үнэллээ.



#### Шалгуур үзүүлэлт:

Төслийн зорилтын шалгуур үзүүлэлт: Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний чанар хүртээмжийг оролцогчдын **19.6 хувь** нь сайн гэж үнэлсэн.

#### 2.3.2.1. Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэргийн хохирогч/даван туулагчдад үзүүлж буй хариу үйлчилгээний нөхцөл байдал

Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэргийн хохирогч, даван туулагчдад үзүүлж буй хариу үйлчилгээний талаар хууль эрх зүйн орчин, тогтолцоо бүрдсэн байна. Хүүхдийн эрх, хамгааллын бодлого шинэчлэгдэн батлагдсаны үндсэн дээр шинэ бүтэц, зохион байгуулалт бий болсон байдаг. Тухайлбал, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын харьяа Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвийн дэргэд түр хамгаалах байр 2017 онд байгуулагдсан байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль батлагдсанаас хойш хохирогчдыг түр хамгаалах байрлуулах, яаралтай тусламж, үйлчилгээнд хамруулах зорилго бүхий Нэг цэгийн үйлчилгээний төв (НЦҮТ), Түр хамгаалах байрыг бий болгосон төдийгүй салбар дундын гишүүдээс бүрдсэн хамтарсан баг байгуулагдан ажиллах болсон. Хүүхдийн хамгааллын тухай хуулийн хүрээнд хүүхдийн эрхийн хууль зүйн хороо гэж байгуулагдсан.

Өнөөдрийн байдлаар хүүхэд хамгааллын үйлчилгээний тогтолцоо Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын бүрэн чиг үүрэгт хамаарч байна. Тус газар нь үйл ажиллагаагаа 21 аймагт,

нийслэл болон 9 дүүрэгт нийт 1054 гаруй мэргэжилтнүүдийн бүрэлдэхүүнтэйгээр хүүхэд хамгааллын үйлчилгээг үндэсний хэмжээнд үзүүлж байна. Энэхүү чанарын судалгааны үр дүнгээр оролцогчид хүүхэд хамгаалал, хариу үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой харилцаанд харьцангуй дэвшил гарсан ба хохирогч хүүхдэд үзүүлэх үйлчилгээ тодорхой болсон хэдий ч үйлчилгээг хүргэхэд тогтмол санхүүжилт, хүний нөөц хангалтгүй хэвээр байгааг дурдсан. 2016 оны Хүүхэд эрхийн тухай хуульд зааснаар хүүхдийн эрхийн хэрэгжилтийг хянах зорилгоор хүүхдийн эрхийн ажилтан, улсын байцаагч гэсэн албан тушаалыг бий болгосон. Хүүхдийн эрхийн байцаагч нь хүүхдийн эсрэг зөрчлийг шалган шийдвэрлэх замаар хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах эрх бүхий ажилтан гэж заасан. Гэтэл бодит байдал дээр энэхүү албан тушаалыг хавсарган гүйцэтгэж байна. Зарим газар хүүхдийн эрхийн байцаагч байхгүй байх гээд хүний нөөц хомс байна гэлээ.

Судалгаанд үйлчилгээ үзүүлэгч төрийн байгууллагуудаас цагдаагийн байгууллагын хүүхдийн асуудал хариуцсан байцаагч, Шүүх эмнэлгийн ахлах шинжээч эмч, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын хүүхэд хамгааллын ажилтан, сэтгэл зүйн нөлөөллийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, сэтгэл зүйч, өмгөөлөгч, Нэг цэгийн үйлчилгээний төв, ГССҮТ-ийн НЦҮТ, дүүргийн хууль зүйн хорооны мэргэжилтнүүд зэрэг 18 алба хаагч, Хамтарсан багийн 10 мэргэжилтнүүд хамрагдсан ба тухайн салбартаа нэг сараас 20+ жил ажилласан туршлагатай байлаа. Үйлчилгээ үзүүлэгч төрийн бус байгууллагаас нийт 5 мэргэжилтэн хамрагдсан тэд бүгд салбартаа 5+ дээш жил ажилласан туршлагатай байлаа.

**Матриц 8.** Үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын үйлчилгээний төрлийн харьцуулалт

Үйлчилгээний төрөл	Үйлчилгээ үзүүлэгч төрийн байгууллага	Үйлчилгээ үзүүлэгч төрийн бус байгууллага
Мэдээлэл хүлээн авах, илрүүлэх	Хамтарсан баг ГБХЗХГ, 108 Хүүхдийн асуудал хариуцсан байцаагч НЦҮТ, ТХБ Өмгөөлөгч Сэтгэл зүйч	Хөөрхөн зүрх ХЭҮТ Гүнж Ид шидийн орон Good neighbors'
Нөхцөл байдлын үнэлгээ хийх	Нийгмийн ажилтан	Нийгмийн ажилтан
Аюулгүй байдлыг хангах	Цагдаа, Хамтарсан баг	ХЭҮТ, Ид шидийн орон
Дэмжих, холбон зуучлах	Үйлчилгээ үзүүлэгч төр төрийн бус байгууллагууд хохирогч/даван туулагчийг мэргэшсэн үйлчилгээний байгууллагад хандуулдаг.	
Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйлчилгээ үзүүлэх	Хууль зүйн хорооны мэргэжилтэн	Үгүй
Гэр бүлд нь нэгтгэх	Нийгмийн ажилтан, Хамтарсан баг	ХЭҮТ Хөөрхөн зүрх Ид шидийн орон

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан 6 төрлийн үйлчилгээг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн хохирогч/даван туулагчдад үзүүлж байна.


**Дүрс 15.** Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэргийн хохирогч/даван туулагчдад үзүүлж буй хариу үйлчилгээ



### 1. Мэдээлэл хүлээн авах, илрүүлэх, шалгах

Сүүлийн жилд хүүхэд хамгаалалд холбогдох хууль, дүрэм журмуудыг олон нийтэд сурталчлахад чиглэсэн нөлөөллийн ажлыг зохион байгуулсны үр дүнд хүүхдийн эсрэг хүчирхийллийн илрүүлэлт сайжирч байгаа билээ. Ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагын үр дүнгээс (n=33) харахад бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэргийн хохирогч/даван туулагчдыг үйлчилгээ үзүүлэгч төрийн болон төрийн бус байгууллагад хандахад гэр бүлийн хэн нэгэн, эсхүл ойрын эгч, найз нөхөд, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нар туслан дэмждэг байна.

**Дүрс 16.** Хохирогч/даван туулагчдыг дэмжиж тусламж үзүүлдэг хүн/байгууллага



**Шигтгээ 18.** Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогч/даван туулагчийн илрүүлэлт

ЕБС-ийн хүүхдүүдэд зөвлөгөө өгөх явцдаа бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчийг илрүүлж байсан. Тухай асуудлыг нийгмийн ажилтанд хэлэхэд цагдаад хандаж байсан.

*Сургуулийн нийгмийн ажилтантай хийсэн ярилцлагаар*

Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй зөрчил, гэмт хэргийн талаарх мэдээ, мэдээллийг хүлээн авсан бол нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтан, хамтарсан баг, хүүхдийн эрхийн хууль зүйн

хороо, хууль сахиулагч хүлээн авч шалгаж, шаардлагатай арга хэмжээ авах үүргийг хүлээсэн байдаг байна.

Цагдаагийн болон хүүхэд хамгааллын ажилтнууд хувьд хүүхдийн эсрэг хүчирхийлэл, зөрчил, тэр дундаа бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэргийн илрүүлэлт сайжирсан ба холбон зуучлах үйлчилгээгээр аюулгүй байдлыг ханган ажилладаг байна. Охид эрсдэлтэй нөхцөл байдалд орвол эсхүл эргэн тойрны хэн нэгэнд аюул тохиолдсон үед хүүхдийн тусламжийн утас 108 руу ганцаарчлан ханддаг байна. Тус утас нь 2020 оны байдлаар нийт 90,000 орчим дуудлага мэдээлэл хүлээн авснаас 55,000 орчим нь зорилтот дуудлага мэдээлэл<sup>38</sup> байжээ. Тус тусламжийн утас нь 24 цагийн турш, үнэ төлбөргүйгээр хүүхдийн эрхийн зөрчлийн мэдээлэл хүлээн авах, зөвлөгөө өгөх зорилготой байна. Түүнчлэн хамтарсан баг нь охидын эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийг илрүүлэхэд чухал үүрэгтэй. Сүүлийн 5 жилийн хугацаанд судалгаанд хамрагдсан дүүргүүдийн хамтарсан баг охидын эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгтэй холбоотой кейсийг илрүүлэн, ажилласан байна.

### Хүснэгт 20. Хамтарсан багийн кейс бүртгэл

№	Кейсийн үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021
1	Ажилласан кейсийн тоо	2	5	4	3	1
2	Холбон зуучилсан кейсийн тоо	1	4	2	1	2
3	Шилжүүлсэн кейсийн тоо	1	1	2	2	2
4	Хаагдсан кейс	2	5	4	6	5
5	Зөвлөгөө өгсөн (кейс нээгээгүй боловч уулзаж ярилцсан)		3			

Хүснэгт 20-оос харахад охидын эсрэг бэлгийн хүчирхийлэл, хүчиндэх гэмт хэргийн гаралт буурахгүй дүр зураг харагдаж байна. Ихэнх илэрсэн кейсүүдийг холбон зуучлах, харьяа оршин суугаа газрын хамтарсан баг руу шилжүүлэх байдлаар хаагдсан. Шинээр ажиллаж буй нийгмийн ажилтанд өмнөх онуудын тоо баримт байхгүй, кейсийн талаар ойлголт мэдлэг тааруу байгаа нь судалгааны явцад харагдсан. Эдгээр кейсийг дийлэнх тохиолдолд хамтарсан багийн зүгээс илрүүлсэн нь сайшаалтай.

Үйлчилгээ үзүүлэгч төрийн байгууллагын (n=18) анхан шатны нэгж дээр ажиллаж буй мэргэжилтнүүдийн хувьд мэдээлэл хүлээн авч, илрүүлэх, шалгах явцад дараах асуудлууд үүсдэг талаар дурдав:

- Кейс бүрд ажиллахад санхүүгийн дэмжлэг байдаггүй.
- Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үнэ төлбөргүй хэдий ч үйлчилгээнд хамруулахын тулд гэрээс нь очиж авах, хүргэж өгөх болон тухайн хүүхэд сургуульдаа явах зэрэгт зардлын асуудал тулгардаг байна. Эдгээрийг нийгмийн ажилтан, хамтарсан багийн гишүүд өөрсдийн мөнгөнөөс өгдөг гэв.
- Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн хувьд хуулийн байгууллагад хандах, хэргийн хянан шийдвэрлэх хугацаа маш удаан байдаг. Хуулийн байгууллагад хүүхдээс мэдүүлэг авах өрөө туйлын хангалтгүй, тав тухгүй өрөөнд хүүхдийг айдастай, дарамттай байх үед мэдүүлэг авдаг.
- Хохирогч хүүхэд бусдын ятгалгад амархан ордог. Гэтэл энэхүү үйл явцад мэдүүлэг авч буй хүн мэдрэмжтэйгээр ханддаггүй.
- Сэтгэл зүйн зөвлөгөө, заслын үйлчилгээ хангалтгүйн зэрэгцээ мэргэжлийн сэтгэл зүйч ажилладаггүй зэрэг хүндрэлийг дурдсан.

38 Ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэл

**Шигтгээ 19. Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн хохирогч хүүхдэд үзүүлсэн үйлчилгээ**

Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн хохирогч хүүхдэд туслалцаа үзүүлсэн. Хохирогч хүүхэдтэй холбоотой хэргийг хүүхдийн байцаагч, хүүхдийн байгууллагад холбон зуучлаад хорооны хамтарсан багт шилжүүлсэн. Хорооны хамтарсан баг гэрт нь нөхцөл байдлын үнэлгээ хийгээд дүүргийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар хүлээлгэн өгч аюулгүй зэрэг, сэтгэл зүйн зөвлөгөөнд хамруулах дүгнэлт гарсан. Ингээд анх ирж байсан хохирогч хүүхэдтэй эргээд холбогдох гэхээр хүнд байдаг. Хамтарсан баг юу хийж байгаа мэдээлэл байдаггүй.

*Үйлчилгээ үзүүлэгч төрийн байгууллагын төлөөлөлтэй хийсэн ярилцлагаар*

Төрийн бус байгууллагын хувьд бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэргийн хохирогчийг илрүүлэх тохиолдолд заавал цагдаагийн болон хамтарсан багт мэдээлдэг хэдий ч хохирогч хүүхдэд үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлдэг байна. Төрийн бус байгууллагууд (n=5) хохирогчдод үйлчилгээ үзүүлэх шаардлагатай санхүүжилтийг олон улсын байгууллагаас төсөл бичиж авдаг ба тус байгууллагууд нь илүү мэргэшсэн мэргэжилтэн болон баг ажиллуулдаг байна. Гэхдээ нөгөө талаас төрийн бус байгууллагын хувьд санхүүжилт тогтмол бус учраас хариу үйлчилгээ, хүний нөөц мөн адил тогтвортой байх боломжгүй байдаг. Төрийн байгууллагаас хариу үйлчилгээг үзүүлэх ажлыг гэрээлэн авдаг хэдий ч санхүүжилтэд ажилтны цалин урамшуулал тусгадаггүй сул талтай. Мөн санхүүжилт нь жилийн эцэст орж ирдэг зэрэг бэрхшээлүүд түгээмэл байна.

Төрийн бус байгууллагаас үзүүлж буй хариу үйлчилгээний чанарыг охидын эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн хохирогч/даван туулагчид “сайн” гэж үнэлсэн. Гэхдээ судалгааны багийн хувьд үйлчилгээ үзүүлэгч төрийн бус байгууллагатай уулзахад бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэргийн хохирогч/даван туулагчидтай ганцаарчилсан уулзалт хийх боломж олгоогүй ба ярилцлагад нийгмийн ажилтан, хэн нэгэн нь хамт байсан учир үйлчилгээний чанар, хүртээмжийг бодитоор гаргахад хүндрэл тулгарав.

**2. Нөхцөл байдлын үнэлгээ хийх**

Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэхийн тулд нэн түрүүнд нөхцөл байдлын үнэлгээ хийдэг. Үнэлгээ нь хүүхдийн амьдарч байгаа орчин, хүүхдэд үүссэн нөхцөл байдал, хүүхдийн эрхийн эсрэг үйлдэл, эс үйлдэхүйн аюул, эрсдэлийн түвшнийг үнэлэх, шалгах, дүгнэх үе шатуудаас бүрдэнэ.

Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэргийн насанд хүрээгүй хохирогч/даван туулагчийн талаарх мэдээ, мэдээлэл хүлээн авсан бол нөхцөл байдал, аюулын зэргийн үнэлгээ хийдэг. Аюулын зэргийн түвшнээс хамаарч Хамтарсан баг, аймаг, нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас шууд цагдаагийн байгууллагад шилжүүлдэг байна. Үйлчилгээ үзүүлэгч төрийн болон төрийн бус байгууллагуудын (n=33) бүхий л нийгмийн ажилтнуудад хамгийн эхний ажил үүрэг нь нөхцөл байдлын үнэлгээ хийснээр хохирогчтой ажиллах нийгмийн ажил үйлчилгээ эхэлдэг байна.





## Шигтгээ 20. Нөхцөл байдлын үнэлгээ

Хамтарсан багийн нийгмийн ажилтан байхгүй бол нөхцөл байдлын үнэлгээ хийдэггүй. Тэгэхээр хамтарсан багийн гишүүдийн нөхцөл байдлын үнэлгээ хийх ажилд суралцуулах хэрэгтэй юм шиг санагддаг.

*Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын төлөөлөлтэй хийсэн ярилцлагын хэсгээс...*

Нөхцөл байдлын үнэлгээг хийхтэй холбоотой санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна. Хамтарсан багийн гишүүн болох нийгмийн ажилтан нартай ганцаарчилсан ярилцлага (n=8) хийхэд бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэрэгт өртсөн хүүхэдтэй ажиллахад арга зүй дэмжлэг хэрэгцээтэй байдаг гэдгийг тодотгож байсан юм. Тухайлбал хэрхэн зөв, оновчтой ярилцлага хийх, нотлох баримт бүрдүүлэхэд анхаарах асуудал, дахин хохирогч болгохгүй байхын тулд юу хийх зэрэг асуултуудтай тулгардаг байна. Нөхцөл байдлын үнэлгээг ганцхан хохирогч/даван туулагчтай уулзаад хийхгүй, гэр бүл, сургуулийн орчныг судлах хэрэгцээ их гардаг ба үүнтэй холбоотой унаа, харилцаа холбооны асуудал тулгардаг.

Хамтарсан багийн нийгмийн ажилтны (n=8) ажлын ачаалал их байна. Нийгмийн ажилтан нь зорилтот бүлэгтээ хүрч ажиллах ёстой байтал хорооны захиргааны ажлаас илүү гарч чаддаггүй. Тиймээс хамтарсан багийн гишүүдийн ажил үүргийг тодорхой болгох шаардлага зайлшгүй шаардлагатай байна гэж үйлчилгээ үзүүлэгч төрийн байгууллагын төлөөлөл саналаа илэрхийлж байсан. Мөн ганцаарчилсан ярилцлагад хамрагдсан төрийн байгууллагын алба хаагчдын ажлын туршлага нь нэг сараас эхэлж байлаа. Эндээс дүгнэхэд төрийн байгууллагын алба хаагчид тогтвортой бус, байнга өөрчлөгдөж байгаатай холбогдуулан хохирогч/даван туулагчдад үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмжийг тодорхойлоход хүндрэлтэй байлаа.



## Шигтгээ 21. Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын хүний нөөцийн чадавх

Манай байгууллагын хувьд хүний нөөцийн чадавх 100 хувь бүрдсэн гэж хэлж чадахгүй. Яагаад гэвэл хүний нөөц шат бүрд маш их солигдож байна. Маш их ачаалалтай ажиллаж байна. Хүний нөөцийн хүртээмжийн асуудал учир дутагдалтай байна. Дээрээс нь бэлгийн мөлжлөгийн хохирогчтой ажиллах тодорхой арга зүй, удирдамж байхгүй байна.

*Үйлчилгээ үзүүлэгч төрийн байгууллагын төлөөлөлтэй хийсэн ярилцлагын хэсгээс...*

Үйлчилгээ үзүүлэгч төрийн бус байгууллагын (n=5) нөхцөл байдлын үнэлгээ түүнчлэн хохирогч/даван туулагчдад үзүүлсэн үйлчилгээний кейс бүрдүүлэлтэд үнэлгээ хийх хүсэлтийг гаргасан хэдий ч тухайн байгууллагууд үзүүлэх хүсэлгүй байлаа. Судалгааны багийн хувьд үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ажлыг дүгнэхээс илүүтэй хохирогч/даван туулагчдад үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмжийг тодруулах нь чухал бөгөөд судалгааны нэг зорилт байсан.

### 3. Аюулгүй байдлыг хангах

2020 онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх журмыг шинэчлэн баталсан<sup>39</sup>. Тус журмаар хүүхэд хамгааллын анхан болон хоёрдогч шатны урьдчилан сэргийлэх, хамгаалах, холбон зуучлах үйлчилгээг Хамтарсан баг үзүүлнэ гэж заасан байна. Аюулгүй байдлыг хангах, дэмжих, холбон зуучлах үйлчилгээг асуудал эрхэлсэн төрийн байгууллага, магадлан итгэмжлэгдсэн хуулийн этгээд, тухайн

<sup>39</sup> Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн А/148 тоот тушаалын хавсралт

асуудлаар мэргэшсэн иргэн үзүүлж, хүүхэд, гэр бүлийн нөхцөл байдал сайжирсан эсэхэд хяналт үнэлгээ хийж, эргэх холбоотой ажиллана. Аюулгүй байдлыг хангах үйлчилгээг үзүүлэхийн тулд цагдаагийн албан хаагч аюулын зэргийн үнэлгээ хийх ба тус үнэлгээгээр хохирогч дунд, өндөр эрсдэлтэй нь тогтоогдсон бол эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн саналыг харгалзахгүйгээр харьяа хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад мэдэгдэж, түр байрлуулан хамгаалах үйлчилгээнд холбон зуучилдаг байна.

Үйлчилгээ үзүүлэгч төрийн байгууллагуудын (n=28) хувьд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогч/даван туулагчдын аюулгүй байдлын хангах зорилго бүхий түр байрлуулан хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээний төвд (нийт 43 байр) байрлуулдаг байна. 2020 оны байдлаар ТХБ, НЦҮТ-р нийт 4659 хүн үйлчлүүлсний 45 орчим хувь нь насанд хүрээгүй хүн байна<sup>40</sup>. Харин төрийн бус байгууллагын хувьд Хүчирхийллийн эсрэг үндэсний төв дэргэдээ хохирогч/даван туулагчийг түр байрлуулан хамгаалах үйлчилгээ үзүүлдэг. Тус байр нь жилдээ 30 хүн байрлуулдаг ба нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, хуулийн зөвлөх, 24 цагийн халамжлагч ажилтнууд 72:48 хуваариар ажилладаг бүрэлдэхүүнтэй байна. Эдгээр түр хамгаалан байрлуулах байр нь 2019 оны Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага<sup>41</sup> стандартын дагуу аюулгүй байдал, зөвлөгөө өгөх өрөөтэй эсэх, байрлагчдад байрлах наад захын шаардлага хангасан эсэхийг ганцаарчилсан ярилцлагаар гаргахыг зорьсон. Ганцаарчилсан ярилцлагад оролцогчдын үзэж буйгаар төрийн байгууллагыг түшиглэсэн тэрхүү байгууламжууд нь стандартын шаардлага хангаагүй ч стандартын дагуу үйлчилгээ үзүүлж байгаа гэв. Харин төрийн бус байгууллагын хувьд стандартын дагуу байж чадахуйц бие даасан, хохирогчдод ээлтэй орчин бүрдүүлэн ажиллаж байгаа гэдгийг дурдав. Эдгээр байрнуудын хувьд хүчин чадлын хувьд бүгд өөр өөр бөгөөд үзүүлж буй үйлчилгээ нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заагдсан долоон төрлийн үйлчилгээ<sup>42</sup> түлхүү үзүүлдэг байна.

Хүүхэд байрлуулах дагнасан ганцхан байр байдаг ба тэр нь Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрыг дэргэд ажилладаг<sup>43</sup>. Хүчин чадлын хувьд 25 ортой, хоногт 35-40 хүлээн авдаг байна.



## Шигтгээ 22. Үйлчилгээ үзүүлэгч ТББ байгууллага

Хүчирхийллийн эсрэг Үндэсний төв нь эрүүл мэндийн үзлэг хийх тусгай өрөөгүй ба харин хохирогчийг хамгаалан байрлуулах байрны аюулгүй байдал хангагдсан байртай, хохирогч тав тухай байрлах боломж бүрдсэн, зөвлөгөө өгөх өрөөтэй, ажилтны болон амралтын өрөөтэй, мэдээлэл авах боломжтой байдаг гэв.

*Үйлчилгээ үзүүлэгч төрийн бус байгууллагын төлөөлөлтэй хийсэн ярилцлагын хэсгээс...*

Үйлчилгээ үзүүлэгч төр болон төрийн бус байгууллагуудын хувьд бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэргийн хохирогч/даван туулагчтай ажиллах тусгайлсан бодлого байдаг эсэхийг тодруулахад тусгай бодлого байхгүй, харин хүүхэд хамгааллын бодлого дотор багтдаг гэж байлаа. Цаашид бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн хохирогч/даван туулагчидтай ажиллах үед баримтлах удирдамжийг гарган ажиллах хэрэгцээтэй байна. Мөн түр хамгаалан байрлуулах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн хүчин чадал, хүний нөөц, санхүүжилт, чадавхыг гүнзгийрүүлэн судлах шаардлагатай.

40 Нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр, хамтарсан багийн үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийнэ - Хүний эрхийн Үндэсний Комисс (nhrcm.gov.mn)

41 Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага (estandard.gov.mn)

42 <https://familycenter.mn/news/106>

43 <https://news.mn/r/2406695/>

#### 4. Дэмжих, холбон зуучлах

Нөхцөл байдлын үнэлгээгээр хүүхдэд тусламж, үйлчилгээ үзүүлэх дүгнэлт гарсан бол иргэний бүртгэл, сэтгэл зүй, хууль зүй, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн болон бусад шаардагдах үйлчилгээнд нийгмийн ажилтан холбон зуучилна. Холбон зуучлах үйлчилгээний хэрэгжилтэд хүүхдийн эрхийн ажилтан хяналт тавина.

Хамтарсан баг нь хүүхэд болон гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээ, аюулын зэргийн зэргийн үнэлгээнд үндэслэн дараах холбон зуучлах үйлчилгээ үзүүлнэ.

##### *Дүрс 17. Холбон зуучлах үйлчилгээний төрөл*



Судалгаанд сонгогдсон дүүргүүдийн Хамтарсан баг (n=10) 2017-2021 оны байдлаар бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэрэгт өртсөн хохирогч/даван туулагчтай холбоотой 10 кейсийг холбон зуучлах үйлчилгээгээр бусад байгууллагууд руу шилжүүлсэн байна.

Үйлчилгээ үзүүлэгч төрийн байгууллагын мэргэжилтнүүд дийлэнх тохиолдолд бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэргийн хохирогчийг ихэвчлэн сэтгэл зүйн зөвлөгөө, заслын үйлчилгээнд хамруулахаар мэргэшсэн төрийн бус байгууллага руу холбон зуучлах үйлчилгээ үзүүлж байна. Мөн бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэргийн хохирогчийг урт хугацаанд байрлуулах хамгаалах байр байдаггүй учраас хамгаалах байртай үйлчилгээний байгууллагад мөн холбон зуучилдаг. Тухайлбал, сэтгэл зүйн зөвлөгөө, заслын үйлчилгээнд хамруулахаар Хөөрхөн зүрх ТББ, Хамгаалах байрны үйлчилгээнд Хүчирхийллийн эсрэг үндэсний төв хандуулдаг гэж байлаа. Төрийн байгууллагын НЦҮТ, Түр хамгаалах байрны үйлчилгээ нь 72 цагаас 3 сар хүртэл хугацаанд байрлуулдаг.

Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэргийн кейс дээр ажиллахад цаг хугацаа, санхүүжилт хэрэгцээтэй байдаг. Хохирогч хүүхдэд үйлчилгээ үзүүлэх зардлыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас Хүүхдийн хамгааллын зардлаас санхүүжүүлдэг. Нэг хүүхдийн үйлчилгээнд үзүүлэх үйлчилгээнүүдэд гарах хувьсах зардлын тооцоо байдаггүй учраас хүүхэд бүрийн зардал харилцан адилгүй байдаг.



### Шигтгээ 23. Эргэх холбоо

Холбон зуучлах үйлчилгээний кейсийн шийдвэрлэлт талаарх мэдээлэл солилцох байдал муу байдаг. Эргэн мэдээлэл үйл явц хангалтгүй. Зарим нь мэдээлэл өгөхөөс татгалздаг.

*Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын төлөөлөлтэй хийсэн ярилцлагын хэсгээс...*

Үйлчилгээ үзүүлэгч төрийн байгууллагын (n=18) хувьд бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэргийн хохирогч/даван туулагчтай ажиллахад мэргэжил арга зүйн дэмжлэг туслалцааг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, мэргэжлийн төрийн бус байгууллагууд болох Хөөрхөн зүрх, Хүчирхийллийн эсрэг үндэсний төвд хандаж туслалцаа авдаг гэв.

Сэтгэцийн гэмтэлд суурилсан, хохирогч төвтэй арга зүйн талаар төрийн байгууллагуудын төлөөлөл (n=28) хангалттай мэдлэггүй байна. Өнөөдрийн байдлаар сэтгэцийн гэмтэлд суурилсан, хохирогч төвтэй арга зүйгээр Хөөрхөн зүрх ТББ ажилладаг ба мэргэжлийн бүлгүүдэд тогтмол сургалт зохион байгуулах замаар тэдний мэдлэг, мэдээлэл нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулдаг байна.



### Шигтгээ 24. Арга зүй

Сэтгэцийн гэмтэлд суурилсан, хохирогч төвтэй арга зүйг мэддэггүй. Хохирогчийг урт хугацааны нөхөн сэргээх үйлчилгээнд, сэтгэл заслын үйлчилгээнд бага насны хүүхдийг хамруулах шаардлага их байдаг. Тиймээс бид мэргэжлийн байгууллага болох Хөөрхөн зүрх, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв рүү хандуулдаг.

*Үйлчилгээ үзүүлэгч төрийн байгууллагын төлөөлөлтэй хийсэн ярилцлагын хэсгээс...*

## 5. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйлчилгээ үзүүлэх

Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагааг Хүүхдийн хамгааллын тухай хуулийн 15 дугаар зүйлд анх удаа хуульчлан оруулж өгсөн байдаг. Аймаг, дүүргийн Засаг дарга орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралтай зөвшилцөн хүүхдийн эрхийн хууль зүйн хороог байгуулах ба тус хорооны ажлын албаны үүргийг орон нутгийн хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн байгууллага хэрэгжүүлнэ гэж заасан. Түүнчлэн Хүүхдийн хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөрийн (2017-2021) “нийгмийн бүх орчинд хүүхэд бүрийг үл хайхрах байдал, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэр, эрсдэлт нөхцөлд өртөхөөс хамгаалах” 4 дүгээр зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд<sup>44</sup> гэмт хэргийн гэрч, хохирогч болсон, сэжигтэн, мөрдөн шалгагдаж байгаа, ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан, шүүхээр шийтгэгдсэн хүүхдэд хууль зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагааг тогтмолжуулах ажлыг хэрэгжүүлэхээр тусгасан. Тус хороо нь зөвхөн 21 аймаг, 9 дүүргийн түвшинд нийт 30 хороо нь төрийн байгууллагын 400 орчим удирдах албан тушаалтнаас бүрдэн ажиллаж байна.

44 Засгийн газрын 2017 оны 270 дугаар тогтоолын хавсралт “Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр”



## Шигтгээ 25. Хүүхдийн эрхийн байцаагч

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн хүүхдийн эрхийн улсын байцаагч гэж дүүргүүд дээр 1-2 байцаагч байдаг. Манай дүүрэг гэхэд 25 хороотой, 25 хороон дээр 2 хүүхдийн эрхийн улсын байцаагч байдаг. Хаанаа ч хүрдэггүй.

*Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын төлөөлөлтэй хийсэн ярилцлагын хэсгээс...*

Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны зохион байгуулалт, гишүүдийн бүрэн бүрэлдэхүүнээр ажиллах боломжгүй байна. Цаашлаад төрийн байгууллагын тогтворгүй байдлаас болж гишүүд байнга өөрчлөгдөж байдаг, үйл ажиллагаа нь тогтвортой бус байдаг, мөн тухай хорооны тайлан, мэдээллийг хэн нэгтгэх, хэрхэн хариуцлагажуулах талаарх зохицуулалт дутмаг байдагтай холбоотой гэж дурдаж байлаа.

Хүүхдийн эрхийн тухай хуульд заасны дагуу хүүхдийн эрхийн зөрчлийг шалган шийдвэрлэх замаар хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах үүрэг бүхий субъектийг Хүүхдийн эрхийн улсын байцаагч гэдэг. Одоогийн байдлаар хуульд заасан шалгуур, болзол хангасан 70 орчим байцаагч эрхээ аван ажиллаж байна. Эдгээр эрх бүхий байцаагч нь ажил, үүрэг хавсран гүйцэтгэж байгаа ба бүгд үндсэн ажил дээрээ нэмэлт чиг үүргийг хэрэгжүүлдэг байна. Тиймээс хүүхдийн эрхийн байцаагчийн үндсэн үүргийн хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, хүүхдийн эрхийн улсын байцаагчийн хүрэлцээ муу байдаг. Нэг дүүрэгт 1-2 байцаагчтай. Үүнээс шалтгаалан цаашид хүүхдийн эрхийн байцаагчийн эрх зүйн байдлыг дээрдүүлэх, тусдаа ажил үүрэгт тооцох хэрэгцээтэй байгаа байдал ажиглагдав.

### 6. Гэр бүлд нь эргэн нэгтгэх

Нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтан хүүхэд асрах хувилбарт болон төвлөрсөн асрамжийн үйлчилгээнээс хүүхдийг гэр бүлд нэгтгэх үйл ажиллагааг зохион байгуулж хяналт тавьдаг.

Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын мэргэжилтнүүд хохирогч хүүхдийг гэр бүлд нэгтгэх үйлчилгээг 2020 оны Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх журмын дагуу хэрэгжүүлдэг байна. Гэхдээ тэд бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэрэгт өртсөн хохирогч хүүхдийг гэр бүлд нь нэгтгэхийн өмнө түр хугацаанд хамгаалан байрлуулах байранд байлгах нь чухал гэж үзэж байлаа. Учир нь бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэрэгт өртсөн хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хариу үйлчилгээг тасралтгүй, тогтмол үзүүлэх шаардлагатай байдаг. Энэ төрлийн үйлчилгээ үзүүлэхийн тулд мэргэжлийн нийгмийн ажилтан байх хэрэгцээтэй бөгөөд гэр бүл, сургуулийн орчныг судлах, дахин хохирогч болохоос урьдчилан сэргийлэх ажил хийх нь хэрэгцээ бий болдог. Гэтэл энэ бүх үйлчилгээ үзүүлэхэд хүний нөөц, санхүүжилтийн асуудал дутмаг байдлаас болж хангалттай түвшинд үзүүлэх боломжгүй байдаг байна.



## Шигтгээ 26. Хохирогч/даван туулагчдын сэтгэлзүйн жишээ

Гэртээ харимаар байдаг. Дүү нартайгаа тогломоор санагддаг. Цагдаагийн асуудал дуусаагүй болохоор харих болоогүй гэсэн.

*Үйлчилгээ үзүүлэгч ТББ-д хандсан хохирогч/даван туулагчтай хийсэн ярилцлагын хэсгээс...*

Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэргийн насанд хүрээгүй хохирогч/даван туулагчдад урт хугацааны нийгэм, сэтгэл зүйн нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх нь чухал байдаг. Энэ төрлийн үйлчилгээг төрийн бус байгууллагын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлдэг байна.



### Шигтгээ 27. Хохирогч/даван туулагчдын авсан үйлчилгээний сэтгэл ханамжийн байдал

Үйлчилгээ үзүүлдэг байгууллагын эгч нар сайхан ааштай, харилцаатай байдаг. Надад үзүүлж буй үйлчилгээ тайлбарлаж өгдөг. Бид долоо хоногтоо 2-3 удаа зөвлөгөө авдаг. Анх маш буруу зүйл их боддог, айдастай байсан. Зөвлөгөөнд 3 сараас дээш хугацаанд яваад ирсэн чинь сэтгэл санаа сайхан болсон. Зөвлөгөөнөөс гадна бүжгийн дугуйлан, зургийн, амьдрах ухааны сургалтуудад хамрагддаг.

*Үйлчилгээ үзүүлэгч ТББ-д хандсан хохирогч/даван туулагчтай хийсэн ярилцлагын хэсгээс...*

Үйлчилгээ үзүүлэгч төрийн байгууллагуудын хувьд хүүхэд хамгааллын эрх зүйн орчин, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх үйлчилгээний төрөл хэлбэрийг тодорхой болгосон хэдий ч хэрэгжилтийн түвшинд хангалтгүй байна. Учир нь бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэргийн кейс дээр ажиллах салбар дундын хамтын ажиллагаа өнөөг хүртэл нэгдсэн цогц арга хэмжээнд орж чадаагүй. Энэ төрлийн гэмт хэрэгт өртсөн хохирогч/даван туулагч өнөөг хүртэл олон байгууллагын хаалга татан үйлчилгээнд хамрагдаж байна. Тухайлбал, эрүүл мэндийн асуудлыг эрүүл мэндийн төв рүү хандах, хуулийн байгууллагад хандах бол цагдаа, шүүх эмнэлэг, сэтгэцийн эрүүл мэндийн байгууллага, өмгөөлөл, прокурор, шүүхэд ханддаг, мөн түүнчлэн үйлчилгээ үзүүлэгч байгууллагад хандах, хамгаалах байранд байрлах зэрэг хохирогч руу чиглэсэн үйлчилгээ салангид байгааг харуулж байна. Үүнээс улбаалан сэтгэцийн гэмтэлд суурилсан хохирогч төвтэй арга зүй өнөөгийн байдлаар хохирогчдод үзүүлдэг үйлчилгээнд нэвтрээгүй байна.




### Шигтгээ 28. Мэргэшсэн хүний нөөц

Хүүхэд хамгаалал, хүүхдэд хариуг үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой эрх зүйн орчин сайжирсан. Бүх байгууллагын чиг үүрэг тодорхой болсон. Хүүхдэд үзүүлэх үйлчилгээ зэрэг тодорхой болсон, санхүүжилт нь шийдвэрлэгдсэн. Гагцхүү мэргэжлийн баг, мэргэшсэн хүний нөөц дутмаг байгаа. Салбар дундын уялдаа холбоо хангалтгүй байгаа. Эдгээрийн сайжруулах хэрэгтэй.

*Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын төлөөлөлтэй хийсэн ярилцлагын хэсгээс...*


### Дүрс 18. Хариу үйлчилгээний оролцогчид



Энэ бүхий л хариу үйлчилгээний үйл явцаас харахад хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ нэгдмэл бус салангид байгааг харуулахын зэрэгцээ бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэргийн насанд хүрээгүй хохирогч/даван туулагчдад хариу үйлчилгээ үзүүлэх бүхий л үйлчилгээ нь нэг дороос үзүүлдэг төв бий болгох эсвэл байгаа төвүүдэд тусад нь байрлуулах нэг өрөөг бий болгох хэрэгцээ бий болсон байгааг харуулж байна. Энэ нь одоогийн хохирогчийг түр байрлуулан хамгаалах үйлчилгээ нь зөвхөн гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчийг байрлуулдаг ба бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэргийн хохирогч/даван туулагч хүүхдийг байрлуулах газар олддоггүй гэсэн гэж ганцаарчилсан ярилцлагын үр дүн дээр суурилсан.

Хүүхэд тэр дундаа бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэргийн хохирогчийг урт хугацаанд нөхөн сэргээх төв байгуулах хэрэгцээ байна. Ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагын үр дүнгээс харахад зарим тохиолдолд хохирогч хүүхдийг байрлуулах газар олдохгүй хэцүү байдаг гэж дурджээ. Ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагад оролцогчдыг ярилцлагад тулгуурлан дараах үйлчилгээний зураглалыг гаргалаа.

**Дүрс 19.** Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэрэгт өртсөн хохирогч/даван туулагчдад үзүүлж буй хариу үйлчилгээний зураглал



2021 онд шинэчлэн найруулж буй Хүүхэд хамгааллын тухай хуулийн төслийн танилцуулгад<sup>45</sup> хүүхэд хамгааллын үйлчилгээний төсвийг хүүхэд хамгааллын үйлчилгээний хэлбэр тус бүрээр улс, орон нутгийн төсөвт тусгах, хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлыг төсөвлөхдөө өмнөх

45 ХНХЯ, Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн танилцуулга 2021 он www.mlsp.gov.mn

онд шийдвэрлэсэн хүүхэд хамгааллын кейст тулгуурлаж дараа онд зарцуулах мөнгөн дүнг тогтоодог байхаар заажээ. Хэрэв шинэчилсэн хууль батлагдвал хүүхэд хамгааллын үйлчилгээнд зарцуулагдах төсөв тогтмол улсын төсөвт тусгагдаж, хүүхэд хамгааллын үйлчилгээг сайжруулах нөхцөл бүрдэж байгаа байдал ажиглагдаж байна.

Алба хаагч, мэргэжилтнүүдийн хувьд ч мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх сургалтад хамрагдах хэрэгцээтэй байдаг талаар судалгаанд оролцогчдын дийлэнх нь илэрхийлж байлаа. Ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагын үр дүнд үйлчилгээ үзүүлэгч төрийн байгууллагын алба хаагч, мэргэжилтнүүдийн хувьд сэтгэцийн гэмтэлд суурилсан, хохирогч төвтэй арга зүйд суралцаж байгаагүй бөгөөд бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэргийн хохирогчид үзүүлж буй үйлчилгээндээ уг арга зүйг нэвтрүүлэн ажиллаж чаддаггүй байна.

### 2.3.2.2. Үйлчилгээ үзүүлэгч төрийн бус байгууллагын чадавх, хүний нөөц, хүртээмж

Судалгаанд оролцсон үйлчилгээ үзүүлэгч төрийн бус байгууллагуудын хувьд нийт таван байгууллага хамрагдсан ба нэг нь үйлчилгээ үзүүлдэг байгууллага биш байлаа. Үлдсэн 4 байгууллагын хувьд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх хүний нөөц, чадавхыг тодруулан дараах хүснэгтэд харуулав.

**Хүснэгт 21.** Хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын хүний нөөц, чадавх

Байгууллагын нэр, төрөл	Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ
Гүнж төв ТББ	<p><b>Үйлчилгээ:</b> 31 охидод нийгмийн ажил үйлчилгээ үзүүлсэн туршлагатай. Хамгаалах байр байхгүй тул Цөлийн сарнай ТББ, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв ТББ-ын хамгаалах байр руу холбон зүүчилдэг. Өмгөөлөгчтэй гэрээ байгуулж өмгөөллийн үйлчилгээ үзүүлж байсан. Эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулж байсан. Сэтгэл заслын үйлчилгээг Хөөрхөн зүрх ТББ хамтран хийдэг. Харин Хөөрхөн зүрх ТББ-с зохион байгуулдаг сэтгэцийн гэмтэлд суурилсан хохирогчтой төвтэй арга зүй олгох сургалтад хамрагддаг гэв.</p> <p><b>Үйлчлүүлэгчийн тоо мэдээлэл:</b> 2012 оноос хойш үйлчилгээ үзүүлэхээ зогсоосон. Гэхдээ жил бүр үйлчлүүлэгч ирдэг. Сүүлийн 5 жилийн байдлаар бэлгийн хүчирхийллийн хохирогч болоод хүүхэд төрүүлсэн 5 ээжид үйлчилгээ үзүүлсэн.</p> <p><b>Санхүүжилт:</b> Төрийн байгууллагаас ямар нэгэн санхүүгийн дэмжлэг байдаггүй. Дийлэнх санхүүжилтийг Монгол Улсад суугаа гадаадын Элчин сайдын яам, мөн олон улсын байгууллагаас хүлээн авдаг байна.</p> <p><b>Хүний нөөц:</b> Нийгмийн ажилтан, сайн дурын ажилтнуудтай</p>
Хөөрхөн зүрх ТББ	<p><b>Үйлчилгээ:</b> Бэлгийн хүчирхийлэлд өртсөн насанд хүрээгүй хүүхдүүдэд нийгэм-сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлдэг. Үйлчилгээг үзүүлэх хугацаа доод тал нь 3 сар. Хүүхдүүдэд үзүүлж буй үйлчилгээ бол сэтгэцийн гэмтэлд суурилсан, хохирогч төвтэй аргуудыг ашигладаг.</p> <p><b>Үйлчлүүлэгчийн тоон мэдээлэл:</b> Сүүлийн таван жилд 150 гаруй хүүхдүүдтэй ажиллаж байгаа, жилд дунджаар 35-45 хүүхэдтэй ажилладаг. Хүйсийн хувьд 10 хувь нь эрэгтэй, 90 хувь нь эмэгтэй хүүхэд эзэлдэг байна.</p> <p><b>Санхүүжилт:</b> Төрийн байгууллагатай сэтгэл зүйг үйлчилгээ үзүүлэх чиглэлээр гэрээлэн ажилладаг. Олон улсын байгууллагын дэмжлэгийг хохирогчдод үйлчилгээ үзүүлэх чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх замаар авдаг. Үйлчлүүлэгчдээс үйлчилгээ үзүүлсэн гэж төлбөр авдаггүй.</p> <p><b>Хүний нөөц:</b> Бэлгийн хүчирхийллийн чиглэлээр ажилладаг мэргэжлийн сэтгэл зүйч, мэргэжлийн нийгмийн ажилтнууд ажилладаг.</p>



<p>Хүчирхийллийн эсрэг үндэсний төв ТББ</p>	<p><b>Үйлчилгээ:</b> Хамгаалах байрандаа гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэд, эмэгтэйчүүдийг тодорхой хугацаанд байрлуулан ГБХТХ-д заасан долоон төрлийн үйлчилгээг цогцоор нь үзүүлдэг.</p> <p><b>Үйлчлүүлэгчийн тоон мэдээлэл:</b> Жилдээ 25-30 үйлчлүүлэгчид хандаж үйлчилгээ авдаг.</p> <p><b>Санхүүжилт:</b> Олон эх үүсвэрээс санхүүжилтээ бүрдүүлдэг. Төрийн байгууллагаас зарлагдсан зөвлөх ажил үйлчилгээнд оролцох, олон улсын байгууллагын дэмжлэг, туслалцаа авдаг. Мөн олон нийтийн зүгээс хандив, тусламж ирүүлдэг.</p> <p><b>Хүний нөөц:</b> Хамгаалах байранд нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, хуулийн зөвлөх, 24 цагийн халамжлагч ажилтнууд 72:48 ажилладаг бүрэлдэхүүнтэй.</p>
<p>Гүүд нэйборс ОУБ /Good neighbors/ Сайхан сэтгэл төв</p>	<p><b>Үйлчилгээ:</b> Дүүрэг бүрд салбартай. Эмзэг бүлгийн амьжиргааны түвшин доогуур гэр бүл, хүүхдэд зориулсан хөгжлийн үйл ажиллагаа явуулдаг. Оюу-Толгой болон бусад ОУБ-тай хамтраад сургуулиудад сэтгэл зүйч ажиллуулж байгаа. Ингэхдээ хүүхэдтэй уулзах, мөн зөвлөгөөний үеэр кейс илэрвэл хамтарсан багт мэдэгдэж, холбон зуучлах үйлчилгээ үзүүлдэг.</p> <p><b>Үйлчлүүлэгчийн тоон мэдээлэл:</b> Сэтгэл зүйн зөвлөгөө үзүүлдэг. Эрсдэлийн түвшин үнэлнэ. Уулзалтын хугацаа 45-60 минут, 3-7 удаагийн уулзалт хийдэг.</p> <p><b>Санхүүжилт:</b> Төв байгууллагаасаа санхүүжилт авдаг. Дэлхийн 30 гаруй улс оронд салбартай. Оюу-Толгой ХХК санхүүжилтээр зарим үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг.</p> <p><b>Хүний нөөц:</b> Сэтгэл зүйч, нийгмийн ажилтантай.</p>

Дээрх хүснэгтээс харахад үйлчилгээ үзүүлэгч төрийн бус байгууллагын хувьд бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэргийн хохирогч/даван туулагчдад таваас дээш жил нийгмийн ажил үйлчилгээ, сэтгэцийн гэмтэлд суурилсан, хохирогч төвтэй арга зүйгээр үйлчилгээ үзүүлж байна. Судалгааны үндсэн зорилго болох сэтгэцийн гэмтэлд суурилсан, хохирогч төвтэй арга зүйг Хөөрхөн зүрх ТББ нь төрийн болон төрийн бус байгууллагын мэргэжлийн бүлэгт таниулах нэгдсэн ойлголт өгөх сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг явуулдаг байна.

Шигтгээ 29. Дасан зохицох эмгэг

Удаан хугацаанд бэлгийн хүчирхийлэлд өртсөөр байгаад дасан зохицох эмгэгтэй гэх оноштой хохирогчийг Хөөрхөн зүрх ТББ хандуулан удаан хугацааны үйлчилгээ үзүүлсэн. Холбогдогч нь хоригдчихсон учраас хүүхдийг ар гэртэй нь нэгтгээд, МСҮТ рүү холбон зуучлаад сургуульд сурч байгаа. Хөнгөн зэргийн оноштой хүүхдүүдтэй ажиллаж байдаг.

*Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын төлөөлөлтэй хийсэн ярилцлагын хэсгээс...*

Үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын (n=5) хувьд хохирогчдод үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай санхүүгийн дэмжлэг туслалцаа дийлэнх тохиолдолд олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр үзүүлдэг байна.

Төрийн байгууллагаас хохирогчид үзүүлсэн үйлчилгээнд санхүүжилт авдаг хэдий ч зайлшгүй хангасан байх шаардлагууд байна. Тухайлбал, Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх бол заавал төрийн байгууллагын магадлан итгэмжлэлд хамрагдсан байх, мөн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14-16-р зүйл тусгагдсан тендерт оролцогчийн шаардлагыг хангасан байхыг шаарддаг. Энэ үйлчилгээ үзүүлэгч байгууллагад хүндрэлтэй бөгөөд үйлчилгээнд зарцуулсан зардлыг гүйцэтгэлээр хэдэн сарын дараа олгодог, заавал баримтаар нотлогдох зардлыг тооцдог, зөвлөгчдийн цалин, урамшууллыг олгодоггүй талаар судалгаанд оролцогчид илэрхийлж байлаа.



### Шигтгээ 30. Хохирогч/даван туулагчдын авсан үйлчилгээний сэтгэл ханамжийн байдал

Төрийн бус байгууллага үйлчилгээгээ тайлбарлаж өгдөг байсан. Сэтгэл гутралд орсон байхад зөвлөгөө өгөөд сэтгэл маш сайхан өөдрөг болж байсан. Олон төрлийн сургалт, дугуйланд явахыг санал болгож байсан. Харилцаа, хандлага сайн байдаг.

*Үйлчилгээ үзүүлэгч ТББ-д хандсан хохирогч/даван туулагчтай хийсэн ярилцлагын хэсгээс...*

Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэгч төрийн болон төрийн бус байгууллагыг үйл ажиллагааны хүрээ, санхүүжилт, хүний нөөц, үйлчилгээ болон арга зүйгээр харьцуулан дор Матриц 9-т харуулав.

Матриц 9. Төрийн болон төрийн бус байгууллагын харьцуулалт

Төрийн байгууллага Гэр бүл хүүхэд залуучуудын газар			Төрийн бус байгууллага Үйлчилгээ үзүүлэгч таван байгууллага					
Үйл ажиллагааны хүрээ	Санхүүжилт	Хүний нөөц	Үйлчилгээ	Үйл ажиллагааны хүрээ	Санхүүжилт	Хүний нөөц	Үйлчилгээ	Арга зүй
Үндэсний хэмжээнд ажилладаг	Улсын төсөв (8 тэрбум) ОУБ хандив тусламж	Агентлагт 50 орчим, аймаг нийслэлд 15-30 хүний бүрэлдэхүүнтэй	Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан үйлчилгээ бүхэл нь үзүүлдэг.	Улаанбаатар хот, сонгогдсон орон нутагт	ОУБ, хандив, тусламж, зарим тохиолдол зөвлөх тендерээс төрөөс санхүүжилт авдаг	Үйлчилгээнд суурилсан байгууллага нь 5+ орчим нийгмийн ажилтан, эрх зүйч, өмгөөлөгч,	Илрүүлэх Сэтгэл зүйн зөвлөгөө, засал, хууль зүйн туслалцаа, Өмгөөлөл, хамгаалах байрны үйлчилгээ	Хохирогч төвтэй, сэтгэцийн суурилсан арга зүйг анх удаа Монгол Улсад нэвтрүүлэн ажиллаж байна.
<ul style="list-style-type: none"> <li>• Үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг. Аймаг бүрд салбар нэгжтэй. Өөрийн гэсэн байртай.</li> <li>• Тогтмол санхүүжилттэй.</li> <li>• Хүний нөөц ихтэй мэт харагдавч тогтвор суурьшилтай бус, байнга өөрчлөлт хийгддэг.</li> <li>• Үйлчилгээ хязгаарлагдмал, зарим үйлчилгээг үзүүлдэггүй. Тухайлбал, сэтгэл заслын үйлчилгээ</li> <li>• Урт хугацааны нөхөн сэргээх төв байдаггүй.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулдаггүй ч үндэсний хэмжээнд ажиллаж буй үйлчилгээ үзүүлэгч байгууллагын мэргэжилтнүүдийг арга зүйн хувьд мэдлэг, дадал олгох сургалтыг зохион байгуулдаг.</li> <li>• Тогтмол бус орлоготой. Санхүүжилттгүй.</li> <li>• Мэргэшсэн, чадварлаг хүний нөөцтэй.</li> <li>• Үйлчилгээг тогтмол үзүүлдэг. Хамгаалах байртай</li> <li>• Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэргийн хохирогчтой ажиллах хохирогч төвтэй, сэтгэцийн гэмтэлд суурилсан үйлчилгээг анх удаа эхлүүлсэн.</li> </ul>							

### 2.3.2.3. Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэргийн хохирогч/даван туулагч охидод нэн шаардлагатай туслалцаа дэмжлэг

Энэ хэсэгт бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэргийн хохирогч/даван туулагчдад нэн шаардлагатай үйлчилгээнүүдийг тодрууллаа (Хүснэгт 22).

#### Хүснэгт 22. Хохирогч/даван туулагчдад нэн шаардлагатай үйлчилгээ

Үйлчилгээ	Үйлчилгээний төрөл
Хохирогч/даван туулагчийг хүлээн авах үеэс	Эрүүл мэндийн үйлчилгээ (жирэмсэн)
	Аюулгүй байдлыг хангах
	Зун, намар, өвөл, хаврын улирал тохирсон хувцас, ахуйн хэрэглэл
	Ариун цэврийн хэрэглэл
	Сэтгэл зүйн зөвлөгөө
	Хууль зүйн зөвлөгөө, туслалцаа
Нөхөн сэргээх үйлчилгээ	Тусдаа байранд хохирогч/даван туулагч охидыг байрлуулах байрыг бий болгох
	Урт хугацааны сэтгэл заслын үйлчилгээ
	Өмгөөллийн үйлчилгээ
	Гэр бүлийн дэмжлэг
	Найз нөхөд, хамт олон, багш нарын дэмжлэг
	Хохирогч/даван туулагч охидыг өөрийгөө хамгаалах, амьдралд итгэх итгэлийн нэмэгдүүлэх, чадавхжуулах
	Мэргэжил сонголтод дэмжлэг үзүүлэх
	Дэмжих бүлэг

Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн хохирогчдын хувьд анхан шатны тусламж болох ариун цэврийн хэрэглэл, дотуур хувцас, эрүүл мэндийн үзлэг оношилгоо зэрэг нь нэн тэргүүнд хэрэгцээтэй бөгөөд үйлчилгээ үзүүлэгч төрийн болон төрийн бус байгууллагуудад тогтмол байлгаж байх яаралтай үйлчилгээний багц хэлбэрээр бэлтгэх, улмаар нөөцтэй байх хэрэгтэй байдаг гэв.

💬
**Шигтгээ 31. Хохирогч/даван туулагчдад үзүүлж буй үйлчилгээ**

Үйлчилгээний хувьд бүхий л төрлийн үйлчилгээ тухайлбал, ариун цэврийн хэрэглэл, хувцас, дотуур хувцас, зургаар баримтжуулалт хийх, эрүүл мэндийн, сэтгэл зүйн, хууль эрх зүйн, нийгмийн ажлын бүх үйлчилгээ хэрэгтэй. Эдгээр үйлчилгээнүүдийн нэгийг орхигдуулж болохгүй.

*Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын төлөөлөлтэй хийсэн ярилцлагын хэсгээс...*

Судалгаанд оролцогчдын зүгээс гаргасан бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэргийн хохирогч/даван туулагчдад үзүүлж буй үйлчилгээг сайжруулах чиглэлээр гаргасан саналыг нэгтгэн Хүснэгт 23-т харуулав.

**Хүснэгт 23.** Чанарын судалгаанд хамрагдсан үйлчилгээ үзүүлэгч төрийн болон төрийн бус байгууллагын мэргэжилтнүүдээс гарсан санал

Санал
Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэргийн хохирогч/даван туулагч охидод зориулсан нөхөн сэргээх төв байгуулах
Охидын хөгжүүлэх төв байгуулах, энэ бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэрэгт өртсөн хохирогч/даван туулагчдыг эргэн нийгмийн амьдралд хөл тавихад нь туслах урт хугацааны нөхөн сэргээх төвийг бий болгох
Шөнийн цагаар ажилладаг өмгөөлөгчтэй байх хэрэгтэй. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын хууль зүйн төлөөлөгчийг 24 цаг ажиллуулдаг болгомоор байна.
Сэтгэл заслын үйлчилгээ хийх мэргэшсэн сэтгэл зүйчтэй болох
Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэргийн хохирогч/даван туулагчдад үзүүлж буй үйлчилгээг үнэ төлбөргүй болгох бодлого, ялангуяа нөхөн сэргээх үйлчилгээ буюу урт хугацааны үйлчилгээний санхүүжилтийг төр хариуцах
Бодлогын баримт бичигт тусгах чиглэлээр
Ерөнхий боловсролын сургуулийн багш нарын бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэргийг илрүүлсэн, гэр бүлд эргэн нэгтгэсэн тохиолдолд нууцлал чандлан хадгалах үүргийг багшийн үүрэгт тусгах
Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэргийн хохирогч/даван туулагч хамгийн түрүүнд цагдаагийн байгууллагад дээр ирдэг. тусдаа мэдүүлэг авах өрөөнөөс гадна, тайвшруулах өрөөг байгуулах
Хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр
Төрийн байгууллага, төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаагаа уялдуулах, хамтын ажиллагааг сайжруулах. Төрийн бус байгууллагууд хохирогч/даван туулагч хүүхдийг холбон зуучлах гэхээр бид тийм хүүхэд авахгүй, гээд шалгуур гаргаад байдаг.
Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэргийн хохирогч/даван туулагчийг мэргэжлийн сэтгэл заслын төв, албан бус сургалт, хуулийн байгууллагад хандуулах зэрэг үйлчилгээнд холбон зуучлах үйлчилгээ сайжруулах
Урьдчилсан сэргийлэх ажлын чиглэлээр
Урьдчилан сэргийлэх, илрүүлэх нөлөөллийн ажлуудыг сайжруулах.
Бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх ажлыг системтэйгээр, нэгдсэн аргачлалаар хүүхдийн нас, сэтгэхүй онцлогт тохирсон байдлаар зохион байгуулах. Бага насны хүүхдүүдэд зориулсан миний биед хүрч болохгүй гэсэн агуулгатай сурталчилгаа хийх.
Цахим орчин хяналттай болгох. Интернэтийн орчноос хүссэн мэдээллийг авахын зэрэгцээ буруу мэдээллийн суваг руу насанд хүрээгүй хүн хохирогч эсвэл бусдад уруу татагдан гэмт хэрэг үйлдэх эрсдэлтэй нөхцөл үүсдэг.
Хууль тогтоомжийг сурталчилгааг тогтмол зохион байгуулах. Ингэхдээ насны онцлогт нь тохирсон байдлаар сурталчлан, таниулах
Боловсрол олгох чиглэлээр
Эрүүл мэндийн хичээлийн мэргэжлийн хүн заах, нөхөн үржихүйн хичээлийн агуулгыг сайжруулах. Онцгойлон өөрийгөө яаж хамгаалах талаар мэдлэг мэдээлэлтэй болгох, охидыг бэлгийн боловсролтой болгох,
Багш нарын хариуцлагыг нэмэгдүүлэх, тэднийг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэргийг илрүүлэх, таних чиглэлээр сургах
Эцэг, эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, тэдэн рүү чиглэсэн сургалт зохион байгуулах.
Хүний нөөцийг сургах чиглэлээр
Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын мэргэжилтнүүд тогтмол сургалтад хамрагдаж, мэдлэг мэдээллээ дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах
Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн хохирогчийг таньж мэдэх, илрүүлэх чиглэлээр эрүүл мэндийн салбарынхан мэргэжилтнүүдэд сургалтыг зохион байгуулах
Хэвлэл мэдээллийн салбарын сэтгүүлч нарыг хохирогч төвтэй хандлагаар мэдээ, мэдээлэл бэлтгэх чиглэлээр сургалтад хамруулах.

Дээрхээс дүгнэхэд үйлчилгээ үзүүлэгч төрийн болон төрийн бус байгууллагуудын хувьд хоёул хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлдэг.

Үйлчилгээ үзүүлэгч төрийн байгууллагын хувьд Хүүхэд хамгааллын тухай хуульд заагдсан хариу үйлчилгээ үзүүлж байгаа бол төрийн бус байгууллагын (n=2) хувьд сэтгэцийн гэмтэлд суурилсан, хохирогч төвтэй арга зүйг ашиглан үйлчилгээ үзүүлдэг давуу талтай байна. Төрийн байгууллагаас үйлчилгээнд тусгайлсан хүүхэд хамгааллын төсөв батлуулдаг ба үүнээс хариу үйлчилгээний зардлыг гаргадаг ба зарим үйлчилгээг төлбөрийн хамтад нь үйлчилгээ үзүүлэгч төрийн бус байгууллага руу холбон зуучлах үйлчилгээг шилжүүлдэг байна.

Судалгаанд оролцогчдын хувьд бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэргийн хохирогч/даван туулагчдад үзүүлж буй үйлчилгээг сайжруулах чиглэлээр нэн тэргүүнд хохирогчдод зориулсан нөхөн сэргээх төвийг бий болгох, хохирогч төвтэй үйлчилгээг хөгжүүлэх, сэтгэл зүйн зөвлөгөө, заслын үйлчилгээг бүхий л шатад үзүүлдэг байх, энэ төрлийн гэмт хэргийн хохирогч/даван туулагч нартай ажиллах арга зүйд суралцах зайлшгүй хэрэгцээ гэжээ.

Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг цогц, бүрэн дүүрэн, чанартай байдлаар үзүүлэх боломжгүй байна. Чанарын судалгаанд хамрагдсан үйлчилгээ үзүүлэгч төрийн байгууллагын 18, хамтарсан багийн 10, төрийн бус байгууллагын 5 төлөөлөгч нараас хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, ялангуяа бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэрэгт өртсөн хохирогч/даван туулагчдад үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар тодруулахад ихэнх оролцогчид Хүүхэд хамгааллын тухай хуулийн хүрээнд үйлчилгээ үзүүлдэг хэдий ч хохирогч/даван туулагчдад цогц үйлчилгээ үзүүлж чадахгүй байгаа талаар дурдсан. Тухайлбал:

1. Хүүхэд хамгаалал, хариу үйлчилгээ үзүүлэх нийгмийн ажил үйлчилгээг тодорхой болгох, үйлчилгээний стандартыг бий болгох хэрэгцээтэй байна. Үйлчлүүлэгч/хохирогчид үйлчилгээг хүргэхдээ орон нутаг, нийслэлд үзүүлж буй үйлчилгээ өөр өөр байхгүй байх;
2. Кейс бүртэй ажиллахад санхүүжилт шаардлагатай;
3. Холбон зуучлах үйлчилгээг сайжруулах, эргэх холбоог бий болгох, кейс шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг солилцдог байх;
4. Үйлчилгээг чанаржуулах шаардлагатай. Хэдийгээр хохирогчид хуульд тусгагдсан үйлчилгээг үзүүлж байгаа хэдий ч тогтмол санхүүжилтгүй улмаас үйлчилгээний чанар муу байдаг. Тухайлан бэлгийн хүчирхийлэл, ураг төрлийн бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үйлчилгээ үзүүлэхэд эрүүл мэндийн үйлчилгээ, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлдэггүй, наад захын хэрэгцээг хангахуйц хувцас, дотуур хувцас зэрэг нь үйлчилгээ үзүүлэгч байгууллагад бэлэн биш байдаг.
5. Зарим тохиолдол үйлчилгээ үзүүлэгч төрийн бус байгууллага үйлчилгээний хязгаартай гээд хүүхэд авахгүй байх тохиолдол байдаг.
6. Шөнийн цагаар хохирогч ирэхэд сэтгэл зүйч, хуульч, өмгөөлөгч байдаггүй.
7. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогч хүүхдээс цагдаагийн ажилтан мэдүүлэг авахдаа ижил хүйсийн байцаагч байх хэрэгтэй байдаг. Цагдаагийн байцаалт авах өрөө хохирогчоос ярилцлага авахад тохиромжгүй байдаг. Олон хүний дэргэд байцаалт авдаг гэх мэт хүндрэл бэрхшээлүүд өнөөдрийн байдлаар үйлчилгээний чанар, хүртээмжид сөрөг нөлөөтэй байна гэв.

Түүнчлэн чанарын ярилцлагад оролцогчид бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэргийн хамгийн ихээр үйлдэгдэж буй хэлбэр нь ураг төрлийн бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэг<sup>46</sup> давамгайлж байна гэв. Үйлчилгээ үзүүлэгч төрийн байгууллагын хувьд бэлгийн хүчирхийлэл, ураг төрлийн бэлгийн хүчирхийлэл өртсөн хохирогчтой ажиллахад арга зүйн дэмжлэг,

46 Гэр бүлийн хүрээнд буюу төрсөн эцэг, ах, өвөө, хойд эцэг, авга, нагац гэх мэт төрөл садны хүмүүсийн зүгээс үйлдэж буй бэлгийн хүчирхийлэл

санхүүгийн туслалцаа маш их хэрэгцээтэй байхын зэрэгцээ хохирогч хүүхэдтэй ажиллах мэргэжлийн нийгмийн ажилтан дутмаг байдаг талаарх голлох мэргэжлийн бүлгийнхэн дүгнэж байсан.

## 2.4 Сурагчдын аюулгүй байдалд үзүүлэх КОВИД-19 цар тахлын нөлөө

2019 онд цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн нийт зөрчлийн 0.4% буюу 8,962 тохиолдол нь гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой байсан байна<sup>47</sup>. Харин 2020 оны эхний улирлын байдлаар 2019 оны мөн үетэй харьцуулахад гэр бүлийн хүчирхийлэл 46.9%-аар өссөн байна<sup>48</sup>. Харин КОВИД-19 цар тахал эхэлснээс хойш дэлхий нийтээрээ хүмүүс ихэнх хугацааг гэртээ хөл хорионд өнгөрүүлж буйтай холбогдуулан дэлхий дахинд өсвөр насны 7 хүүхэд тутмын 1 нь ганцаардал, сэтгэл зүйн түгшүүр, дарамт мэдэрсэн гэх судалгааг НҮБ-ын Хүүхдийн Сангаас мэдээлсэн байна<sup>49</sup>.

Тиймээс уг дэд бүлгээр суурь судалгаанд оролцогчид КОВИД-19 цар тахлын гэр бүл, сургууль, олон нийтийн түвшинд охид өөрийн аюулгүй байдалд эрсдэл үүссэн гэж тодорхойлсон эсэхийг хэрэв тодорхойлсон ямар төрлийн аюул тулгарсан гэж хариулсан болохыг дэлгэрүүлэн харуулав.


**Шалгуур үзүүлэлт:**

Төслийн зорилтын шалгуур үзүүлэлт: КОВИД-19 цар тахал нь гэр бүл, сургууль, олон нийтийн түвшинд өөрийн аюулгүй байдалд эрсдэл үүсгэсэн гэж нийт оролцогч охидын 19.1 хувь нь тодорхойлсон байна.

Таван охин тутмын нэгд нь КОВИД-19 цар тахлаас хойш аюулгүй байдалд нь эрсдэл үүсжээ. Суурь судалгаанд оролцсон нийт 664 сурагч охидын 537 нь буюу 80.9% нь КОВИД-19 цар тахал гарснаас хойш гэр бүлийн уур амьсгал нь өөрчлөгдөөгүй эсвэл гэр бүлийнхэнтэйгээ хамт цагийг сайхан өнгөрүүлдэг болсон гэх хариултыг өгсөн байна. Харин үлдсэн 127 (19.1%) сурагч охид өөрийн гэр бүлийн уур амьсгалыг маш түгшүүртэй хэцүү болсон эсвэл гэр бүлийн орлого муудаж улмаар уцаартай, бухимдалтай таагүй уур амьсгалтай болсон гэж тодорхойлсон байна.

амьсгалыг маш түгшүүртэй хэцүү болсон эсвэл гэр бүлийн орлого муудаж улмаар уцаартай, бухимдалтай таагүй уур амьсгалтай болсон гэж тодорхойлсон байна.

### Дүрс 20. КОВИД-19 цар тахлын дараах гэр бүлийн уур амьсгал



Өгөгдлийн эх сурвалж: Охидоос авсан нэр нуусан асуумж

Өөрийн гэр бүлийн уур амьсгалыг тогтворгүй, бухимдалтай болсон гэж тодорхойлсон охидоос (n=127) КОВИД-19 цар тахлаас өмнө гэр бүлд нь тодорхой эрсдэлүүд байсан эсэхийг асуухад

47 Монгол Улс дахь Хүүхдийн эрхийн нөхцөл байдлын үнэлгээ, ХИС, 2020

48 Нэг цэгийн үйлчилгээний төв, хамгаалах байрны ажилтнууд, хамтарсан багийн зүгээс COVID-19 цар тахлын үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны удирдамж, 2020

49 <https://www.unicef.org/press-releases/least-1-7-children-and-young-people-has-lived-under-stay-home-policies-most-last>

давхардсан тоогоор охидын 29.3% нь урд нь ямар нэгэн эрсдэл байсан гэж хариулсан байна. Эдгээр эрсдэлээс дурдвал гэр бүлийн гишүүдээс ирэх уур бухимдал, сэтгэлзүйн дарамт (11%), сурах орчин боломжоор хангагдахгүй байх (6.6%) эрсдэлүүд тус тус өндөр хувьтай байна (Дүрс 21).

**Дүрс 21.** КОВИД-19 цар тахлын өмнө болон үед гэр бүлд тулгарсан бэрхшээлүүдийн төрөл, хувиар



Эх сурвалж: Охидоос авсан нэр нууцалсан асуумж

Судалгаанд оролцсон нийт сурагч охидын 8.5% нь КОВИД-19 цар тахлын үед Дүрс 22-д дурдсан эрсдэлүүдийг нэмэгдсэн гэж хариулсан байна. Харин дээрх эрсдэлүүд нь хивэндээ байсан эсвэл буурсан гэж хариулсан охидын хувь 39.4% байна. Оролцогч охидын дийлэнх нь буюу 52.4% нь КОВИД-19 цар тахал гарснаас хойш гэр бүлд нь ямар нэгэн эрсдэл үүсээгүй гэж хариулсан байна.

Дүрс 22-д эрсдэл тус бүрээр үнэлсэн охидын үнэлгээг дэлгэрүүлэн харуулав. Уг үнэлгээнээс харахад охидод түлхүү “гэр бүлийн гишүүдээс ирэх уур бухимдал, сэтгэл зүйн дарамт” (19.7%) болон “сурах орчин, боломжоор хангагдахгүй байх” (16.3%) эрсдэлүүдтэй тулгарсан байна.

**Дүрс 22.** КОВИД-19 цар тахлын үед үүдэж, гэр бүлийн орчиндох эрсдэлүүдэд гарсан өөрчлөлтүүд, хувиар



Эх сурвалж: Охидоос авсан нэр нууцалсан асуумж



Зорилтот 15 сургуулийн нийгмийн ажилтан, захирал, сэтгэл зүйчидтэй хийсэн ярилцлагаас (n=18) дүгнэхэд охидын аюулгүй байдалд КОВИД-19 цар тахал харилцан адилгүй нөлөөлсөн байна. Нийт оролцогчдын 14 нь буюу 77.8% нь тухайн хүүхдийн гэр бүлийн орчин нөхцөлөөс шалтгаалж хүүхэд айх аюулгүй байх эсэх нь тодорхойлогдоно гэж хариулсан байна. Тухайлбал, архины хамааралтай гэр бүлд байдаг эсвэл өөрийн хууль ёсны асран хамгаалагчтайгаа байдаггүй охид түлхүү гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртөх эрсдэл нь өндөр байсан бол илүү тайван амгалан гэр бүлд байдаг охид гэр бүлтэйгээ цаг хугацаагаа өнгөрөөх боломжтой болсондоо баяртай байх тохиолдлууд ч мөн байсан гэдгийг оролцогчид (3%) онцлов. Дийлэнх оролцогчдын үзэж буйгаар зөвхөн бэлгийн хүчирхийлэл гэхээс илүүтэй сэтгэл зүйн болон бие махбодын хүчирхийлэл КОВИД-19 цар тахлын үед нэмэгдсэн гэв.



### Шигтгээ 32. Гэр бүлийн хүчирхийлэл

Гэр бүл хамгийн аюулгүй байх орчин боловч нийт суралцагчдын 10 орчим хувьд гэр бүл аюулгүй орчин байж чадаагүй. Яг бэлгийн хүчирхийлэлд өртөөгүй боловч өөр бусад хүчирхийлэлд өртсөн талаарх мэдээллүүд ирсэн. Хамтарсан баг ажиллаж байгаа. Жишээ нь: бие махбодын хүчирхийлэл болон хараа хяналтгүй байх буюу үл хайхрах хүчирхийлэлд өртөх гэх мэт асуудлууд сүүлийн 2 жилд нэмэгдсэн. 30-40 насны эмэгтэйчүүд их сэтгэлийн тэнхээгүй болсон. Хүний амьдралд маш олон зүйл тохиолдоно. Эцэг эхээ алдах, эр нөхрөө алдах гэх мэт. Ийм зүйлсийн дараагаар үр хүүхдээ хайрлахгүй архинд орох тохиолдол гарч байна. Ийм хоёр ч тохиолдол гарсан. Гэр бүлийн орчныг 2 оноогоор өгнө. Гэр бүл болгон харилцан адилгүй байдаг.

*Сургуулийн төлөөлөлтэй хийсэн ярилцлагын хэсгээс.,*

Харин үйлчилгээ үзүүлэгч төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөлөлтэй хийсэн ярилцлагаар (n=35) гэр бүлийн хүчирхийлэл КОВИД-19 цар тахлын үед эрс нэмэгдсэн гэж гарав. Бүх нийтийн хөл хорионы үед охидын хүчирхийлэлд өртөж байгаа үйл явц нь нууцлагдмал байдаг боловч хөл хорио тавигдах үед үйлчилгээ үзүүлэгч байгууллага руу хандах тохиолдол ихэсдэг байна. Түүнчлэн зөвхөн гэр бүлийн хүчирхийллээс гадна гэр бүлийн гишүүдийн эсвэл ураг төрлөөс үзүүлэх бэлгийн хүчирхийллийн тохиолдол ихэссэн байна.



### Шигтгээ 33. Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл

Манайд гэвэл хойд аавтайгаа гэртээ үлдээд КОВИД-19 цар тахлаас болоод ээж нь хилийн цаана хоригдчихсон. Тэр үедээ охин бэлгийн хүчирхийлэлд өртсөн ийм тохиолдол дээр хойд аавтайгаа үлддэг, ээж ааваасаа гадуур нагац ах, авга ах, өвөөтэйгөө үлдээд хөл хорионд ороод энэ хугацаандаа бэлгийн хүчирхийлэлд өртсөн тохиолдол байгаа. Ажил дээр гарснаас хойш бол нэмэгдсэн.

*Үйлчилгээ үзүүлэгч төрийн байгууллагын төлөөлөлтэй хийсэн ярилцлагын хэсгээс..*

Аль алинд нь л нөлөөлсөн, хүүхдийн тоо нь ч өссөн. Яаж мэдээлэгдэж байгаа арга зам нь өөрчлөгдсөн. Одоо хөл хорионоос шалтгаалаад хүүхдүүд сургуульд хамрагдах боломжгүй, гэртээ байсан. Үүнээс үүдэн хүчирхийлэл үйлдэгчтэйгээ хамт удаан байх, Ураг төрлийн бэлгийн хүчирхийлэл буюу төрсөн эцэг, хойд эцэг, ах гэх мэт хүмүүсийн зүгээс үйлдэгдэх бэлгийн хүчирхийлэл өссөн. Тэгээд яаж мэдэгдэж байгаа вэ гэхээр, хүүхдүүд ихэнх тохиолдолд жирэмсэн болсноороо мэдэгдэж байгаа. Хөл хориотой байсан учраас гараад хэн нэгэнд, багштайгаа яриад ч юм уу, найзтайгаа уулзаад хэлэх боломжгүй, мэргэжлийн хүнд хандах боломж байгаагүй учраас жирэмсэн болтлоо нуух гэх мэт байдлууд илэрч байсан. 2019 онд бол 30 байсан, тэгээд 2020 онд бол 33, 2021 оны 12 сарын байдлаар 40 гаруй үйлчлүүлэгчдэд үйлчилгээ үзүүлсэн. Тоо нь тодорхой хэмжээгээр нэмэгдэж байгаа, тэр дундаа ураг төрлийн бэлгийн хүчирхийлэл ихээр нэмэгдсэн байгаа. Өмнө нь бол болзооны үеийн

бэлгийн хүчирхийлэл, цахимаар танилцаад, ураг төрөл гээд хосолсон байдаг бол одоо энэ 2021 оны бэлгийн хүчирхийллийн 40 гаруй тохиолдлын 80 гаруй хувь нь ураг төрлийн бэлгийн хүчирхийлэл эзэлж байгаа.

*Үйлчилгээ үзүүлэгч төрийн бус байгууллагын төлөөлөлтэй хийсэн ярилцлагын хэсгээс...*

Судалгааны үр дүнгүүдээс харахад КОВИД-19 цар тахлаас үүдэн гэр бүлийн гишүүдийн орлого багасах, хүмүүс гэртээ ихээхэн цаг өнгөрүүлдэг болсноос хойш гэр бүлийн хүчирхийлэл тодорхой хэмжээнд нэмэгдсэн байгаа боловч хөл хорионы үед аливаа хүчирхийлэл нь нууцлагдмал байдал руу шилжих асуудал үүсэж байна.

КОВИД-19 цар тахал гарснаас нэмэгдсэн аюул, эрсдэл, орчноос хамааран өөр өөр байна. Судалгаанд хамрагдсан сурагч охидоос КОВИД-19 цар тахал гарснаар сургууль, амьдарч буй орчин болон интернэт цахим орчинд аюул эрсдэл үүссэн эсэхийг асуухад давтагдсан тоогоор охидын 204 (30.6%) нь сургуулийн орчинд, 135 (20.3%) нь амьдарч буй орчинд, болон 85 (12.7%) нь цахим орчинд эрсдэл нэмэгдсэн гэж хариулсан байна (Дүрс 23).

**Дүрс 23.** Сургууль, амьдарч буй орчин болон цахим орчинд аюул, эрсдэл үүссэн эсэх, хувиар



### Шигтгээ 34. Сургуулийн орчны аюулгүй байдал

Зарим үед айж эмээх зүйл байдаг. Танхим, цахимаар сургалт явж байхад хүүхэд эцэг эх болгоомжтой байсан. КОВИД-19 цар тахлын 2 жилийн хугацаанд танхимд авчраагүй учраас тэр үед сургууль дээрх нийгмийн харилцаа байхгүй байсан. Намар 2 жил сургуульдаа ирээгүй хүүхдүүд бага хэмжээний айдас, түгшүүрийн асуудал байсан. Ангийнхнаасаа хоцорсон, үерхэл нөхөрлөлийн харилцааны асуудал үнэхээр хаалттай байсан. Ирээд найз нөхөдтэйгөө ойлголцож чадах уу чадахгүй юу, олуулаа хичээлд суухаар КОВИД тусна гэсэн айдас маш их байсан. Энэ айдас түгшүүрийг буулгахын тулд багш нар сайн мүү гэж хэлэхгүй зэрэг арга хэмжээ аваад явж байгаа. Цахимаар өсвөр насны хүүхдүүдийн хоорондын зодоон гээд явсан. Энэ асуудал бүх сургууль дээр байгаа. Үе тэнгийнхний хоорондын зөрчил маш их байсан. Тэр дээр бид нар маш их ажилласан. Цахимын харилцаанаас амьд харилцаа руу ороод ирэхээр хүүхдүүдэд өөрийн эрхгүй зөрчил үүссэн.

*Сургуулийн ажилтнуудтай хийсэн ярилцлагын хэсгээс...*

*Эх сурвалж: Охидоос авсан нэр нууцалсан асуумж*

Сургуулийн орчинд эрсдэл үүссэн гэж хариулсан охидын 71.6% нь халдвар авах буюу өвчин тусах эрсдэл ихэссэн гэж хариулсан бол 9.5% нь сургууль дээрх дээрлэл нэмэгдэж,

хүүхдүүдийн зан авир тогтворгүй болсон талаар хэлсэн байна. Мөн үлдсэн охид (19.9%) нь хичээлийн хоцрогдол бий болсон, найзуудаасаа холдсон гэх мэт хариултуудыг өгсөн.

Судалгаанд хамрагдсан 18 сургуулийн ажилтнуудын 13 нь КОВИД-19 цар тахлын үед сургууль аюулгүй орчин гэж үзсэн бол 5 оролцогч сургуулийн орчныг зарим талаар аюултай орчин гэж үнэлсэн байна. Учир нь КОВИД-19 цар тахлаас үүдэн сурагчдын дунд хичээлийн хоцрогдол бий болох, нөхөрлөл, харилцааны доголдол үүсэх, цаашлаад энэ нь дээрэлхэхийн суурь болох магадлалтай байгааг дурдаад энэ тал дээр хариу арга хэмжээ авахын тулд сурагчдын эцэг эхийн оролцоо зайлшгүй шаардлагатайг тодотгосон байна.

Эдгээр хариултуудаас харахад сургуулийн сурагчид болон ажилтнуудын хариултууд ерөнхийдөө төстэй байгаа тул КОВИД-19 цар тахлын үед сурагчид өвдөх, сэтгэл санаа тогтворгүй болох цаашлаад сургуулийн орчинд дээрэлхүүлэх гэх мэт орж байгаа нь батлагдаж байна.

Харин амьдарч буй орчинд үүссэн эрсдэлүүдийг оролцогчид тодорхойлохдоо нийт оролцогчдын 60% нь халдвар авах буюу өвчин тусах гэж хариулсан байсан бол 15.5% нь гадуур явж чадахгүй, гэртээ хоригдсоноос шалтгаалж бухимдалтай байсан гэж хариулсан байна. Харин оролцогчдын 11.9% нь архидан согтуурал ихэссэн ба гэр бүлийн гишүүд уур бухимдалтай болж аливаа төрлийн дарамт шахалт үзүүлдэг болсон гэжээ. Үүнээс хоёр оролцогч бэлгийн хүчирхийлэлд өртсөн байна.

Судалгаанд оролцсон сургуулийн ажилтнууд сурагч охидын амьдарч буй орчинд архидан согтуурах явдал нэмэгдэх, гэрэлтүүлэг муу байх, эзэнгүй нохой, муур их байх гэх мэт шалтгаанаас болоод зарим талаар аюултай гэж үнэлсэн.



### Шигтгээ 35. Амьдарч буй орчны аюулгүй байдал

Амьдрах орчны хувьд харилцан адилгүй тул 3 оноогоор үнэлнэ. Хотын төвд амьдардаг хүүхдүүд харьцангуй аюул багатай, эцэг эх нь хараа хяналт сайн тавьдаг. Жишээ нь: 10 хүртэлх насны хүүхдийг ганцаарыг нь замын хөдөлгөөнд оролцуулахгүй гэж байнга хүргэж өгдөг, хардаг хүнтэй хүмүүс байна. Гэтэл өөрөө 10 настай хэр нь насанд хүрсэн хүний үүрэг гүйцэтгээд 3,4 настай 2 дүүгээ хардаг, хашаанд амьдардаг хүүхдүүдийн хувьд гэр лүү нь хэн ч яваад орох эрсдэлтэй байгаа. Харанхуй гудамж, согтуу хөлчүү хүмүүстэй орчин хүртэл байгаа учраас хаашаа ч харсан хүүхэд аюулгүй байх орчин манайд хангалттай бус буюу бүрдэж чадаагүй байгаа.

*Сургуулийн ажилтнуудтай хийсэн ярилцлагын хэсгээс...*

Цахим орчинд эрсдэл үүссэн гэж хариулсан охидын 58.3% нь цахим орчноор дамжуулан хувийн чатаар танилцах утга агуулга бүхий эсвэл хүчирхийллийн өнгө аястай мессеж хүлээж авсан байна. Дийлэнх тохиолдолд ийм мессеж илгээдэг хүмүүс нь танихгүй хүн эсвэл хуурамч хаягаас байсан байна. Үүнээс гадна охидын 19.4% нь цахим сүлжээнээс маш их сөрөг мэдээлэл авч буйтай холбоотойгоор айдастай болох, сэтгэл зүйнд сөргөөр нөлөөлсөн гэж хариулсан байна. Мөн цахим сүлжээгээр дамжуулж залилуулах, цахим сүлжээнд донтох, ашиглах цаг нь ихсэн тохиолдлууд гарч байна гэдгийг охид тодотгон хэлж байсан юм.

Сургуулийн ажилтнууд ч мөн сурагч охидын хэлсэн асуудлуудтай санал ижил байсан ба цахим орчим нь шүүлтүүргүй мэдээлэл ихтэй, КОВИД-19 цар тахлаас шалтгаалж хүүхдүүдийн хэрэглээ нэмэгдэж улмаар донтолт, сэтгэл зүйн нөлөөллүүдийг бий болгодог гэж үзсэн байна. Түүнчлэн сургуулийн ажилтнуудын үзэж буйгаар эцэг эхчүүд өөрсдөө хүүхдүүдээ буруу үлгэр

дуурайлал үзүүлдэг, хараа хяналт бүрэн тавьдаггүйгээс шалтгаалж цахим орчны хэрэглээ нэмэгдэн, үүгээр дамжуулж хүчирхийлэл үүсэх эрсдэл гардаг гэв.



### Шигтгээ 36. Цахим орчны аюулгүй байдал


Сургууль бүр цахим орчин буюу гар утасны зохистой хэрэглээг нэвтрүүлэх хэрэгтэй. Гэтэл эцэг эхчүүдийн хувьд хүүхдэдээ хараа хяналт тавьдаггүй, хүүхдээ саатуулахын тулд утас авч өгөөд, хүүхдээ ямар сүлжээнд яаж хандаж байгаа талаар хяналт тавьдаггүй. Харин зарим эцэг эхчүүдийн хувьд хүүхдээсээ Фейсбүүк кодыг нь аваад элдэв янзын группэд нэгдсэн байна уу гэх мэтээр хандалтыг нь харж, хараа хяналт тавьдаг. Энэ мэтээр хүмүүс харилцан адилгүй байна. Мөн тухайн хүүхдийн буюу хувь хүний цахим орчныг хэрэглэх хэрэглээ, соёл, хандлага ч нөлөөлж байна.

Цахим орчинд цахим гэмт хэрэг хийдэг хүмүүс үйлдэж байгаа. Нас тодорхойлолт тал дээр мэдээлэл байхгүй. Нийтлэг шинж нь өсвөр насны хүүхдийг гаж сэдэл болох хүүхдээр мөнгө олох, бэлгийн мөлжлөгт оруулах, хувийн дур хүслээр ашиглах дадал суусан хүмүүс байж болзошгүй.

*Сургуулийн ажилтнуудтай хийсэн ярилцлагын хэсгээс...*

Суурь судалгаанд оролцогч охидоос КОВИД-19 цар тахлын үед хамгийн их тухайн охины аюулгүй байдалд эрсдэл учруулсан орчныг нь асуухад нийт охидын 18.8% нь амьдран суугаа газар, гудамж талбайг сонгосон бол 17.6% нь сургуулийн орчноо тодорхойлсон байна. Харин нийт охидын 38.6% нь ямар ч орчинд эрсдэл нэмэгдээгүй гэдэг хариултуудыг өгөв.

**Дүрс 24.** КОВИД-19 цар тахлын улмаас хамгийн ихээр эрсдэл нэмэгдсэн орчин, хувиар



*Эх сурвалж: Охидоос авсан нэр нууцалсан асуумж*

Тус хариултуудыг оролцогчдын байршлаар харьцуулан харвал Чингэлтэй дүүрэгт байрлах сурагч охидын хамгийн олон нь буюу 20.8% нь гэр бүлийн орчинд эрсдэл нэмэгдсэн гэсэн бол Сонгинохайрхан дүүрэгт байрлах охидын олонх нь (21.5%) сургуулийн орчныг сонгосон байна. Харин Баянзүрх (14.2%) болон Сүхбаатар (14.1%) дүүргийн сурагч охидын хувьд түлхүү интернэт, цахим орчинд аюул нэмэгдсэн гэж байгаа бол амьдран суугаа газар, гудамж талбайд эрсдэл учирсан гэж хариулсан.

КОВИД-19 цар тахлын үед өөрийн аюулгүй байдалд дээр дурдсан орчнуудад эрсдэл учирсан гэж тодорхойлсон охидын бараг тал хувь нь буюу 47.8% нь хэнд ч хандаагүй гэсэн бол 36.0% нь гэр бүлийн гишүүд, найз нөхөд, дотнын хүмүүсээс тусламж хүссэн гэж хариулсан байна. Харин мэргэжлийн холбогдох байгууллагууд руу хандсан охидын хувь 12.0% байсан ба тэд

багш, нийгмийн ажилтнаас тусламж хүссэн, цагдаагийн байгууллагад дуудлага өгсөн, хүүхэд хамгааллын байгууллагад хандсан эсвэл хүүхдийн тусламжийн 108 утсанд холбогдсон гэж тус тус хариулсан байна (Дүрс 25)

**Дүрс 25.** КОВИД-19 цар тахлын улмаас аюулгүй байдалд эрсдэл үүссэн охидын хандаж тусламж, үйлчилгээ хүссэн хүн эсвэл байгууллага, хувиар



Хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хүн, байгууллагад хандсан гэх хариултыг өгсөн охидын 78.7% нь өөрийн эрхийг хангах хүссэн тусламж, үйлчилгээгээ авч, хамгаалуулж чадсан гэсэн бол үлдсэн 21.3% нь хүссэн тусламж, үйлчилгээгээ авч чадаагүй гэж хариулсан байна. Энэхүү охидын өөрийн авсан үйлчилгээгээ үнэлэхийг хүсэхэд охидын 62.7% нь их бөгөөд маш их сэтгэл хангалуун байна гэж хариулсан бол 31.1% нь дундаж гэх үнэлгээг өгсөн байна. Харин бага болон маш бага сэтгэл ханамжтай гэх хариултыг өгсөн охидын хувь ердөө 6.2% байв (Дүрс 26).

**Дүрс 26.** Үйлчилгээ авсан байгууллагат үзүүлэх сэтгэл ханамжийн үнэлгээ, хувиар



Эх сурвалж: Охидоос авсан нэр нууцалсан асуумж

## НЭГДСЭН ДҮГНЭЛТ

### **Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээтэй холбоотой эрх зүйн орчны хувьд:**

Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэргийн хохирогчдод хариу үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой хууль тогтоомж болох Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль батлагдсан ба эдгээр хууль тогтоомжийг даган 30 гаруй журам гаргаж даган мөрдөж байна.

Монгол Улс нь хүүхдийг эрхийг хангах, хамгаалах чиглэлээр 2016 онд Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай бие даасан хууль тогтоомжийг батлан гаргажээ. Үүгээр хүүхэд хамгаалал, тэдгээрт хариу үйлчилгээ үзүүлэх, үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын салбар дундын зохицуулалт тодорхой тусгагдсанаар томоохон ахиц дэвшил гарсныг илтгэнэ. Үүнээс гадна төрийн байгууллагын зүгээс хохирогч хүүхдэд үйлчилгээ үзүүлэх байгууллагыг заавал магадлан итгэмжлэлд хамруулж үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг олгож буй нь хүүхдэд үзүүлэх үйлчилгээнд хариуцлагатай хандаж буй илэрхийлэл юм. Нийгмийн бүхий л харилцаанд хүүхдийн эрх ашиг хэзээ ч зөрчигдөх ёсгүй.

Хүүхдийн эрх ялангуяа хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн гаралт өсөн нэмэгдэж байгаа ба цагдаагийн байгууллагад бүртгэгдэж байгаа гэмт хэргийн сүүлийн 3 жилийн байдлаар өдөрт нэг хэрэг бүртгэгдэн шалгагдаж байна. Хохирогчдын 80 хувь нь 10-29 насны охид, залуу эмэгтэйчүүд эзэлж байна. Эдгээр хохирогч эмэгтэйчүүд, хүүхдүүд хариу үйлчилгээ авч чадаж байгаа эсэх нь тодорхой бус байлаа. Ер нь цаашид бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэргийн хохирогч хүүхдийг хариу үйлчилгээнд хамруулах, холбон зуучлах үйлчилгээг чанаржуулах, хохирогчийг үйлчилгээний гадна үлдэхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх хэрэгтэй байна.

### **Хүүхэд хамгаалал, хүчирхийлэл, мөлжлөгийн талаар охидын ойлголт, мэдлэгийн тухайд:**

Аливаа эрсдэлт орчинд, аюултай нөхцөл байдалд өөрийгөө болон үе тэнгийн найз, нөхдөө хамгаалах, урьдчилан сэргийлэх арга, хүчирхийлэл, мөлжлөгөөс зайлсхийх талаар охидын ойлголт, мэдлэг, тусламж эрэлхийлэх зан үйлийг судалж, дараах үр дүнд хүрлээ.

### **Хүүхэд хамгааллын талаар ойлголт, мэдлэг:**

Үр дүн 1: Дийлэнх охид өөрийгөө болон үе тэнгийн найз нөхдөө хамгаалах, аливаа эрсдэлээс зайлсхийх шаардлагатайг ухамсарласан байдаг ба энэ байдал нь дунд ангийн охидтой харьцуулахад ахлах ангийн охидод илүү ажиглагдаж байна. Харин байшин хороололд амьдардаг охидтой харьцуулахад гэр хороололд амьдардаг охид хүүхэд бүр бусдаар хамгаалуулах эрхтэйг харьцангуй сул ухамсарласан байна. Хүүхэд бүр хамгаалуулах шаардлагатай гэж нийтийн байранд амьдардаг охид 100% санал нэгдсэн байгаагаас үзэхэд охид нийтийн байранд амьдрахад эрсдэлт, аюултай нөхцөлд орж, бусдаар хамгаалуулах хэрэгцээ, шаардлагатай тулгардаг байж болзошгүйг энд онцолъё. Мөн өөрийн албан ёсны асран хамгаалагчтай амьдардаг охидтой харьцуулахад асран хамгаалагчтайгаа хамт амьдардаггүй охидод бусдаар хамгаалуулах хэрэгцээ, шаардлага тулгардаг байж болзошгүй байна.

Үр дүн 2: Хүүхдийг хэн хамгаалах ёстойг судалгаанд хамрагдсан охидын 11% нь харьцангуй сайн, 38% нь дундаж түвшинд мэдэж байсан бол 51% нь огт мэдэхгүй, эсвэл харьцангуй муу мэдэж байв. Гэр бүл, сургууль, гудамж, талбай, олон нийтийн газар болон интернэт, цахим орчинд аюултай нөхцөл байдлаас өөрийгөө хэрхэн хамгаалах

талаар охидын мэдлэгийг үнэлүүлэхэд тэдний 30.6% нь гудамж, талбай, олон нийтийн газарт, 17.6% нь интернэт, цахим орчинд, 13.3% нь сургуулийн орчинд, 7.1% нь гэр бүлийн орчинд аюултай нөхцөл үүсэхэд өөрийгөө хэрхэн хамгаалах талаар мэдэхгүй, эсвэл муу мэдлэгтэй гэж хариулсан байна. Үүнээс гадна нийт охидын 8.1% нь эрсдэл, аюулаас өөрийгөө хэрхэн хамгаалах, хэрхэн урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл, заавар, зөвлөгөө авч байгаагүй үзэхэд охид, сурагчдад хүүхэд хамгааллын талаар, эрсдэлээс хэрхэн урьдчилан сэргийлэх тухай мэдээлэл, заавар, зөвлөгөө өгөх, сургалт явуулах хэрэгцээтэй байгааг илтгэнэ. Ялангуяа, гудамж, талбай, олон нийтийн газар аюул, эрсдэл тохиолдоход охид өөрийгөө хэрхэн хамгаалах талаар ойлголт, мэдлэг олгоход онцгойлон анхаарах шаардлагатай байна.

Үр дүн 3: Охидын дийлэнх нь аюултай, эрсдэлтэй байдалд орвол өөрийгөө хэрхэн хамгаалах тухай мэдээлэл, заавар, зөвлөгөөг эцэг, эхээсээ болон хүүхэд хамгааллын 108 утаснаас авдаг бол хүүхэд хамгааллын хамтарсан баг, холбогдох хичээл, баг, хорооны нийгмийн ажилтан, брошюр, танилцуулга, нугалбар зэргээс мэдээлэл авдаг охидын тоо харьцангуй цөөн байна. Тиймээс хүүхэд хамгааллын талаар заавар, зөвлөгөө өгдөг мэдээллийн эх сурвалжийн тоог нэмэгдүүлэх шаардлагатай.

Үр дүн 4: Мөн охид хэн нэгнээс тусламж авч, хамгаалуулахдаа тэдний нэр төрд халдахгүй, сэтгэл зүйд сөргөөр нөлөөлөхгүй, нэмж эрсдэлд оруулахгүй, хүүхдийн эрхийг дээдэлсэн, шударга зарчимд тулгуурласан хүүхэд хамгааллын үйлчилгээ хүсэж байгаа нь судалгаагаар тогтоогдсон.

#### **Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн талаар ойлголт, мэдлэг:**

Үр дүн 5: Судалгаанд хамрагдсан охидын 72.3% нь бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн талаар ерөнхий мэдлэгтэй гэж өөрийгөө үнэлсэн байна. Харин тэдний 46.5% бэлгийн хүчирхийллийн талаар, 30.1% нь бэлгийн мөлжлөгийн талаар үнэн, зөв мэдлэгтэй байгаа нь асуулга судалгааны үр дүнгээс тогтоогдлоо. Дунд ангийн охидтой харьцуулахад ахлах ангийн охидын олонх нь бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн талаар мэддэг ба ямар үйлдлийг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт оруулдаг вэ гэдгийг 24, 148, 13, 85, 31, 20 дугаар сургуулийн сурагчдын харьцангуй их хувь нь мэдэж байсан бол бусад сургуулийнх дунджаас доогуур байв.

Үр дүн 6: Охид бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн талаар харьцангуй цөөн эх сурвалжаас мэдээлэл авдаг батэдний дийлэнх олонх нь ТВ, радио, цахим хуудас, нийгмийн сүлжээ: facebook, twitter гэх мэт олон нийтийн мэдээллийн хэрэгслээс эсвэл сургуулийн орчноос мэдээлэл авдаг ажээ. Тиймээс бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн талаар мэдээлэл өгдөг, түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар заавар, зөвлөгөө өгдөг, өртсөн тохиолдолд хаана, хэнд хандаж, тусламж үйлчилгээ авч болох талаар үнэн, зөв мэдээлэл өгдөг эх сурвалжийн тоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Үр дүн 7: Өөрийн албан ёсны асран хамгаалагчтайгаа амьдарч буй охидтой харьцуулахад асран хамгаалагчтайгаа амьдардаггүй охид гэр бүлийн орчинд бэлгийн хүчирхийлэл, мөлжлөг, дарамт шахалтад орох эрсдэл өндөр байна. Харин охид бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртөх эрсдэлтэй тулгарах магадлалд амьдран сууж буй байршил, орчноос хамаарсан статистикийн ач холбогдолтой ялгаа ажиглагдсангүй.

Үр дүн 8: Гурван охин тутмын хоёр нь эрсдэл, аюул тохиолдолд хамгийн түрүүнд эцэг, эх, асран хамгаалагчдаа ханддаг байна. Харин хоёр охины нэг нь хүүхдийн тусламжийн 108 утсанд, мөн хоёр охины нэг нь цагдаад ханддаг аж. Хүүхэд хамгааллын хамтарсан баг, хүүхдийн төлөө ажилладаг ТББ, хүүхэд, гэр бүл хөгжлийн төв, сургуулийн удирдлага, багш, сургуулийн болон баг, хорооны нийгмийн ажилтан, баг, хорооны засаг даргад хандах охидын тоо харьцангуй цөөн байгаа нь тэд эдгээр хүмүүс, байгууллагад хандах боломжтойг мэдэхгүй байгаатай холбоотой. Эрсдэлтэй,

аюултай нөхцөл байдал үүсэхэд хэнд хандахаа ч мэдэхгүй охид (нийт охидын 1.5%) байгааг энд онцолъё.

- Үр дүн 9: Судалгаанд хамрагдсан охидоос ямар орчинд охидын эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөг үйлдэгдэх магадлал өндөр гэж үнэлж байгаа тодруулахад хамгийн өндөр эрсдэлтэй нь интернэт, цахим орчин, дараа нь гудамж, талбай, олон нийтийн газар гэж тэд хариулжээ. Тодруулбал, тэдний 74.0% нь интернэт, цахим орчинд, 68.6% нь гудамж, талбай, олон нийтийн газар илүү эрсдэлтэй гэж үзсэн байна. Иймд эцэг эх, асран хамгаалагчид, сургуулийн удирдлага, багш, нийгмийн ажилтан, хүүхэд хамгааллын байгууллагууд интернэт, цахим орчин, гудамж, талбай, олон нийтийн газарт охидын эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөг үйлдэгдэх эрсдэлийг бууруулах орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарч ажиллах хэрэгтэй байна.
- Үр дүн 10: Судалгаанд хамрагдсан нийт 664 охидын 19.7% нь охид бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн үедээ хэн нэгнээс тусламж авч, хамгаалуулж чаддаг байх гэсэн хүлээлт, таамаглалтай байна. Харин тэдний 58.6% нь охид шаардлагатай тохиолдолд тусламж авч, хамгаалуулж чаддаггүй байх гэсэн ойлголт, хүлээлттэй байгаагаа илэрхийлжээ. Өөрөөр хэлбэл, бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах, охидод тусламж үзүүлэх үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдлыг охид маш хангалтгүй, учир дутагдалтай гэж үнэлсэн байна.
- Үр дүн 11: Мэдээллийн нууцлал алдагдаж, нэр төрд сөргөөр нөлөөлөхөөс эмээж, бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн охид бусдаас тусламж авч, хамгаалуулж чаддаггүй гэсэн хариултыг судалгаанд оролцсон охид түгээмэл сонгосон байна. Иймд хүүхэд хамгааллын байгууллага, хувь хүмүүс хүүхдүүдийн мэдээллийн нууцыг хадгалах, нэр төрд халдахгүй байхад онцгой анхаарах хэрэгтэй байна.
- Үр дүн 12: Ойролцоогоор таван охин тутмын нэг нь хэрхэн тусламж авч, хэрхэн хамгаалуулах талаар мэддэггүйгээсээ шалтгаалж, охид бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн үедээ хэн нэгэнд хандаж, тусламж авч чаддаггүй гэж хариулсан байна. Тиймээс бэлгийн хүчирхийлэл, мөлжлөг, хүүхдийн эрхийн зөрчлийн талаар хэнд хандах, хэрхэн тусламж авч, хамгаалуулах боломжтой талаар мэдлэг, мэдээлэл олгох төрөл бүрийн ажлыг хийх зайлшгүй шаардлагатай.
- Үр дүн 13: Нийт 664 охидын 19% нь хүчирхийлэл, мөлжлөг үйлдэгчийн зүгээс дарамт, шахалт, дахин хүчирхийлэл, мөлжлөгт өртөхөөс айдаг шалтгаанаар охид шаардлагатай тусламж, үйлчилгээг авч чадахгүй хохирдог гэж хариулсан байна. Иймд хүүхэд хамгааллын үйлчилгээг зайлшгүй сайжруулах, гэмтэлд суурилсан хохирогч/даван туулагч төвтэй арга зүйг ашиглан хүүхдийн эрх зөрчигдөхөөс хамгаалж чаддаг тогтолцоог бүрдүүлэх нэн тэргүүний шаардлага тулсан байна.

## **Хүүхэд хамгааллын үйлчилгээ**

### **Хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тухайд:**

Энэхүү дэд бүлэгт нийт хамтарсан баг, ерөнхий боловсролын сургууль, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын 45 төлөөлөлтэй хийсэн ярилцлага, 5 удаагийн фокус бүлгийн ярилцлага, 664 охиныг хамруулсан асуулга, кейс судалгааны үр дүнд үндэслэн хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны өнөөгийн нөхцөл байдал, хэрэгжүүлж буй үйл ажиллагааны чанарыг үнэлсэн. Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чанарыг судалгаанд оролцогчдын 43.4 хувь нь сайн гэж үнэлсэн байна.

- Үр дүн 1: Хамтарсан баг нь охидын эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд иргэд, олон нийтэд зориулсан сургалт, сурталчилгааг зохион байгуулах, олон нийтийг татан оролцуулах ажлууд хангалтгүй, орхигдуулж байна.



- Үр дүн 2: ЕБС-удад охидын эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд хуулиар үүрэг хүлээсэн төрийн байгууллагуудын оролцоо сул, хамтран ажиллах байдал хангалтгүй байна. Үр дүн 3: Охидын эсрэг бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах хамтарсан багийн гишүүдийн 42.5 хувь, сургуулийн удирдлага, нийгмийн ажилтнуудын 36.6 хувь нь ур чадвараа сайн гэж үнэлсэн.
- Үр дүн 3: Хамтарсан багийн гишүүд болон сургуулийн удирдлага, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нар мэргэжил арга зүйн зөвлөгөөг хуулиар үүрэг хүлээсэн төрийн болон олон улсын байгууллагуудаас авч байна.
- Үр дүн 4: Хамтарсан багийн гишүүдийн 90 хувь нь сэтгэцийн гэмтэлд суурилсан, хохирогч төвтэй арга зүйн талаар ойлголт, мэдлэггүй байна.
- Үр дүн 5: Судалгаанд хамрагдсан хамтарсан багийн гишүүний 80 хувь нь, ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтнуудын 73 хувь нь урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд зохион байгуулагдаж буй арга хэмжээнүүдэд төсөв байхгүй байгааг баталсан.
- Үр дүн 6: Чанарын судалгаагаар охид бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртөх эрсдэлийг дараах хүчин зүйлүүд нэмэгдүүлж байна.
- Охидын бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн талаарх ойлголт, мэдлэг хангалтгүй байгаа нь бэлгийн хүчирхийллийн хохирогч болох эрсдэлийг нэмэгдүүлж байна.
  - Гэр бүлийн хэн нэгэн гишүүн нь архины хамааралтай байх нь охидыг бэлгийн хүчирхийлэлд өртөх эрсдэлийг нэмэгдүүлж байна.
  - Эцэг, эх болон асран хамгаалагчийн боловсролын түвшин доогуур, хараа хяналт сул байх тусам охид бэлгийн хүчирхийлэлд өртөхөд нөлөөлж байна.
  - Цахим орчны шүүлтүүргүй мэдээлэл нь охидыг бэлгийн хүчирхийлэлд өртөхөд нөлөөлж байна.

#### **Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний тухайд;**

Энэ бүлэгт Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10-р зүйлд заасан Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэгч төрийн болон төрийн бус байгууллагын голлох мэргэжилтнүүдээс хүүхдэд хамгааллын хариу үйлчилгээний чанар, хүртээмжийг тодорхойлов.

- Үр дүн 1: Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан хамтарсан багийн зохицуулалтыг хүчингүйд тооцсон нь хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх ажилд ухралт болжээ. Хамтарсан багийн зохицуулалтыг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд хамааруулан зөвхөн гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, тохиолдолд ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн байна. Үр дүн 2. Судалгаанд оролцогчдын хувьд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх үйлчилгээний тогтолцоо бүрдсэн хэдий ч хэрэгжилт хангалтгүй ба нэн шаардлагатай сэтгэл зүйн зөвлөгөө, заслын үйлчилгээг хохирогчид үзүүлж чадахгүй байна.
- Үр дүн 2: Кейс дээр ажиллахад салбар дундын хамтын ажиллагаа бэхжиж чадаагүй байна. Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, зөрчил, бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэрэгт өртсөн хүүхдийг хамгаалах нь төрийн байгууллагуудын үүрэг. Гэтэл эдгээр үүргийг хэрэгжүүлэхэд салбар дундын хамтын ажиллагаа хангалтгүйн зэрэгцээ зөвхөн нийгмийн ажилтны ажил үүрэг гэж ойлгох нь түгээмэл байна.
- Үр дүн 3: Сэтгэцийн гэмтэлд суурилсан, хохирогч төвтэй арга зүйг зөвхөн төрийн бус байгууллага тэр дундаа Хөөрхөн зүрх, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв ТББ нь бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэргийн хохирогч/даван туулагчдад үзүүлж буй үйлчилгээндээ нэвтрүүлж чадсан байна.

- Үр дүн 4: Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний нэг хэлбэр болох холбон зуучлах үйлчилгээ хангалтгүй, ялангуяа хохирогч хүүхдийг холбон зуучилж өөр байгууллагад шилжүүлсэн тохиолдолд кейсийн шийдвэрлэлт, үйл явцын талаарх эргэн мэдээлэл байдаггүй байна.
- Үр дүн 5: Кейс бүрд тухайлсан зардал байхгүй байгаа нь кейс дээр ажиллаж буй мэргэжилтнүүд тухайлбал, нийгмийн ажилтан, хамтарсан багийн гишүүд зардлыг өөрсдөөсөө гаргаж байна. Иймээс үйлчилгээ бүрийг үнэлэх үнэлгээ бий болгох хэрэгцээтэй байна.
- Үр дүн 6: Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэргийн хохирогчдод үзүүлж буй үйлчилгээ бүр харилцан адилгүй хүрч байна. Тухайлан энэ төрлийн гэмт хэргийн хохирогч/даван туулагчтай уулзахдаа анхан шатны мэдээллийг хэрхэн хүлээн авах, зөвлөгөө өгөх арга зүй, хохирогчоос асуух асуулт, нотлох баримтыг хэрхэн бүрдүүлэх зэргийг агуулсан заваар, тэрхүү зааврыг хэрэглэх чиглэлээр мэргэжилтнүүдийг сургах, мэдлэг ур чадварыг дээшлүүлэхэд анхааран ажиллах хэрэгтэй байна.

#### **КОВИД-19 цар тахлын нөлөөллийн тухайд:**

Тус бүлэгт гэр бүл, сургууль, олон нийтийн болон цахим орчны түвшинд КОВИД-19 цар тахлын сурагч охидын аюулгүй байдалд үзүүлсэн үр нөлөөг дурдав.

- Үр дүн 1: Нийт 664 сурагч охид хамрагдсаны 138 (20.7%) нь КОВИД-19 цар тахал нь гэр бүл, сургууль, олон нийтийн түвшинд өөрийн аюулгүй байдалд эрсдэл үүсгэсэн гэж тодорхойлсон байна. Энэхүү үзүүлэлт нь 5 охин тутмын 1 нь КОВИД-19 цар тахлын үед аливаа эрсдэлд орсон байж болзошгүй гэдгийг харуулж байна.
- Үр дүн 2: Оролцогч охидын хувьд хамгийн их эрсдэлтэй гэж тооцогдсон орчин нь сургууль (30.6%) болон амьдарч буй орчин (20.3%) байна. Учир нь сургуулийн орчинд КОВИД-19 цар тахал халдварлах өндөр магадлалтай гэж сурагч охид үзсэн бол эсрэгээрээ сургуулийн холбогдох мэргэжилтнүүд сургууль дээр цар тахлын хариу арга хэмжээг бүрэн авч халдварлах магадлалыг маш бага түвшинд авчирсан гэдгийг тодотгосон байна. Харин сургуулийн орчинд сурагч охид болон сургуулийн мэргэжилтнүүдийн санал нийлж буй эрсдэл нь хичээлийн хоцрогдол, нөхөрлөл болон харилцааны доголдол байна. Амьдарч буй орчны хувьд архины хамааралтай байдал эргэн тойрны хүрээлэлд нэмэгдсэнээс үүдсэн эрсдэл байсан бол цаашлаад зөвхөн КОВИД-19 цар тахалтай холбоогүйгээр байдаг эрсдэлүүд болох гудамжны гэрэлтүүлэг муу, зэрлэг буюу эзэнгүй нохой, муурууд тэнүүчлэх, гудамжинд бэртэж, гэмтэх гэх мэт эрсдэлүүд байсаар байна.
- Үр дүн 3: Харин гэр бүлийн орчинд өөрийгөө эрсдэлд орсон гэж тодорхойлсон охид 19.1%-ийг эзэлж байсан бол цахим орчинд эрсдэл үүссэн гэж тодорхойлсон охидын хувь 12.7% байна. Гэр бүлийн орчинд илүүтэй орлого багассанаас шалтгаалан сэтгэлзүйн болон бие махбодын хүчирхийлэл гарсан бол цахим орчинд бэлгийн дарамт үзүүлж буй хувийн захидал ирж байсан гэдгийг судалгаанд оролцогч сурагч охид онцолсон байна.
- Үр дүн 4: Судалгаанд оролцсон үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын үзэж буйгаар КОВИД-19 цар тахлын үед охидод учрах бэлгийн болох гэр бүлийн хүчирхийлэл нь илүү далд хэлбэр лүү шилжсэн ба нууцлагдмал болсон байна. Энэ нь хөл хорио тавигдсанаас хойш хариу үйлчилгээ үзүүлэгч байгууллага руу хандах хохирогч/даван туулагчийн тоо нэмэгддэг гэх баримтаар батлагдаж байна.

## САНАЛ ЗӨВЛӨМЖ

### Хүүхэд хамгаалал, хүчирхийлэл, мөлжлөгийн талаар охидын ойлголт, мэдлэгийн тухайд:

- Өөрийгөө болон үе тэнгийн найз нөхдөө эрсдэл, аюултай байдалд орохоос зайлсхийх, урьдчилан сэргийлэх арга зам, эрсдэлт нөхцөлд орсон тохиолдолд хэнд хандаж, хэрхэн тусламж авч болох талаар охидын ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх мэдээлэл, заавар зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах
- Охидын насны онцлог, амьдран сууж буй сууцны төрөл, хууль ёсны асран хамгаалагчтайгаа хамт амьдардаг эсэхээс хамаарч охид бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртөх магадлал ялгаатай байгааг үйл ажиллагаандаа анхаарч тусгах
- Цахим орчинд цацагдаж буй мэдээ, мэдээлэлд хяналт тавьж, эрсдэлтэй, сэжигтэй мэдээлэл түгээж, охидыг хүчирхийлэх, мөлжих оролдлого, үйлдлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх арга хэмжээ тогтмол явуулж байх
- Гудамж, талбай, олон нийтийн газарт гэрэлтүүлэг хийх, камер тавих, эрсдэл аюулд орвол цагдаа, хуулийн байгууллага, хүүхэд хамгааллын багт мэдээлэл дамжуулах сувгийг бий болгох зэрэг замаар охид аюулгүй зорчих орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарах
- Охидод үнэн, зөв мэдээллийг өгөхдөө олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээг ашиглах
- Хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэхдээ охидын нэр хүндэд халдахгүй, мэдээллийн нууцыг чанд хадгалах, охидыг дахин эрсдэлд оруулахгүй, сэтгэл зүйд сөргөөр нөлөөлөхгүй гэмтэлд суурилсан хохирогч/даван туулагч төвтэй арга зүйг ашиглан хүүхдийн эрх зөрчигдөхөөс хамгаалах, хохирогч хүүхдүүдийн сэтгэл зүйд дахин гэмтэл учруулахгүй, хохирогчид ээлтэй үйлчилгээ үзүүлж чаддаг үйлчилгээ үзүүлэх тогтолцоог бүрдүүлэх

### Хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тухайд:

- “MNB Гэр бүл” сувгаар охидын эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөг сэдвээр кейсэд суурилсан цуврал нэвтрүүлэг бэлтгэн хүргэх;
- Охидын эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгөөс урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн мэдээлэл, контент, подкаст, шторк зэргийг бэлтгэн иргэдийн идэвхтэй байдаг олон нийтийн сүлжээгээр хүргэх;
- Хамтарсан баг, сургуулийн хүүхэд хамгааллын баг, харьяа дүүрэг/аймгийн гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, олон улсын байгууллага, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, харилцан дэмжлэг туслалцаа үзүүлэх чиглэлд санал солилцох уулзалтуудыг зохион байгуулах, төлөвлөгөөг гаргах, хэрэгжүүлэх, туршлага солилцох;
- ЕБС-ийн Эрүүл мэндийн хичээлийн агуулгад Охидын эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх сэдвийг тусгах (үндсэн ойлголт, тохиолдол /кейс/ гэх мэт);
- Охидын эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх чиглэлд мэргэжлийн байгууллагууд (супервайзер) нь мэргэжил арга зүйн зөвлөгөөг хорооны болон сургуулийн нийгмийн ажилтнуудад өгдөг байх;
- Хамтарсан багийн үзүүлж буй үйлчилгээнд төсөв хэрхэн авах талаар мэдээллийг гишүүдэд өгөх, тэдний ажлын байрны тодорхойлолтод ажил үүргийг тусгах, хэрэгжилтийн үнэлж, урамшуулал олгох;

- ЕБС-ийн хүүхэд хамгааллын багийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд охидын эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх чиглэлд охидын насны онцлогийг харгалзсан нөлөөллийн үйл ажиллагааг тусгах (зургийн уралдаан, эсээ бичлэг, охидын клуб, контент бэлтгэх гэх мэт), холбогдох зардлыг тусгах;
- Охидын эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үе тэнгийн сургагч багш нарыг бэлтгэх;
- Хороодод архины хамааралтай, олон хүүхэдтэй өрх толгойлсон, амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур, хойд эцэгтэй, боловсролын түвшин доогуур, хэт алслагдсан, бүртгэлгүй өрх/гэр бүлийн судалгааг нарийвчлан гаргах, гэрээр айлчлан мэдээллийг өгөх;
- Өсвөр насны хүүхдийн (ялангуяа, охид) цахим хэрэглээг зүй зохистой ашиглах чиглэлээр заавар зөвлөгөөг мессеж хэлбэрээр хүргэх, зурагт хуудсыг сургуулийн орчинд байршуулах;

#### **Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний тухайд:**

- Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан Хамтарсан багийн зохицуулалтыг дахин хуульчлах, ингэхдээ хамтарсан багийн бүтэц зохион байгуулалт, гишүүдийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхой болгох
- Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээнд оролцогч талуудын үүрэг, хариуцлагыг тодорхой болгох замаар уялдаа холбоог сайжруулах
- Хариу үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой батлагдсан төсвийг тодорхой болгох, тэдгээрийн зарцуулалтыг нээлттэй болгох
- Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх үйлчилгээний стандартыг бий болгох
- Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэрэгт өртсөн хохирогч хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалах түр хамгаалан байрлуулах байрыг одоогийн байгаа НЦҮТ, ТХБ-д байрлуулдаг болгох
- Урт хугацааны нөхөн сэргээх үйлчилгээг бий болгох
- Үйлчилгээ үзүүлэгч төрийн болон төрийн бус байгууллагаас үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмж, кейс бүрдүүлэлт, хүний нөөц зэрэгт дахин үр дүнд суурилсан үнэлгээ хийх
- Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг үзүүлэхдээ сэтгэцийн гэмтэлд суурилсан, хохирогч төвтэй арга зүйг нэвтрүүлэх, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын мэргэжилтнүүдийг мэргэшүүлэн сургах

**ХАВСРАЛТ 1 ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭГ ҮЗҮҮЛЭХ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙГ МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ЖУРМЫН ХАРЬЦУУЛАЛТ**

**Хүснэгт 24.** 2016 болон 2021 оны Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх магадлан итгэмжлэх журмын харьцуулалт

Бүтэц	2016 оны Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/330 тоот тушаалын хавсралт Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх магадлан итгэмжлэх журам	2021 оны Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/210 тоот тушаалын хавсралт Хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэх хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх журам
Нийтлэг зүйл	Зорилго нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэгт заасны дагуу хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.	Зорилго нь Хүүхдийн эрхийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.7 дугаар заалт <sup>50</sup> , Хүүхдийн хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэг <sup>51</sup> , Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, эрүүл мэндийн сайдын хамтарсан 2017 оны А/84, А/54, А/130 дугаар тушаалын <sup>52</sup> дагуу хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг магадлан итгэмжлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
Зөвлөл	Орон тооны бус зөвлөл байна. Зөвлөл нь 7 хүний бүрэлдэхүүнтэй байна. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын тушаалаар батална. Зөвлөлийн үйл ажиллагааг зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга удирдан зохион байгуулна. Зөвлөл нь 7 эрх үүрэгтэй. Зөвлөл нь ээлжит ба ээлжит бус хуралтай байна.	Орон тооны бус зөвлөл байна. Зөвлөл нь 9 хүний бүрэлдэхүүнтэй байна. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг хүүхэд, гэр бүл хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. Зөвлөлийн үйл ажиллагааг зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга удирдан зохион байгуулна. Зөвлөл нь 6 эрх үүрэгтэй. Зөвлөл нь ээлжит ба ээлжит бус хуралтай байна.
Байгууллагад тавих шаардлага, бүрдүүлэх материал	Шалгуур үзүүлэлт нь байгууллагын хүүхэд хамгааллын үйлчилгээний чиглэл, хөрөнгө, санхүү, мэргэшсэн хүний нөөцтэй байна.	Шалгуур үзүүлэлт нь байгууллагын хүүхэд хамгааллын үйлчилгээний чиглэл, хөрөнгө, санхүү, мэргэшсэн хүний нөөцтэй байна.
Магадлан итгэмжлэл олгох, сунгах, хүчингүй болгох	Магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтийг 90 ба түүнээс дээш хувийг хангасан байгууллагад магадлан итгэмжлэлийг 2 жилийн хугацаанд олгоно.	Магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтийг 80 ба түүнээс дээш хувийг хангасан байгууллагад магадлан итгэмжлэлийг 2 жилийн хугацаанд олгоно.

50 Хүүхдийн эрхийн тухай хуулийн 13 дугаар зүйл буюу Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын үүрэг оролцоо 13.1.7 дах хэсэгт төрийн зарим чиг үүргийг гэрээлэн гүйцэтгэх этгээдийг магадлан итгэмжлэх

51 Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйл буюу Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ 10.1.4 дэх хэсэгт дэмжих, холбон зуучлах

52 Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, эрүүл мэндийн сайдын хамтарсан 2017 оны А/84, А/54, А/130 дугаар тушаал буюу хохирогчид үйлчилгээ үзүүлэх төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх журам. Тус журмын зорилго нь хохирогчид хуульд заасан үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж байгаа төрийн бус байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний технологи, чанарт хөндлөнгийн үнэлгээ хийж, дүгнэлт гарган магадлан итгэмжлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

<p>Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын эрх, үүрэг</p>	<p>Шинээр нэмэгдсэн.</p>	<p>Магадлан итгэмжлэгдэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах чиглэлээр 7 үүргийг хэрэгжүүлнэ. Хяналт, шинжилгээ, үнэлгээ</p>
<p>Хяналт, шинжилгээ, үнэлгээ</p>	<p>Хяналт, шинжилгээ, үнэлгээ</p>	<p>Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын эрх, үүрэгт хяналт, шинжилгээ, үнэлгээг хэсгийг багтаасан.</p>
<p>Хавсралт</p>	<p>Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх байгууллагын магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлт</p>	<p>Магадлан итгэмжлэгдсэн хуулийн этгээдийн үзүүлэх хүүхэд хамгааллын үйлчилгээний төрөл                  Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлт                  Төвлөрсөн халамж, асрамжийн үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлт                  Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлт                  Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх байгууллагыг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэх заавар                  Магадлан итгэмжлэгдсэн байгууллагад олгох гэрчилгээний загвар</p>

## ХАВСРАЛТ 2 ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ДАГАН ГАРСАН ЖУРМУУДЫГ ЖАГСААЛТ

Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль тогтоомжийн даган гарсан журмууд.

Д/Д	Тушаал
1	Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх журам (2021)
2	Хүүхдийг МУ-ын хилээр нэвтрүүлэхэд хяналт тавих журам (2020)
3	Боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх журам (2018)
4	Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг суурь боловсролын үйлчилгээнд тасралтгүй хамруулах журам (2018)
5	Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд эмнэлгийн болон сэтгэл зүй, заслын үйлчилгээ үзүүлэх журам (2018)
6	Хохирогчдод эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх журам (2018)
7	Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам (2017)
8	Хохирогчийг хүчирхийлэл үйлдэгчтэй уулзуулах уулзалтыг зохион байгуулах журам (2017)
9	Хохирогчид үйлчилгээ үзүүлэх төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх журам (2017)
10	Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журам (2017)
11	Хүүхдийн эрхийн мэдээллийн санг бүрдүүлж, ашиглах журам (2017)
12	Нөхцөл байдлын үнэлгээ хийх журам (2017)
13	Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр, журам (2017)
14	Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх санхүүжүүлэх журам (2017)
15	Сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлэх журам (2017)
16	Холбон зуучлах үйлчилгээний журам (2017)
17	Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх журам (2017)
18	Хохирогчид сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх журам
19	Гэр бүлийн хүчирхийллийн талаарх статистик мэдээлэл, тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх журам (2017)
20	Эрх хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөл журам (2017)
21	Гэр бүлийн хохирогчийн аюулгүй байдлыг хангах журам (2017)
22	Зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтын хөтөлбөрийг батлах тухай журам (2017)
23	Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх журам (2017)
24	Нэг цэгийн үйлчилгээний төвийн аюулгүй байдалд хяналт тавих тухай журам (2017)
25	Аюулын зэргийн үнэлгээ хийх журам
26	Хүүхдийн эрхийн ажилтны ажиллах журам (2016)
27	Урамшуулал олгох журам (2016)
28	Хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах үйлчилгээ үзүүлэх журам (2015)
29	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх журам (2013)
30	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид сэтгэцийн нөхөн сэргээх тусламж, үйлчилгээ үзүүлэх журам (2013)

### ХАВСРАЛТ 3 ТООН СУДАЛГААНД ХАМРАГДСАН СУРГУУЛЬ ТУС БҮРЭЭР ГАРСАН ҮР ДҮН

Судалгаанд хамрагдсан 664 охидын 92.6% нь хүүхэд бусдаар хамгаалуулах шаардлагатай, үлдсэн 7.4% нь шаардлагагүй гэж үзжээ. Хүүхэд хамгааллын талаар охидын ойлголт дүүрэг, байршлаас хамаарч ялгаатай эсэхийг шинжлэхэд Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн охидын 97.2%, 96.1% тус тус хүүхэд хамгаалуулах шаардлагатай гэж үзсэн Сонгинохайрхан дүүргийн нийт охидын 83.7% хүүхэд хамгаалуулах шаардлагатай гэж үзжээ. Баянгол, Баянзүрх дүүргүүдийн хувьд энэ үзүүлэлт харгалзан 94.7%, 93.4% байна.

**Хүснэгт 25.** Хүүхэд бусдаар хамгаалуулах шаардлагатай эсэх талаар охидын ойлголт

Дүүрэг	Сургууль, түүврийн тоо	Хамгаалуулах шаардлагатай гэж үзсэн охидын тоо, түүвэрт эзлэх хувь		Хамгаалуулах шаардлагагүй гэж үзсэн охидын тоо, түүвэрт эзлэх хувь	
		Тоо	Хувь	Тоо	Хувь
Баянзүрх	79-р сургууль, n=65	59	90.8	6	9.2
	148-р сургууль, n=66	62	93.9	4	6.1
	85-р сургууль, n=66	63	95.5	3	4.5
Сонгинохайрхан	9-р сургууль, n=45	36	80.0	9	20.0
	107-р сургууль, n=45	36	80.0	9	20.0
	121-р сургууль, n=45	41	91.1	4	8.9
Чингэлтэй	24-р сургууль, n=24	24	100.0	0	0.0
	117-р сургууль, n=24	23	95.8	1	4.2
	57-р сургууль, n=24	23	95.8	1	4.2
Баянгол	13-р сургууль, n=44	42	95.5	2	4.5
	19-р сургууль, n=44	41	93.2	3	6.8
	20-р сургууль, n=44	42	95.5	2	4.5
Сүхбаатар	16-р сургууль, n=43	41	95.3	2	4.7
	31-р сургууль, n=43	42	97.7	1	2.3
	3-р сургууль, n=42	40	95.2	2	4.8
<b>Нийт, n=664</b>		<b>615</b>	<b>92.6</b>	<b>49</b>	<b>7.4</b>


Өгөгдлийн эх сурвалж: Охидоос авсан нэр нуусан асуумж

Охидын үзэл, бодолд сургууль хамт олны нөлөө байгааг эсэхийг тогтоох зорилгоор Хүснэгт 25-д охидын хариултыг дүүрэг, сургуулиар дэлгэрэнгүй задалж харуулав. Сонгинохайрхан дүүргийн 9-р сургууль, 107-р сургуулиудын нийт охидын 20% нь хүүхэд бусдаар заавал хамгаалуулах шаардлагагүй гэж үзсэн байгаа нь бусдаасаа хэт өндөр үзүүлэлт байгаа тул анхаарал татаж байв.

Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн талаар охидын ойлголт, мэдлэгт насны ялгаа, анги, сургуулийн ялгаа байгаа эсэхийг шинжлэхэд дунд ангийн охидтой харьцуулахад ахлах ангийн охидын олонх нь бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн талаар мэддэг ба 21, 148, 13, 85, 31, 20 дугаар сургуулийн сурагчдын харьцангуй их хувь нь мэдэж байсан бол бусад сургуулийнх дунджаас доогуур байв. (Дүрс 27)




**Дүрс 27.** Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт ямар үйлдлийг оруулдгийг зөв мэддэг охидын эзлэх хувь



Өгөгдлийн эх сурвалж: Охидоос авсан нэр нуусан асуумж

Харин ойр дотнын найз, эгч, ах, дүү, хамаатан садан, танилууд дунд бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртөж байсан/өртөх дөхөж байсан гэж судалгаанд хамрагдсан нийт охидын 27.9% хариулсан бол 117, 57, 20, 148, 24, 13, 107 дугаар сургуулийн охидын 27.9%-аас илүү нь энэ хариултыг өгчээ. Энд Чингэлтэй дүүргийн 117, 57, 24-р сургуулиуд багтаж байгааг тодотгоё. Эдгээр сургуулийн охид бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртөх эрсдэл өндөр байж болох тул төслийн зүгээр эдгээр сургуулийн охид руу чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулбал тэднийг хамгаалах боломжтой.

**Дүрс 28.** Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртөж байсан гэх хариултыг өгсөн оролцогчид, сургуулиар





**Save the Children**

🏠 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Аризона төв, 4-р давхар

☎ +976-11-329365, +976-11-329371

📠 +976-11-329361

✉ [Mongolia.secretary@savethechildren.org](mailto:Mongolia.secretary@savethechildren.org)

🌐 [www.savethechildren.mn](http://www.savethechildren.mn)

📘 [Save the Children in Mongolia](#)

🐦 [Save the Children MN](#)

📺 [HairaarUlgerley](#)